# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2020 оны жилийн эцэс/

2021 оны 01 дүгээр сарын 14

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Монгол Улсын хууль, Улсын Их Хурал болон УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан шийдвэр, зүйл, заалтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2020 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим хуудсанд байршуулсан шийдвэр, зүйл, заалтыг 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн байдлаар тасалбар болгон Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 5 дугаар хавсралтын дагуу салбар тус бүрээр Геологи, эрдэс баялгийн, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн түүний нөөцийн, Уул уурхайн, Хүнд үйлдвэрийн, Нийтлэг асуудал гэсэн таван ангиллаар хэрэгжилтийг гаргуулав.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

2020 оны жилийн эцсийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан нийт 151 шийдвэрийн 247 зүйл, заалтыг дээр дурдсан агуулгаар ангилж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **90.3** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

- Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 17 шийдвэрийн 27 зүйл, заалтын хэрэгжилт - 94.1%;

- Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 22 шийдвэрийн 30 зүйл, заалтын хэрэгжилт - 94.0%;
- Уул уурхайн бодлогын 66 шийдвэрийн 105 зүйл, заалтын хэрэгжилт - 88.3%;
- Хүнд үйлдвэрийн бодлогын 8 шийдвэрийн 9 зүйл, заалтын хэрэгжилт - 77.7%;
- Нийтлэг асуудлын 38 шийдвэрийн 76 зүйл, заалтын хэрэгжилт - 91.3%-ийн тус тус биелэлттэй байна.

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

/2020 оны жилийн эцэс/

Хүснэгт-1

| Салбар, чиглэлийн нэр | Хяналтад авсан тоо | | Хэрэгжилтийн явц /хувиар/ | | | | | Үнэлгээ /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэр | зүйл заалт | 100% | 70% | 30% | 0% | үнэлээгүй | |
| НЭГ. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО (ГЭББ) | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 2 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| УИХ-ын тогтоол | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 10 | 20 | 16 | 3 | 1 | 0 | 0 | 92.0 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 4 | 4 | 4 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| ГЭББ-ын дүн | 17 | 27 | 23 | 3 | 1 | 0 | 0 | 94.1 |
| ХОЁР. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ТҮҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО (ГТГТББТНТБ) | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 1 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 70.0 |
| УИХ-ын тогтоол | 2 | 3 | 2 | 1 | 0 | 0 | 0 | 90.0 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 3 | 6 | 5 | 1 | 0 | 0 | 0 | 95.0 |
| Засгийн газрын тогтоол | 5 | 5 | 4 | 1 | 0 | 0 | 0 | 94.0 |
| Ерөнхий сайдын захирамж | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 10 | 14 | 12 | 2 | 0 | 0 | 0 | 95.7 |
| ГТГТББТНТБ-ын дүн | 22 | 30 | 24 | 6 | 0 | 0 | 0 | 94.0 |
| ГУРАВ. УУЛ УУРХАЙН БОДЛОГО (УУБ) | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 4 | 8 | 6 | 0 | 2 | 0 | 0 | 86.0 |
| УИХ-ын тогтоол | 6 | 17 | 9 | 3 | 4 | 0 | 1 | 76.8 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 3 | 3 | 2 | 1 | 0 | 0 | 0 | 90.0 |
| ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 25 | 38 | 22 | 5 | 2 | 0 | 9 | 90.0 |
| Ерөнхий сайдын захирамж | 3 | 3 | 0 | 2 | 0 | 0 | 1 | 70.0 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 24 | 35 | 25 | 5 | 0 | 0 | 5 | 95.0 |
| УУБ-ын дүн | 63 | 105 | 65 | 16 | 8 | 0 | 16 | 88.3 |
| ДӨРӨВ. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО (ХҮБ) | | | | | | | | |
| УИХ-ын тогтоол | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 2 | 3 | 1 | 1 | 1 | 0 | 0 | 66.6 |
| Ерөнхий сайдын захирамж | 2 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 3 | 3 | 1 | 1 | 1 | 0 | 0 | 66.6 |
| ХҮБ-ын дүн | 8 | 9 | 5 | 2 | 2 | 0 | 0 | 77.7 |
| ТАВ. НИЙТЛЭГ АСУУДАЛ | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Монгол Улсын хууль | 4 | 15 | 11 | 2 | 2 | 0 | 0 | 86.6 |
| УИХ-ын тогтоол | 2 | 4 | 3 | 1 | 0 | 0 | 0 | 92.5 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 3 | 3 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Ерөнхийлөгчийн зарлиг | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | 2 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 17 | 27 | 24 | 2 | 1 | 0 | 0 | 95.1 |
| Ерөнхий сайдын захирамж | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 6 | 8 | 8 | 0 | 0 | 0 | 0 | 100.0 |
| ЗГ-ын албан даалгавар | 2 | 15 | 7 | 5 | 2 | 0 | 1 | 79.2 |
| Нийтлэг асуудлын дүн | 38 | 76 | 60 | 10 | 5 | 0 | 1 | 91.3 |
| **НИЙТ ДҮН** | **151** | **247** | **177** | **37** | **16** | **0** | **17** | **90.3** |

Нийт 151 шийдвэрийн 247 зүйл, заалтын 17 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй бөгөөд хэрэгжилтийг дүгнэсэн 230 зүйл, заалтын 177 зүйл, заалт буюу 76.9% нь "бүрэн хэрэгжсэн" 100 хувийн биелэлттэй, 37 зүйл, заалт буюу 16.1% нь "хэрэгжих шатанд" 70 хувийн биелэлттэй, 16 зүйл, заалт буюу 6.9% нь "хэрэгжилт хангалтгүй" 30 хувийн биелэлттэй байна.

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ
/Хууль тогтоомжийн төрлөөр/

Хүснэгт-2

| | | Бүгд | Монгол Улсын хууль | Улсын Их Хурлын тогтоол | УИХ-ын Байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | Засгийн газрын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | Засгийн газрын албан даалгавар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хяналтад авагдсан шийдвэрийн тоо | | 151 | 11 | 12 | 9 | 1 | 3 | 59 | 7 | 47 | 2 |
| Заалтын тоо | | 247 | 26 | 26 | 12 | 1 | 3 | 93 | 7 | 64 | 15 |
| Үнээс | "бүрэн хэрэгжсэн" 100% | 177 | 19 | 16 | 10 | 1 | 3 | 67 | 4 | 50 | 7 |
| | "хэрэгжих шатанд" 70.0% | 37 | 3 | 5 | 2 | 0 | 0 | 12 | 2 | 8 | 5 |
| | "хэрэгжилт хангалтгүй" 30.0% | 16 | 4 | 4 | 0 | 0 | 0 | 5 | 0 | 1 | 2 |
| | "хэрэгжээгүй" 0% | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| | Үнэлгээ өгөөгүй | 17 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 9 | 1 | 5 | 1 |
| | **Үнэлгээ** | 90.3 | 85.8 | 82.8 | 95.0 | 100.0 | 100.0 | 91.5 | 90.0 | 94.7 | 79.3 |

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг төрлөөр нь авч үзвэл:

- Монгол Улсын 11 хуулийн 26 заалтын хэрэгжилт – 85.8%;
- Улсын Их Хурлын 12 тогтоолын 26 заалтын хэрэгжилт – 82.8%;
- УИХ-ын Байнгын хороны 9 тогтоолын 12 заалтын хэрэгжилт – 95.0%;
- Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 1 заалтын хэрэгжилт – 100.0%;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 шийдвэрийн 3 заалтын хэрэгжилт – 100.0%;
- Засгийн газрын 59 тогтоолын 93 заалтын хэрэгжилт – 91.5%;
- Ерөнхий сайдын 7 захирамжийн 7 заалтын хэрэгжилт – 90.0%;
- Засгийн газрын хуралдааны 47 тэмдэглэлийн 64 заалтын хэрэгжилт – 94.7%;
- Засгийн газрын 2 албан даалгаврын 15 заалтын хэрэгжилт – 79.3% байна.

**Дөрөв. Дүгнэлт.**

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан 151 шийдвэрийн 247 зүйл, заалтын 2020 оны жилийн эцсийн хэрэгжилтийг **90.3** хувийн биелэлттэй гэж дүгнэлээ.
2. Нийт 247 зүйл, заалтын 17 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй, 177 зүйл, заалт "бүрэн хэрэгжсэн" 100 хувийн биелэлттэй, 37 зүйл, заалт "хэрэгжих шатанд" 70 хувийн биелэлттэй, 16 зүйл, заалт "хэрэгжилт хангалтгүй" 30 хувийн биелэлттэй байна.
3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа боловч хэрэгжилтийг тайлагнахдаа ажлын гол үр дүнг товч тодорхой, баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнах шаардлагатай байна.
4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгтгэн боловсруулсан тайланг албажуулж, тогтоосон хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх шаардлагатай байна.

**Тав. Зөвлөмж.**

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тухайн зүйл, заалтыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад танилцуулахдаа хэрэгжилтийг хариуцан тайлагнах нэгжийг тодорхой цохуулж эзэнжүүлэх;
2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрээс өөрийн нэгжид хамаарах хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг нэгтгэн Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлэх үүргийг нэгжүүдэд эзэнжүүлж, уг үүргийг тухайн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тусгах;
3. Төрийн захиргааны удирдлагын газраас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг (дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж) нэгтгэн боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэгт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой байдлаар гаргуулах, холбогдох

тушаал, шийдвэр болон албан бичгүүдийн огноо, дугаарыг тодорхой бичүүлж хэвших;

4. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын нэгдүгээр хавсралтад зааснаар Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 01 дүгээр сарын 15, 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ЗГХЭГ-т хүргүүлдэг бөгөөд энэ хугацаанаас ажлын 5 хоногийн өмнө нэгтгэн боловсруулсан тайланг албажуулж Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлж байх.
5. "хэрэгжилт хангалтгүй" буюу 30 хувийн биелэлттэй дүгнэгдсэн, хэрэгжилтийн явц удаашралтай байгаа ажлуудыг эрчимжүүлэх, он удаан жил хэрэгжилт хангагдахгүй байгаа холбогдох шийдвэрийн зүйл, заалтыг хүчингүй болгуулах, дараагийн шийдвэрийг гаргуулах талаар тодорхой арга хэмжээг авч ажиллах.

Жич: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан, нэгтгэлийг хавсаргав.

---

Хянасан:

| | | |
|---|---|---|
| ХШҮДАГ-ын дарга | | Ц.Одхүү |

Үнэлгээ хийж, танилцуулга боловсруулсан:

| | | |
|---|---|---|
| ХШҮДАГ-ын ахлах шинжээч | | Х.Цэнд-Аюуш |
| Шинжээч | | Н.Цогтбаяр |
| Ахлах мэргэжилтэн | | Д.Батнайрамдал |
| Мэргэжилтэн | Ж.Энхсайхан | Ж.Энхсайхан |

# УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР БАТЛАГДСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

/2020 оны жилийн эцсийн байдлаар/

2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр

| № | *Шийдвэрийн дэс дугаар* | *Зүйл, заалтын дэс дугаар* | *Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга* | *Хэрэгжилтийн явц* | *Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)* | *Тасарсан болон удааширч байгаа шалтгаан* |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| САЛБАР ЧИГЛЭЛ: 1. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО | | | | | | |
| 1.а. Монгол Улсын хууль | | | | | | |
| 1 | 1 | 1 | **Ашигт малтмалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2006-07-08 Дугаар 2006.08.26** 16.6.. Улсын төсвийн хөрөнгөөр хийх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг хянаж хүлээн авах журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуульд нийцүүлэн батална. | Улсын төсвийн хөрөнгөөр хийх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох тухай журмыг УУС-ын 2015 оны 108 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж захиргааны хэм хэмжээ тогтоосон актын Улсын бүртгэлд 2015.07.01-ний өдрийн 3542 дугаарт бүртгүүлсэн. | 100% Журмыг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 2 | 2 | 2 | **Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай 2009-07-16 Дугаар 2009.07.16** 4.3.. Энэ хуулийн 4.1-д заасан газрын хилийн заагийг Засгийн газар тогтооно. (4.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац | Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 174 дүгээр тогтоолоор Ашигт малтмал хайх ашиглахыг хориглосон гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн заагийг хавсралтаар баталсан. Уг тогтоолд Засгийн газрын 2014 оны 260, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 130 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон. Засгийн газрын 2012 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 194 дугаар тогтоолоор Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагийг 1 дүгээр, Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийг 2 дугаар, Ойн сан бүхий газрын хилийн заагийг 3 | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно.) | дугаар хавсралтаар тус тус баталсан. Монгол улсын Засгийн газрын 2014 оны 260, Монгол улсын Засгийн газрын 2014 оны 281, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 130, 302, 2016 оны 155 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон.<br>Монгол улсын Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 120 дугаар тогтоол "Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээний загвар"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсан/<br>Монгол улсын Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 289 дүгээр тогтоолоор "Монгол улсын Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол улсын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн зааг-ийн солбицолд оруулах өөрчлөлтийг 1 дүгээр, уг тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Ойн сан бүхий газрын хилийн зааг"-ийн солбицолд оруулах өөрчлөлтийг 2 дугаар хавсралтаар баталсан. Мөн энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хилийн заагийг хэсэгчлэн тогтоох тухай" Монгол улсын Засгийн газрын 174 дүгээр тогтоол, "Хилийн заагийг тогтоох" тухай 194 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болгосон. | | |
| 1.б. Улсын Их Хурлын тогтоол | | | | | | |
| 3 | 1 | 1 | **Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (УИХ 2016.07.21-ний 12 дугаар тогтоолд "21.Үндэсний геологийн алба" гэж нэмсүгэй)<br>2020-01-30<br>Дугаар 2020 №12**<br>3.. Үндэсний геологийн албыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан байгуулж ажиллуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Үндэсний геологийн албыг Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолоор байгуулсан.<br>Тус тогтоолоор Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт зөвшөөрсөн. Үндэсний геологийн албаны орон тооны дээд хязгаарыг 68 байхаар тогтоосон боловч Засгийн газрын 38 дугаар тогтоолоор орон тооны дээд хязгаарыг 35 байхаар өөрчлөлт оруулсан. Өнөөдрийн байдлаар Үндэсний геологийн албаны үйл ажиллагаа жигд явагдаж байна. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 1.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | | |
| 1.г. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | | |
| 1.е. Засгийн газрын тогтоол | | | | | | |
| 4 | 1 | 1 | **Төслийн нэгж байгуулах тухай**<br>**2019-05-01**<br>**Дугаар 2019_176**<br>3.. Төслийн нэгжийг 5 жилийн хугацаатай ажиллуулж, үр дүнгийн тайланг тухайн жилийн 12 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс Монгол" ХХК (П.Ганхүү)-д даалгасугай. | Газрын ховор элементийн төслийн нэгж нь Ховор металл, газрын ховор элементийн чиглэлээр дараах судалгааг хийсэн байна. Үүнд:<br>- ГХЭ-ийн зах зээлийн болон технологийн мөн хөгжингүй орнуудын ховор, газрын ховор элементийн талаар баримталж байгаа бодлогын талаарх судалгаа,<br>- Монгол орны газрын ховор метал, газрын ховор элементийн ордууд, томоохон илрэлүүд, эрдэсжсэн цэгийн мэдээллийн санг бүрдүүлж, баяжуулалт хийж байна. Мэдээллийн санг Геологийн баримтын төвөөс авсан 14 тайлангийн материалаар нэмж, баяжуулсан байна. Монгол орны газрын ховор элемент болон ордуудын тухай мэдээлэл, Төслийн нэгжийн судалгааны мэдээллийг бэлтгэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлсэн. | 100% | |
| 5 | 2 | 2 | **Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2020-01-15**<br>**Дугаар 2020_17**<br>1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн иж бүрдлийг бүрэн хангуулах, цахим мэдээллийн төрөлжсөн санг 2020 оны I улиралд багтаан байгуулах, тус мэдээллийн санг холбогдох төрийн байгууллагууд ашиглах, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт тус тус даалгасугай. | Ашигт малтмал, газрын тосны газар нь Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд өөрийн олгосон Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хувийн хэргийг цахим болон бичгийн хэлбэрээр бүрдүүлэлт хийж байна. Хувийн хэргийн бүрдүүлэлтэнд агентлагийн Хяналт-шинжилгээ,үнэлгээ, статистикийн хэлтэс болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж ажиллаж байна.<br>Ашигт малтмал газрын тосны газрын даргын 2020 оны А/87 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулан дараах ажлуудыг хийж хэрэгжүүлж байна. Үүнд:<br>1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн иж бүрдэл хангасан, хангаагүй байгааг ялгаж ангилан судалгааг гаргасан.<br>2. Тусгай зөвшөөрлийн хувийн хэргүүдийг цахим хэлбэрт хөрвүүлэн оруулах ажлыг ХБНГерман Улсын БГР "Монгол улсын эрдэс баялгийн салбар дахь институцын болон боловсон хүчний чадавхийг хөгжүүлэх-II" төслийн дэмжлэгтэйгээр эхлүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 130 хувийн хэрэг материал цахим хэлбэрт оруулаад байна. 2021 онд бүрэн цахим хэлбэрт шилжихээр төлөвлөн ажиллаж байна.<br>3. 1997 оны ашигт малтмалын тухай хууль хэрэгжиж эхлэхээс өмнө олгогдсон 384 тусгай зөвшөөрлийн мэдээллийг УУККС-д нөхөн оруулсан.<br>Төрийн байгууллагатай мэдээлэл солилцох ажлын хүрээнд төрийн мэдээллийн нэгдсэн систем "ХУР", "ДАН", "ЦАХИМ-МОНГОЛ"-д нэгдэх бэлтгэл ажлыг хангуулах, цаасан мэдээллийг цахимжуулах, УУККС-ийг төрийн бусад байгууллагуудтай холбох сервис хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгохоос бусад цахим мэдээллийн төрөлжсөн санг шинээр | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна. УУККС-ийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сантай "ХУР" системээр дамжуулж мэдээлэл солилцох сервисийг хөгжүүлж байна. Байгаль орчин аялал жуулчлалын яамтай мэдээлэл солилцох, мэдээллийн санг холбох талаар тохиролцох, гэрээ хийх ажил хийгдэж байна. Цаашдаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон бусад төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох дундын сервисүүдийг бий болгохоор системийн хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна. Нэгдсэн бодлого зохицуулалтгүйгээс төрийн байгууллагуудын эрхэлдэг мэдээллийн сангуудын хөгжүүлэлт өөр өөр түвшинд байхаас гадна техникийн шийдлийн хувьд ч өөр өөр байгаа нь мэдээлэл солилцоход бэрхшээлүүд тулгарч байн | | |
| 6 | 2 | 3 | 5.. Ашигт малтмалын ордын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журам"-ыг шинэчлэн боловсруулж 2020 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт үүрэг болгосугай. | Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолоор Үндэсний геологийн алба байгуулагдсантай холбогдуулан Ашигт малтмал, газрын тосны газрын зарим чиг үүрэгт өөрчлөлт орсон. Үүнтэй холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас тус журмын төслийг боловсруулан ирүүлэх тухай албан бичгийг АМГТГ-т 2020 оны 01/2709 дугаар албан бичгээр хүргүүлсэн. АМГТГ-аас одоогийн байдлаар холбогдох тооцоо судалгааг 2020.11.30-ны өдрийн 1/5368 дугаар албан бичгээр ирүүлээд байна. | 30% | |
| 7 | 2 | 4 | 7.. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолоор баталсан "Алт-2" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланд хийсэн шинжилгээ, алтны хайгуул, олборлолтын талаар цаашид авах арга хэмжээний саналыг 2020 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | "Алт-2 Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтийг холбогдох салбар зөвлөл, төрийн байгууллага, нутгийн удирдлага болон бусад холбогдох этгээдээс авч нэгтгэсэн. Нэгтгэлд тулгуурлан хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтийн тайланг эцэслэн гаргаж, өмнө нь хэрэгжсэн Алт-1 хөтөлбөртэй харьцуулсан танилцуулга 2020.12.31-ний байдлаар бэлэн болсон.<br>Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дууссантай холбогдуулан үр дүнгийн тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 2021 оны I улиралд багтаан ЗГХЭГ-т танилцуулна. | 100% | |
| 8 | 2 | 5 | 9.. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохдоо байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгохдоо сонгон шалгаруулалтаар олгох зарчмаар зохион байгуулж байна. Сонгон шалгаруулалтыг нийтэд ил тод нээлттэй байлгах зорилгоор Ашигт малтмал, газрын тосны газрын цахим хуудаст сонгон | 100%<br><br>Тогтоолын дагуу | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай баримтад үндэслэх, тусгай зөвшөөрөл олгох ажиллагааг Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.15-д заасны дагуу олон нийтийн хяналтын дор явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т үүрэг болгосугай. | шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн зарыг байршуулан мэдээлж байна. Мөн агентлагийн цахим хуудаст талбайн тухай болон сонгон шалгаруулалтын тухай мэдээллийг тогтмол байршуулж байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгох 53 талбайг 6 багц болгон нийтэд цахимаар зарласан. Үүнээс шаардлага хангасан 27 талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгосон. Үүний үр дүнд улсын төсөвт 4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. | холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 9 | 2 | 6 | 10.. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төслийг зохих журмын дагуу яаралтай боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/249 дугаар тушаалаар эрдэс баялгийн багц хуулиудад /Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хуулиуд/ нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг нь Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хуулиудад хийсэн давхардал, зөрчил, хийдлийн судалгаанд үндэслэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болгох асуудлыг тусгасан багц хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар, түүний эрх зүйн байдлыг Ерөнхий сайдад танилцуулахад энэ асуудлыг танилцуулсан бөгөөд Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 58 дугаар тэмдэглэлээр асуудлыг боловсруулж, бэлтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх үүрэг өгөгдсөн байна. | 100% | |
| 10 | 3 | 7 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай**<br>**2020-04-29**<br>**Дугаар 2020_153**<br>2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрхийг олгохыг холбогдох аймгийн Засаг дарга нарт, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай. | Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг концессын гэрээгээр гүйцэтгэх "Макс роуд" ХХК-д тус замын бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын 54 талбайг хайх, ашиглах эрхийг холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан талбайтай давхцуулахгүй олгосон. Тус компани замын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай 1,549,000 м.куб элс, дайрга, хайргыг ашиглахаар уг тогтоолд тусгасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалыг бүрэн ашиглаж замын ажлыг дуусгасан байна. | 100%<br><br>УУХҮЯ-наас тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, замын бүтээн байгуулалтын ажил дууссан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11 | 3 | 8 | 4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | Тус компани замын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай 1,549,000 м.куб элс, дайрга, хайргыг ашиглахаар уг тогтоолд тусгасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалыг бүрэн ашиглаж замын ажлыг дуусгасан байна. | 100% | |
| 12 | 4 | 9 | **Ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох тухай 2020-06-01 Дугаар 2020_212**<br>2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан талбайд ашигт малтмал хайх эрхийг “Эрдэнэс Монгол” ХХК, түүний охин компани “Эрдэнэс алт ресурс” ХХК-д, 2 дугаар хавсралтад заасан талбайд ашигт малтмал хайх эрхийг “Эрдэнэс Монгол” ХХК, түүний охин компани “Эрдэнэс силвер ресурс” ХХК-д тус тус олгох арга хэмжээ авч, ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэнд үүрэг болгосугай. | Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумдын нутагт Эрдэнэс алт ресурс ХХК-д ХҮ-021669, 021668, 021667, 021666, Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай сумдын нутагт Эрдэнэс силвер ХХК-д ХҮ-021671, 021670 дугаарын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон. Талбайнууд нь улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй сэдэвчилсэн болон зураглалын ажлын үр дүнд тогтоогдсон хэтийн төлөв бүхий талбайнууд бөгөөд үнэт, өнгөт, ховор, холимог металлын хүдэржилттэй. Эрдэнэс алт ресурс ХХК, Эрдэнэс силвер ХХК нь эрх олгогдсон талбайд ашигт малтмал хайгуулын ажил гүйцэтгэх бэлтгэл ажил болон хайгуулын ажлуудыг хийж гүйцэтгэж байна. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.. | |
| 13 | 4 | 10 | 3. Ашигт малтмал хайх ажлыг гүйцэтгэх төрийн өмчит хуулийн этгээдүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүү нарт даалгасугай. | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн зураглал, сэдэвчилсэн судалгааны ажлуудын үр дүнд хэтийн төлөвтэй болох нь тогтоогдсон 6 талбайд ашигт малтмалын хайгуулын ХҮ-021666, ХҮ-021667, ХҮ-021668, ХҮ-021669, ХҮ-021670, ХҮ-021671 дугаар бүхий 6 тусгай зөвшөөрлийг төрийн өмчийн Эрдэнэс силвер ресурс ХХК болон Эрдэнэс алт ХХК-дад олгосон. Эрдэнэс силвер ресурс ХХК нь Үндэсний геологийн алба ба Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын хамтран хайгуулын ажлыг гүйцэтгэж байна. Үүний үр дүнд Овоот хяр нэртэй XV-021670 хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд алтны хүдрийн ордын хайгуулыг хийж дуусган нөөцийг тооцолсон байна. Овоот хяр ордын хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ордын нөөцийг ЭБМЗөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн B+C зэргээр 53,1 тонн алтны нөөцийг Улсын ашигт малтмалын нэгдсэн бүртгэлд бүргэсэн байна. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 14 | 5 | 11 | **Агентлаг байгуулах тухай**<br>**2020-06-23**<br>**Дугаар 2020_230**<br>3. Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталж мөрдүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгосугай. | Үндэсний геологийн албаны бүтцийн ерөнхий бүдүүвч, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай УУХҮСайдын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А-254 дугээр тушаалаар батлуулсан. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.. | |
| 15 | 5 | 12 | 9. Чиг үүрэг нь шилжиж байгаатай холбогдуулан Ашигт малтмал, газрын тосны газраас Үндэсний геологийн албанд чиг үүргийн хувьд шилжих орон тоог холбогдох төсөв, хөдлөх хөрөнгийн хамт шилжүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн), Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т тус тус даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн алба байгуулагдаж буйтай холбогдуулан батлагдсан орон тооны дээд хязгаарт багтаан шилжих орон тоо, холбогдох төсөв, хөрөнгийг хүлээлцүүлж, үйл ажиллагааг яаравчлан эхлүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг УУХҮСайдын 2020 оны 8 дугаар сарын 24-ны өдрийн А/217 дугаар батлуулсан. Үндэсний геологийн албанд Ашигт малтмал, газрын тосны газраас 35 мэргэжилтэний орон тоо, тэдгээрийн ажилд шаардлагатай дагалдах хэрэгсэл бүхий хөдлөх хөрөнгө, төсвийг шилжүүлсэн. Үндэсний геологийн алба нь Ашигт малтмал, газрын тосны II байранд үйл ажиллагаагаа явуулж байна. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.. | |
| 16 | 6 | 13 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай**<br>**2020-09-23**<br>**Дугаар 2020_114**<br>2. Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа Азийн авто замын АН-4 чиглэлийн Баян-Өлгий аймгийн Өлгий хотыг тойрон гарах авто зам, гүүрийн барилгын ажлын Багц-1, Багц-2, Багц-3 дугаар хэсэг буюу нийт 18.82 км хатуу хучилттай авто зам, 201.08 у/м төмөр бетон гүүрийн барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор | Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан МОН-3129 дугээр зээлийн гэрээний дагуу "Баруун бүсийн авто замын коридор хөрөнгө оруулалтын хөтөлбөр" Төсөл 2-ын хүрээнд 2020 онд АН-4 чиглэлийн Өлгий хотыг тойрон гарах 18.82 км авто зам, 201.08 у/м гүүрийн барилгын ажлыг 3 багц гэрээгээр гүйцэтгэхээр Зам, Тээврийн Хөгжлийн Яам нь авто замын барилгын гүйцэтгэгч "Эйч Кэ Би Интернейшнл Холдинг" ХХК, "Хотгор Зам" ХХК-тай 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр гэрээ байгуулж талбайн ажлыг эхлүүлэхэд бэлэн болсон. Гэрээ ёсоор Багц-1: 6.76 км авто зам, Багц-2: 201.08 у/м төмөрбетон гүүр, 260м зам, Багц-3: 11.8 км авто замын барилгын ажилд шаардлагатай ТТАМ-ыг ашиглах, хайх эрхийг аж ахуйн нэгжүүдэд олгосон. Замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын дээрх талбайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 17 | 7 | 14 | баталсугай. 2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Баян-Өлгий аймгийн Засаг дарга А.Гылымханд, авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгасугай. | | | |
| 17 | 6 | 14 | 4. Авто зам, гүүрийн барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд үүрэг болгосугай. 4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасугай. | Засгийн газрын тогтоолоор бүтээн байгуулалтын зорилгоор тусгай хэрэгцээнд авсан замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 18 | 7 | 15 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай 2020-10-07 Дугаар 2020_135**<br>2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Баян-Өлгий аймгийн Засаг | Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр"- Төсөл 2-ыг хэрэгжүүлэх МОН-3129 зээлийн гэрээг 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан байна. Тус зээлийн хөрөнгөөр Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км 4 багц хэсэг бүхий хатуу хучилттай авто замыг барьж байгуулахаар төлөвлөсөн ба Ховд-Өлгий чиглэлийн 3 багц хэсэг бүхий нийт 163.9 км хатуу хучилттай авто замыг 2016- 2019 онд барьж байгуулан ашиглалтад оруулсан. Үлдэж байгаа багцын 1-4 дүгээр хэсэг буюу Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг 2020-2022 онд барьж хэрэгжүүлэхээр холбогдох бэлтгэл ажлыг ханган ажилласан. Замын барилгын ажлын гүйцэтгэгчийг | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | дарга А.Гылымханд, авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгасугай. | сонгон шалгаруулах олон улсын тендерийг Азийн хөгжлийн банкны "Худалдан авах ажиллагааны журам"-ын дагуу зохион байгуулж, шалгарсан гүйцэтгэгч компани болох БНХАУ-ын "Лонгжиан Роуд энд Бридж" ХХК-тай зам барилгын ажлыг гүйцэтгэх гэрээг 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан байна. Уг тогтоолын дагуу ТТАМ хайх, ашиглах 7 талбайд эрх олгосон. Замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын дээрх талбайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | | |
| 19 | 7 | 16 | 3. Авто замын барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд үүрэг болгосугай.<br>4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасугай. | Засгийн газрын тогтоолоор бүтээн байгуулалтын зорилгоор тусгай хэрэгцээнд авсан замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын албайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | 70% | |
| 20 | 8 | 17 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай<br>2020-10-21<br>Дугаар 2020_154**<br>1. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Архангай аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасанд, авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, | Орхон гол-Их тамир чиглэлийн авто зам нь Архангай аймгийн Өгийнуур сумын нутаг дэвсгэрт байрлах Орхон голын гүүрнээс Батцэнгэл сум, цаашлаад Их тамир сумын чиглэлд баригдах Мянганы замын нэг хэсэг бөгөөд Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XIV.1.1.23-д тусгагдсан арга хэмжээ юм. Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн 63 км хатуу хучилттай авто зам, 220 у/м төмөрбетон гүүрийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгчээр "Хурдны зам" ХХК, хяналтын зөвлөхөөр "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ ажиллаж байна. Уг тогтоолын дагуу ТТАМ хайх, ашиглах 19 талбайд эрх олгосон. Замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын дээрх талбайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгасугай. | | | |
| 21 | 8 | 18 | 3. Авто зам, гүүрийн барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд үүрэг болгосугай. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасугай. | Засгийн газрын тогтоолоор бүтээн байгуулалтын зорилгоор тусгай хэрэгцээнд авсан замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын албайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 22 | 9 | 19 | **Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай**<br>**2020-11-04**<br>**Дугаар 2020_170**<br>2. Энэ тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж байгаа газар, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг нөхөх олговортойгоор эргүүлэн авах, эсхүл солиход гарах зардлын хэмжээ, нүүлгэн шилжүүлэх хугацааг тохиролцох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт даалгасугай. | Тогтоолын дагуу улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж байгаа газар, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг нөхөх олговортойгоор эргүүлэн авах, эсхүл солиход гарах зардлын хэмжээ, нүүлгэн шилжүүлэх хугацааг тохиролцох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэн ажиллаж байна. | 70% | |
| 23 | 10 | 20 | **Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай**<br>**2020-06-23**<br>**Дугаар 2020_231** | Тогтоолын нэмэлтээр түгээмэл тархацтай ашигт малтмалын тайлбайнуудыг ялган тогтоосон. Эдгээр талбайд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөлтнй холбоотой асуудлыг харъяалах аймгийн Засаг даргын тамгын газар зохицуулах арга хэмжээг авсан. | 100%<br><br>Тогтоолын дагуу | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2. Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 361 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол”-ын 42 дахь заалтын дараа хавсралтад дурдсан агуулгатай 43-61 дэх заалтыг нэмсүгэй. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан нарт даалгасугай. | Засгийн газрын тогтоолоор бүтээн байгуулалтын зорилгоор тусгай хэрэгцээнд авсан замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 1.ё. Ерөнхий сайдын захирамж | | | | | | |
| 1.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 24 | 1 | 1 | **2014 оны 10 дугаар сарын 4-ний өдөр 51 дүгээр тэмдэглэл 2014-10-04 Дугаар 2014_51** ХҮI. . Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг зөвшөөрч, холбогдох хуулийн дагуу үзэл баримтлалыг батлуулан хуулийн төслийг боловсруулж танилцуулах өргөтгөсөн ажлын хэсэг гарган ажиллуулахыг Уул уурхайн сайд Д.Ганхуягт даалгав. | Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн дагуу Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төслийн хувилбарыг боловсруулан ажилласан. Засгийн газрын бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх шаардлага гарч байсан.<br>Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/209 дугаар тушаалаар байгуулан ажиллуулсан: Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулга, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр оруулсан нэмэлт, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд 020 оны 07 дугаар сарын 07-ны өдөр оруулсан өөрчлөлт, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасаны дагуу хуулийн шинэчилсэн найруулгыг дахин шинэчилэн боловсруулах шаардлага зүй ёсоор гарсан. Үүнтэй уялдуулан Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаас "Салбарын хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах асуудлын хүрээнд Ашигт малтмалын тухай, | 100%<br><br>Энэхүү ажлыг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Газрын тосны тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж,... Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэ ... "-хийг үүрэг болгосон. Засгийн газраас өгсөн үүргийн дагуу Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгийг шинэчилэн байгуулах зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Зохион байгуулалтын хүрээнд холбогдох салбаруудын төлөөллийг хамруулахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 03/3013 албан тоотоор холбогдох төрийн болон төрийн бус, эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагад хандсан. | | |
| 25 | 2 | 2 | **2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр 2 дугаар тэмдэглэл 2019-01-09 Дугаар 2019_2** XXIII.5. . “Газрын ховор элемент” хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Газрын ховор элемент хөтөлбөрийн төслийг боловсруулсан. Боловсруулсан Хөтөлбөрийн төслийг танилцуулах, санал авах олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжийн төлөөлөл 32 хүн оролоцсон. Мөн хөтөлбөрийн төслийг яамны цахим хуудаст байршуулан санал авах ажиллагааг зохион байгууллаа. ирүүлсэн санал, зөвлөмжүүдэд үндэслэн нэмэлт өөрчлөлт оруулж боловсруулсан хөтөлбөрийн төсөлд яамдаас санал авахаар 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/1512 тоот албан бичгээр хүргүүлж,ирүүлсэн саналыг нэгтгэсэн байна. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2020 оны 06 сарын 17-ны өдрийн 01/1643 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.Гэвч Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчингүй болсонтой холбоотойгоор дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг буюу үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл байхгүй болсон байна. | 100% Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль 2020 онд батлагдсанаар дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг буюу үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл байхгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 26 | 3 | 3 | **2019 оны 7 дугаар сарын 9-ний өдөр 30 дугаар тэмдэглэл** | Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын 2020 оны 46 дугаар тогтоол, Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай УИХ-ын 2020оны | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **2019-07-09**<br>**Дугаар 2019_30**<br>XXI.3. 2. .Улсын тусгай хамгаалалтад авах газар нутагт нь ашигт малтмал хайх, ашиглах талбайтай давхцаж байгаа эсэхийг нягталж, шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжид заасан зохих арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав. | 47 дугаар тогтоолд хамрагдсан талбайнуудад Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай хуулийн дагуу олгогдсон тусгай зөвшөөрлийн талбайн давхцалыг шалгаж, тодруулан давхцалтай хэсгийг тогтоон холбогдох саналыг бэлтгэн Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн: | Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 27 | 4 | 4 | **2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 27 дүгээр тэмдэглэл**<br>**2020-04-27**<br>**Дугаар 2020_27**<br>4. . “Эрдэнэс Тавантолгой Майнинг” ХХК-д шилжүүлсэн Цанхийн зүүн хэсгийн MY-011943 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д буцаан шилжүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт; | MV-011943 тоот тусгай зөвшөөрлийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д буцаан шилжүүлснийг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2020 оны 6 дугаар сарын 11-ний 202 дугаар шийдвэрээр Кадастрын хэлтсийн мэдээллийн санд бүртгэсэн. | 100%<br><br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| | 17 | 27 | Геологи, эрдэс баялгийн бодлогын дундаж: 94.1 хувь | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| САЛБАР ЧИГЛЭЛ: 2. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО | | | | | | |
| 2.а. Монгол Улсын хууль | | | | | | |
| 28 | 1 | 1 | **ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ**<br>**/Шинэчилсэн найруулга/**<br>**2014-07-01**<br>**Дугаар 2014_06**<br>8.1.9. газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах; | Хуулийн тус заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд АМГТГ-аас ОХУ-ын “Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн орчуулгад тулгуурлан “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн төслийг боловсруулсан. Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан тус дүрмийн төслийг төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж, санал шүүмж авах хэлэлцүүлгийг Нээлттэй нийгэм форумтай хамтран | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2018.03.21-ний өдөр зохион байгуулсан ба дүрмийн төсөлтэй холбоотой тодорхой санал, шүүмжүүдийг ирүүлсэн. Энэхүү дүрмийн орчуулгын эх хувь болох ОХУ-ын "Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм 2018 онд шинэчлэгдсэн, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018.06.21-ний өдрийн 27-р тогтоолоор MNS ISO 45001:2018 "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо- Шаардлага, хэрэглэх заавар" стандартыг баталж, 2018.07.16-ны өдрөөс мөрдөж эхэлсэн, мөн манай улсын газрын тосны салбарт хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой олон улсын стандартууд, дүрэм, заавар, зааварчилгааг судлан нэгтгэх, дүрмийн төсөлд тусгах, уялдуулах зэрэг хүчин зүйлс, учир шалтгаантай холбоотойгоор тус дүрмийн төслийг орчин үеийн нөхцөл, байдалд нийцүүлэн боловсруулах хэрэгцээ, шаардлага тулгарч байна. Энэхүү үйл ажиллагаанд тодорхой хэмжээний төсөв, мөнгө шаардагдаж байгаа тул газрын тосны салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх олон улсын туршлага, стандарт, дүрэм журмын талаар судалгаа хийж, санал, дүгнэлт боловсруулах тухай эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгүүлэх төсвийг УУХҮ-ийн сайдын 2021 оны төсвийн багцад суулгаад байна. | | |
| 2.б. Улсын Их Хурлын тогтоол | | | | | | |
| 29 | 1 | 1 | **Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай**<br>**2012-01-05**<br>**Дугаар 2012 №01**<br>1.1.. 1.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай: 1.1. Газрын тос боловсруулах бага болон дунд хүчин чадлын үйлдвэрийг газрын тосны ордод түшиглэсэн байдлаар ойрын хугацаанд барьж байгуулах ажлыг түргэтгэх; | Уул уурхайн яам /хуучнаар/-наас газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг нийт 15 компанид олгосон хэдий ч тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын хөрөнгө санхүүжилт, техник технологи болон зарим тодорхойгүй шалтгааны улмаас дорвитой ажил хийгдээгүй. Нүүрс шингэрүүлж шатахуун үйлдвэрлэхээр тусгай зөвшөөрөл авсан "Багануур Энержи Корпорэйшн", "Гермон Газ", "МАК Си Ти Эл" компаниуд тодорхой ажлууд хийж эхэлсэн ч үйл ажиллагаа нь удаашран зогссон. Заримыг дурдвал "Дархан-Газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК жилд 2 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дархан хотод, "Хэт" ХХК жилд 120 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорнод аймагт, "М-Ойл" ХХК жилд 300 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Улаанбаатар хот, Рашаант өртөөнд, "Сүмбэр Ойл" ХХК-ийн жилд 100 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр, "М Ойл энд Жи" ХХК нь жилд 330 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорноговь аймгийн Зүүнбаянд тус тус барих төсөл ирүүлснийг яамны Эрдэс | 100%<br><br>УИХ-ын тогтоолын заалт нь бүрэн хэрэгжээгүй, цаг хугацааны ач холбогдолгүй болсон, ҮАБЗ, УИХ, ЗГ-аас гарсан шийдвэрүүдээр газрын тос боловсруулах үйлдвэр | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. ҮАБЗ-ийн 2014.03.17-ны өдрийн зөвлөмжөөр газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах зөвлөмж гарсан. Засгийн газрын 2017 оны "Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай" 59 дүгээр тогтоолоор Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хоорондын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Засгийн газрын 2017 оны "Төрийн өмчит компани байгуулах тухай" 92 дугаар тогтоолоор "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий 100 хувь төрийн өмчит Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХКомпани байгуулахаар шийдвэрлэсэн. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хооронд 2016.04.28-ны өдөр байгуулсан "Зээлийн ерөнхий хэлэлцээр"-ийг Монгол Улсын Их Хурал 2017.05.31-ний өдөр, мөн үйлдвэр барих төсөлд шаардлагатай нэмэлт санхүүжилт олгох асуудлаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хооронд 2019.10.09-ний өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Их Хурал 2019.12.20-ны өдөр тус тус соёрхон баталсан. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн менежментийн зөвлөх компани БНЭУ-ын Enjineers india limited (EIL) компанитай "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ"-г 2019 оны 5 дугаар сарын 13-нд байгуулсны дагуу үйлдвэр барих ерөнхий төлөвлөгөөг баталсан. Уг гэрээг МГТБҮ ТӨХХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор баталж "Газрын тос боловсруулах үйлдвэр барих 2019-2024 оны календарьчилсан төлөвлөгөө"-г 2019.05.28-ны өдөр нарийвчлан боловсруулан ажиллаж байна.<br>Төслийн менежментийн зөвлөх компанитай зөвшилцсөний үндсэн дээр үйлдвэрийн бүтээн байгуулалтыг дараах байдлаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Үүнд:<br>- EPC-I: технологийн бус, иргэний барилга байгууламж,<br>- EPC –II: лицензгүй технологийн байгууламж, дагалдах байгууламж,<br>- EPC – III: үйлдвэрийн цахилгаан станц,<br>- EPC – IV: лицензит технологийн байгууламж.<br>Үйлдвэрийн бүтээн байгуулалтын инженерчлэл, худалдан авалт, барилга-угсралтын ажлыг дөрвөн багцын эхний багц болох технологийн бус барилга байгууламжийн барилга-угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр БНЭУ-ын "JMC Projects India" компани шалгарч, 2020.10.13-ны өдөр гэрээг байгуулж, барилга угсралтын бэлтгэл ажлыг хангаад байна. | байгуулах төслийн зорилго үйл ажиллагаа өөрчлөгдсөн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 30 | 1 | 2 | 1.2.. Дотоодын түүхий эдийг боловсруулах үйлдвэр барих | Уул уурхайн яам /хуучнаар/-наас газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг нийт 15 компанид олгосон хэдий ч тусгай | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | санаачилга гаргаж байгаа аж ахуйн нэгжийг дэмжих замаар бензин, түлш шатахууныхаа хэрэгцээг хангах зорилтыг хэрэгжүүлэх; | зөвшөөрөл эзэмшигч компаниудын хөрөнгө санхүүжилт, техник технологи болон зарим тодорхойгүй шалтгааны улмаас дорвитой ажил хийгдээгүй. Нүүрс шингэрүүлж шатахуун үйлдвэрлэхээр тусгай зөвшөөрөл авсан "Багануур Энержи Корпорэйшн", "Гермон Газ", "МАК Си Ти Эл" компаниуд тодорхой ажлууд хийж эхэлсэн ч үйл ажиллагаа нь удааширч зогссон. Заримыг дурдвал "Дархан-Газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК жилд 2 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дархан хотод, "Хэт" ХХК жилд 120 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорнод аймагт, "М-Ойл" ХХК жилд 300 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Улаанбаатар хот, Рашаант өртөөнд, "Сүмбэр Ойл" ХХК-ийн жилд 100 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр, "М Ойл энд Жи" ХХК нь жилд 330 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорноговь аймгийн Зүүнбаянд тус тус барих төсөл ирүүлснийг яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. ҮАБЗ-ийн 2014.03.17-ны өдрийн 14/06 тоот зөвлөмжөөр газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах зөвлөмж гарсан. | УИХ-ын тогтоолын заалт нь бүрэн хэрэгжээгүй, цаг хугацааны ач холбогдолгүй болсон, ҮАБЗ, УИХ, ЗГ-аас гарсан шийдвэрүүдээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн зорилго үйл ажиллагаа өөрчлөгдсөн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 31 | 2 | 3 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2016-11-17 Дугаар 2016 №69**<br>2/2.. Түүхий нефтийн экспортоос нөөц ашигласны төлбөрийг тооцож авах, борлуулалтын орлогыг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх хуулийн шаардлагыг бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгах гэрээ хэлцлийг хийж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах. (2/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:) | Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь олборлосон түүхий тос, байгалийн хийн 5-15 хувь байна гэж хуульчилсан бөгөөд 2014 онд Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд болох Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт орших БХГ-97 талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хувьд газрын тосны нөөц ашигласны төлбөр 7%, Дорнод аймгийн Тамсагийн сав газарт орших Тосон-Уул-XIX талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд газрын тосны нөөц ашигласны төлбөрийг шууд авахаар дурьдаагүй хэдий ч Монгол Улсад ногдох хувь хэмжээнд нөөц ашигласны төлбөрийг хамаарахаар гэрээнд тусгасан байдаг, харин Тамсаг-XXI талбайн хувьд газрын тосны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 7,5%-иар гэрээнд тусгаж өгсний дагуу экспортолж буй газрын тосноос нөөц ашигласны төлбөрийг гэрээнд заасны дагуу авч Улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/12-р тушаалаар байгуулагдсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх хэлэлцээр хийх үүрэг бүхий ажлын хэсэг Гэрээлэгч компаниудтай хэлэлцээр хийж, | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | холбогдох арга хэмжээг авч ажилласан бөгөөд хайгуулын үе шатанд хэрэгжиж буй бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг бүрэн шинэчилсэн. Харин газрын тосны ашиглалт, экспортын үйл ажиллагаа явуулж буй Гэрээлэгч компаниудтай удаа дараа хэлэлцээр хийсэн боловч Гэрээлэгч тал өнөөг хүртэл хөрөнгө оруулалтаа нөхөж аваагүй алдагдалтай ажиллаж байгаагаас гадна 2014 онд батлагдсан Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын холбогдох заалтууд нь хууль батлагдахаас өмнө БХГ байгуулсан Гэрээлэгчийн эрх ашиг, эдийн засгийн нөхцөл байдалд ноцтой хохирол учруулахаар байгаа тул нэгэнт байгуулсан гэрээг өөрчлөхгүй байх зарчмын байр суурийг тухай бүр илэрхийлсээр байна. | | |
| 2.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | | |
| 32 | 1 | 1 | **Валютын ханш, газрын тосны бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах талаар цаашид авах арга хэмжээний тухай**<br>**2012-02-08**<br>**Дугаар 2012 №10 ЭЗБХ**<br>1.8.. Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдийн тоог ОХУ-ын болон бусад нийлүүлэгч компанийн тооноос хамааруулан цөөлөх, газрын тосны бөөний худалдаа эрхлэгч томоохон аж ахуй нэгжүүдээс уул уурхайн салбарын томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй шатахуунд онцгой албан татварын болон аливаа татварын хөнгөлөлтийг үзүүлэхгүй байх, газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаанд үнийг хямд, тогтвортой байлгах зорилгоор өрсөлдөөнийг дэмжих бусад бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр ГТБ-нийг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдааны үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр тусгасан. Мөн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т импортлогч нь "газрын тосны бүтээгдэхүүнийг нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр импортлох" үүрэг хүлээхээр хуульчилсан. Түүнчлэн УУХҮС-ийн 2018 оны 01 дүгээр 12-ны өдрийн А/08 дугаар тушаалаар батлагдсан "Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам"-д ГТБ импортлох тусгай зөвшөөрлийг бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдэд олгох нэмэлт зохицуулалт оруулсан. Түүнчлэн Онцгой албан татварын тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу тус хуулийн 6.2-т заасан хэмжээгээр автобензин, дизелийн түлшийг импортлох үед онцгой албан татварыг авч байгаа тул уул уурхайн салбарын томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй шатахуунд онцгой албан татварын болон бусад аливаа татварын хөнгөлөлтийг үзүүлэхгүй болно. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 33 | 2 | 2 | **Чиглэл өгөх тухай**<br>**2017-06-30**<br>**Дугаар 2017 №07 ЭЗБХ**<br>1.1/. Зээлийн ерөнхий хэлэлцээрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн явц, хэрэгжилтийн талаар хагас жил тутам | ТӨБЗГ-ын 2017.04.04-ний өдрийн 108 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” компанийг байгуулан ажиллаж байна. БНЭУ-ын Эксим банкны санал болгосон компаниудын дунд "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах компанийг | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Байнгын хороонд мэдээлэл хийж байх; | сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017.05.26-ны өдрийн Б/208 тоот тушаалаар байгуулагдсан "Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, хэлэлцээр хийх" ажлын хэсэг 2017 оны 06 дугаар сарын 06-ний өдөр "Газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах шугам хоолой"-н нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулахаар шалгарсан БНЭУ-ын Зөвлөх болох EIL компанийн төлөөлөгч нартай эхний уулзалтыг зохион байгуулсан бөгөөд Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний төсөл болон холбогдох асуудлуудаар хэлэлцээр хийж байна. Улмаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэхтхэг Улсын Экспорт-импорт банк хооронддын 1 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн зориулалтад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг УИХ-ын байнгын хороодоор зөвшилцсөний дараа ажлын журмаар Засгийн газрын зүгээс шийдвэр гаргахаар ЗГ тэмдэглэл гарсан. ЗГ-ын тэмдэглэлийн дагуу уг асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн, Аюулгүй байдлын Байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжүүлсэн. Монгол Улсын Засгийн газарт БНЭУ-ын Экспорт-Импорт банкаар дамжуулан олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэхийг Байнгын хороод дэмжсэний дагуу хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2017.05.31-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн соёрхон батлуулаад байна. | хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 34 | 2 | 3 | 1.2/. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт-Импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн нарийвчилсан техник эдийн засгийн үнэлгээ, зээлийн эдийн засгийн үр нөлөө, эргэн төлөгдөх нөхцөл болон төслийн хэрэгжилтийн явцын талаар хэрэгжилтийг хангаж ажиллаж буй холбогдох яамд, байгууллагууд Байнгын хорооны хуралдаанд танилцуулах. | ЗГ-ын тэмдэглэлийн дагуу уг асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн, Аюулгүй байдлын Байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжүүлсэн. Монгол Улсын Засгийн газарт БНЭУ-ын Экспорт-Импорт банкаар дамжуулан олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэхийг Байнгын хороод дэмжсэний дагуу хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2017.05.31-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн соёрхон батлуулаад байна. | 100%<br><br>Зээлийн хэлэлцээрийг соёрхон баталсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 35 | 3 | 4 | **Чиглэл өгөх тухай 2018-10-30 Дугаар 2018 №32 ЭЗБХ** | Тус заалтын хэрэгжилтийг хангах, автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан, боомтоос хамааруулан ялгавартай тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд манай | 100%<br><br>Тогтоолын дагуу УУХҮЯ- | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2.2/. Газрын тосны зарим төрлийн бэлэн болон завсрын бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах, экологийн ангилал, импортолж байгаа боомтоос хамааруулан автобензин, дизелийн түлшний албан татварыг ялгавартай тогтоох, шатахууны үнийн огцом хэлбэлзлийг онцгой албан татварын хувь хэмжээгээр тухай бүр шуурхай зохицуулах зэрэг асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | яамнаас Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2017 оны 12 дугаар сар, 2018 оны 12 дугаар сар, 2019 оны 03 дугаар сар, 2020 оны 11 дүгээр саруудад Сангийн яаманд хүргүүлсэн. СЯ-аас 2021.01.05-ны өдрийн 4-2/04 тоотоор ирүүлсэн хариунд уг асуудал нь Засгийн газрын тухай хуулийн 20.4.6-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудалд хамаарахыг анхааруулж, уг саналыг цар тахалын эдийн засгийн үед авч үзэх боломжгүй хариуг ирүүлсэн. | наас шалтгаалах холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 36 | 3 | 5 | 2.4/. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн олон талт эх үүсвэртэй байх бодлого баримтлах, Гашуунсухайт-Ганц модны боомтоор шатахуун импортлох ажлыг эхлүүлэх. | Манай улс БНХАУ-аас бага хэмжээний газрын тосны бүтээгдэхүүнийг зөвхөн Замын-Үүд боомтоор импортолж байгаа ба 2018 онд 52.6 мянган тонн, 2019 онд 53.58 мянган тонн, 2020 онд 75.0 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн тус тус импортолсон байна.<br>БНХАУ-ын нийлүүлэгч "Чайна Ойл" компани болон Монголын шатахуун импортлогч компаниуд 2016 оноос Ганц Мод-Гашуун сухайт боомтоор шатахуун нийлүүлэх, импортлох талаар хэлэлцээр хийн, бэлтгэл ажлыг хангах явцад Хятадын талын холбогдох байгууллагаас Ганц модны боомт дээр аюултай бүтээгдэхүүн тээвэрлэх автомашины тусгай зогсоол, гарах терминал байгуулах шаардлагатай гэсэн тул түр хугацаагаар хойшлуулаад байсан.<br>БНХАУ-ын "Чайна Ойл" компаниас 2018 оны 07 дугаар сард Гашуун сухайт боомтоор газрын тосны бүтээгдэхүүн Монгол Улс руу экспортлох асуудал нааштайгаар шийдвэрлэгдэж байгааг мэдэгдсэн. Үүнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Шивээ хүрэнгийн боомтоор автоцистернээр шатахуун импортлоход тухайн боомтуудын хил, гаалийн нөхцөл байдал, тусгай терминал байгуулах шаардлагатай эсэх, тээвэрлэлтийн асуудлаар ЗТАЖЯ, ГЕГ, Автотээврийн үндэсний төв зэрэг газруудаас тодруулга мэдээлэл авсан. Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай хоёр улсын Зам, тээврийн яам хоорондын протоколд улс хоорондын аюултай ачаа тээвэрлэлтэд гүйцэтгэхэд "F" төрлийн онцгой зөвшөөрөл авахаар заасан ба тус зөвшөөрлийг Автотээврийн үндэсний төвөөс олгож байгаа талаар ЗТХЯ-наас, Гашуунсухайт боомтоор шатахуун импортлоход гаалийн байгууллагын хүний нөөц, гаалийн хяналтын бүсийн нөхцөл шаардлага, эрх зүйн зохицуулалтын хувьд хүндрэл гарахгүй, бүх төрлийн шатахууны гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардлагатай гаалийн лаборатори одоогоор байхгүй байгаа болоч 2019 оны төсөвт тус боомтод гаалийн лаборатори байгуулахаар | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тусгагдсан талаар ГЕГ-аас мэдэгдсэн. БНХАУ-ын Чайна ойл компанитай 2019 оны 04 дүгээр сар, 07 дугаар сaруудад уулзалт, хэлэлцээр хийж холбогдох асуудлаар санал солилцсон ба шатахуун импортлох нөхцөлийг бүрдүүлэх асуудлаар 2 талын хил, гааль, тээвэр хариуцсан байгууллагуудтай хэлэлцэх, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх, зөвшөөрөл авах ажлуудыг хийж гүйцэтгэхээр тохиролцсон. М-Ойл компани болон Чайна ойл компаниудын хооронд байгуулсан шатахуун худалдах, худалдан авах гэрээний хүрээнд хятадын талын шатахуун тээврийн 4 автоцистернд хоёр талын тээврийн байгууллагаас холбогдох зөвшөөрлийг аваад байсан боловч Хятадын талын боомтын аюултай ачаанд хяналт хийх талбайтай холбоотойгоор тус асуудал хойшлоод байна. | | |
| 37 | 3 | 6 | 3.. Тогтоолын хэрэгжилтийг 2019 оны нэгдүгээр улирал багтаан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд даалгасугай. | Автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан, боомтоос хамааруулан ялгавартай тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2019.09.07-ны өдрийн 01/2545 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 2.г. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |
| 2.д. ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | | |
| 2.е. Засгийн газрын тогтоол | | | | | | |
| 38 | 1 | 1 | **Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2018-10-24**<br>**Дугаар 2018_323**<br>3.. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор найдвартай хангах асуудлаар холбогдох байгууллага, компанитай уулзалт, хэлэлцээр хийж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын | Газрын тосны тухай хуулийн 7.1.6 дахь заалтын дагуу Засгийн газар нь Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр барьсан тохиолдолд гэрээлэгчид ногдох газрын тос болон өртөгт газрын тосыг тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр худалдаж авах давуу эрхийг эдлэх эрхтэй бөгөөд мөн хуулийн 11.2.4. дэх заалтын дагуу гэрээлэгч нь газрын тосыг нийлүүлэх үүрэгтэй. Мөн Тосон-Уул XIX, Тамсаг XXI, БХГ-97 талбайд хэрэгжиж буй БХГ-нд хуулийн дээрх заалтыг гэрээний салшгүй хэсэг болгож протоколоор тохирсон. Үүний хүрээнд газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор найдвартай, тасралтгүй хангах асуудлыг шийдвэрлэх талаар санал солилцох уулзалтыг 2020.06.04, 2020.10.13-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн холбогдох албан тушаалтнуудтай хамтран Петро Чайна Дачин Тамсаг компаний удирдлагатай уулзалт зохион байгуулсан. Петро | 100%<br><br>Хууль болон БХГ-нд тусгагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | дарга Х.Хэрлэн нарт үүрэг болгосугай. | Чайна Дачин Тамсаг компаний зүгээс Газрын тосны тухай хууль, БХГ-ний үүргээ биелүүлэн, боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах тал дээр өөрийн компаний хувь нэмрийг оруулж ажиллахаа илэрхийлсэн байна. | | |
| 39 | 2 | 2 | **Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх үүргийг шилжүүлэх тухай**<br>**2019-12-18**<br>**Дугаар 2019_452**<br>2.. Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргийг шилжүүлэх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга (Х.Хэрлэн) нарт даалгасугай. | Газрын тосны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, ЗГ-ын 2019 оны 452 дугаар тогтоол, газрын тосны хайгуулын Баянтүмэн-XVII талбайд байгуулсан БХГ-ний 5 дугаар зүйлийн 5.1-д заасныг тус тус үндэслэн БХГ-ний эрх үүрэг шилжүүлэх тухай гурван талт гэрээг АМГТГ, Магнай трейд ХХК, Түмэн Ойл ХХК хооронд 2020.02.21-ний өдөр байгуулснаар БХГ-ний эрх үүрэг Түмэн ойл ХХК-д шилжсэн болно. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 40 | 3 | 3 | **Шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2020-01-08**<br>**Дугаар 2020_14**<br>2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан охин компанийг байгуулах, түүнд хөрөнгө оруулах, бүтээгдэхүүн нийлүүлэх сонирхол илэрхийлсэн гадаадын хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулж, дүнг 2020 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | 2. Засгийн газрын 2020.01.08-ны өдрийн 14 дүгээр тогтоол, мөн өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлийн дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.04.21-ний өдрийн А/81 тушаалыг үндэслэн төрийн өмчит "Эрчис ойл" ХХК-ийг үүсгэн байгуулж ОХУ-ын хөрөнгө оруулагчтай хэлэлцээрийг эхлүүлээд байна. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.03.26-ны өдрийн А/56 тоот тушаалаар "Эрчис Ойл" ХХК-д хэрхэн хөрөнгө оруулах, хамтран ажиллах, гэрээ хэлэлцээ хийх саналыг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ЗТХЯ-ны дэд сайд Ж. Бат-Эрдэнэ, Буянт-Ухаа олон улсын нисэх онгоцны буудлын дарга Н.Мягмарсүрэн, ИНЕГ-ийн харьяа Газрын үйлчилгээний албаны холбогдох хүмүүстэй уулзалтуудыг зохион байгуулж гэрээнд тусгах саналуудыг нэгтгэсэн. Ковид 19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор хөрөнгө оруулагч талтай хийх уулзалт, хэлэлцээрүүд хойшлоод байна. | 70% | |
| 41 | 4 | 4 | **Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх тухай**<br>**2020-10-07**<br>**Дугаар 2020_136**<br>2. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 2021 онд бүрдүүлэх нөөц, бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг хавсралт ёсоор батлаcугай.<br>2. Энэ тогтоолын хавсралтад заасан | Засгийн газрын 2020.10.07-ны өдрийн хуралдаанаар 2021 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх асуудлыг хэлэлцүүлсэн ба Засгийн газрын 2020.10.07-ны өдрийн 136 дугаар тогтоолоор 2021 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжийн нэр, төрөл, тоо хэмжээг тогтоон баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд хавсралтад орсон аж ахуйн нэгжүүдтэй компанийн нөөц бүрдүүлэх гэрээг 2021.01.31-ний өдрийн дотор байгуулах чиглэлийг АМГТГ-т хүргүүлсэн ба тус газраас гэрээ байгуулах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг 2021 оны 1 дүгээр сарын 31-ний дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт даалгасугай. | | ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 42 | 5 | 5 | **Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг шилжүүлэх тухай 2020-10-14 Дугаар 2020_150** 2. Уламжлалт бус газрын тосны хайгуулын "Тавантолгой-XXXIII" талбайд нүүрсний давхаргын метан хийтэй холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар Ашигт малтмал, газрын тосны газар болон "Эрдэнэс метан" ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн хүлээсэн эрх, үүргийг "Метан газ ресурс" ХХК-д бүхлээр нь шилжүүлэхийг зөвшөөрсүгэй. 2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт даалгасугай. | БХГ-ний эрх, үүргийг хамтарсан компани болох "Метан Газ Ресурс" ХХК-ийн нэр дээр шилжүүлэхээр АМГТГ, "Эрдэнэс Метан" ХХК болон "Метан Газ Ресурс" ХХК нар Гурван талт гэрээ байгуулах ба эрх, үүрэг шилжүүлэгч ба эрх, үүрэг хүлээн авагч талууд гарын үсэг зурж АМГТГ-т 2020.12.11-ний өдөр хүргүүлсэн. Гэрээлэгч нь Газрын тосны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7-д заасан 20,000 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг улсын төсөвт төлнө. Үүнээс гадна БХГ-ний эрх, үүргийг шилжүүлснээр "Эрдэнэс метан" ХХК нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 10.2-т заасан "төрийн байгууллагаас олгосон эрх борлуулсан, шилжүүлсний орлого"-д ногдох татвар төлнө. Ногдох татварын хэмжээг хянуулан тогтоолгох зорилгоор холбогдох хууль, журмын дагуу татварын тооцооллыг хийж гүйцэтгэн Татварын ерөнхий газарт хүргүүлсэн.<br>Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, БХГ-ний эрх, үүргийг хамтарсан компани болох "Метан Газ Ресурс" ХХК-ийн нэр дээр шилжүүлсэн. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 2.ё. Ерөнхий сайдын захирамж | | | | | |
| 43 | 1 | 1 | **Ажлын хэсэг байгуулах тухай 2020-08-20 Дугаар 2020_32** 2. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шуурхай | Шадар сайдын 2020.09.01-ний өдрийн 94 дүгээр тушаалаар уг Ажлын хэсгийн хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталсантай холбогдуулан УУХҮС-ын А-246 дугаар тушаалаар дээрх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар гаргаж 2020 оны 12 сард Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | шийдвэрлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай. 2. Бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулж, явцыг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Я.Содбаатар)-т даалгасугай. | | тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 2.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 44 | 1 | 1 | **2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл 2018-07-04 Дугаар 2018_29** XIY.. Газрын тосны хайгуулын Баянтүмэн-XVII талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар Газрын тосны газар (хуучин нэрээр) болон “Магнай трейд” ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг “Магнай трейд” ХХК-аас “Эм Ти ПЛО” ХХК-д бүхэлд нь шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс чиглэл авсны үндсэн дээр дахин хэлэлцүүлэхээр хойшлуулав. Үүнтэй холбогдуулан газрын тосны салбарт байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, ашигт малтмалын салбарт олгосон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан боловч үйл ажиллагаа явуулалгүй | Газрын тосны газар (хуучин нэрээр) болон “Магнай трейд” ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг “Магнай трейд” ХХК-аас “Эм Ти ПЛО” ХХК-д бүхэлд нь шилжүүлэх талаар хөрөнгө оруулагч компани болон гэрээлэгч компанийн хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний хугацаа дууссан гэж үзээд уг асуудлыг цаашид хэлэлцүүлэх шаардлаггүй гэж үзэж дуусгавар болгосон.<br>Газрын тосны салбарт байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийн талаарх танилцуулгыг гэрээ байгуулсан талбай бүрээр бэлтгэн ЗГ-ын 2018.10.03-ны өдрийн хуралдаанд танилцуулж 41 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. | 100%<br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тусгай зөвшөөрөл (гэрчилгээ)-ийг бусдад шилжүүлж (худалдаж) байгаа асуудлыг шийдвэрлэх болон цаашид авах арга хэмжээний талаар тодорхой санал боловсруулан зохих журмын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | | | |
| 45 | 2 | 2 | **2018 оны 10 дугаар сарын 24-ний өдөр 44 дүгээр тэмдэглэл 2018-10-24 Дугаар 2018_44** XXYI.7. . 1. ОХУ-ын Роснефть компанитай хийж байгаа хамтын ажиллагааны хэлэлцээг үргэлжлүүлж, газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөлд хамтран оролцох нөхцөл боломжийг судлан танилцуулах; 2. Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрээс Тосон-Уул орд хүртэл газрын тос дамжуулах хоолойн техник, технологи болон санхүүжүүлтийн асуудлыг судлан танилцуулах; 3. Дотоодын зах зээлд нийлүүлэх автобензин, дизелийн түлшний нөөц, хангамжийг нэмэгдүүлэх, тогтворжуулах зорилгоор автобензин, дизелийн түлшний нөөцийн агуулахуудын багтаамжийг нэмэгдүүлэх, гаалийн баталгаат агуулах байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх; 4. Хөшигийн хөндийд баригдаж байгаа нисэх онгоцны шинэ буудлыг түлш, шатахуунаар хангах асуудлыг шийдвэрлэхэд гадаадын хөрөнгө оруулалт, оролцоог судлан танилцуулах. | Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай түүхий тосыг тээвэрлэх дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг МУ-ын Ерөнхий сайдын 2019.09.16-ны өдрийн 118 дугаар Захирамжаар байгуулсан. Ажлын хэсэг холбогдох судалгааг "Монголын логистикийн холбоо" ТББ-аар гүйцэтгүүлж тайланг хүлээн авсан ба тайлангийн үр дүнг Засгийн газрын 2019.12.18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 55 дугаар тэмдэглэл гаргуулсан. | 100% Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 46 | 3 | 3 | **2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр 55 дугаар тэмдэглэл**<br>**2019-12-18**<br>**Дугаар 2019_55**<br>XXIX.6. . Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр"-ийг дотоодын түүхий тосоор хангах, газрын тосны нийлүүлэлтийн дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох, шаардлагатай тооцоо судалгаа хийх, техник, технологийн шийдэл, хөрөнгө оруулалтын талаар санал, дүгнэлт гаргасан Ажлын хэсгийн тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр"-ийг түүхий тосоор хангах, газрын тосны нийлүүлэлтийн дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох талаар санал, дүгнэлт гаргасан Ажлын хэсгийн тайланг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн төлөөллийг байлцуулж, Засгийн газрын хуралдаанд дахин танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар даалгав. | МУ-ын Ерөнхий сайдын 2019.09.16-ны өдрийн 118 дугаар Захирамжаар байгуулсан Ажлын хэсгийн санал дүгнэлтийг Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар дахин хэлэлцүүлж ЗГ-ын 2020 оны 01 дүгээр тэмдэглэлээр түүхий тосыг дамжуулах хоолойгоор тээвэрлэхээр шийдвэрлэсэн. | 100%<br><br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 47 | 4 | 4 | **2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр 2 дугаар тэмдэглэл**<br>**2020-01-08**<br>**Дугаар 2020_2**<br>X.4. . Шатахууны үнийг тогтворжуулах зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газар болон "Би Ди Өү Интернэйшнл" ХХК хооронд хамтран ажиллах санлын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын | Энэ ажлын хүрээнд Засгийн газрын 2020 оны 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан "Эрчис Ойл" төрийн өмчит компаниар дамжуулан "АИ-92 төрлийн автобензиний үнийг тогтворжуулах" хамтын ажиллагааны гэрээ байгуулах ажлыг УУХҮЯ болон АМГТГ хамтран зохион байгуулав. Энэхүү тогтоолоор хэрэгжүүлж буй гэрээ нь эрсдэлийн сан буюу /Hedge Fund/ үүсгэн газрын тосны бүтээгдэхүүний бирж дээр санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан арилжаалах буюу урт болон богино хугацааны гэрээ хийж, үнэ болон нийлүүлэлтээ тогтмол хэмжээнд барьдаг туршлагаас үндэслэн Монгол Улсад анх удаа хийгдэж буй шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулж буй арга юм.<br>Манай улсын хувьд иргэдийн өргөн хэрэглээний суурь бүтээгдэхүүн болох АИ-92 шатахууны үнийг тогтворжуулах нь нийт эдийн засагт эерэг | 100%<br><br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан АИ-92 төрлийн шатахууны үнийг тогтворжуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэн, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт үүрэг болгов. | нөлөө үзүүлэх бөгөөд эдийн засгийн өсөлтийг дэмжих, бусад бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хязгаарлах гол ач холбогдолтой бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн "Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна" гэсэн заалтыг хэрэгжүүлэх боломжтой болж байна.<br>Энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс аливаа санхүүжилт шаардагдахгүй бөгөөд түлш, шатахууны импорт эрхлэгч компаниудын гадаад улстай хийсэн аливаа гэрээ хэлцэлд өөрчлөлт орохгүй эерэг талтай гэдгийг гэрээ байгуулах мэдэгдэл ирүүлсэн 18 аж ахуйн нэгжийн удирдлагуудад танилцуулан "Эрчис Ойл" ТӨК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Гэрээ байгуулснаар улсын хэмжээнд АИ-92 шатахууны бөөний болон жижиглэнгийн үнийг бүсчлэлээр жигд тогтоож 8 сарын хугацаанд хэрэгжүүлэн ажиллах бүрэн боломжтой юм. Засгийн газрын 2020.05.13-ны өдрийн хуралдаан УУХҮСайд Д.Сумъяабазар Бүх төрлийн шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга* хийв. | | |
| 48 | 5 | 5 | **2020 оны 2 дугаар сарын 12-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл**<br>**2020-02-12**<br>**Дугаар 2020_9**<br>XYI.5. . Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаас Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх дотоодын түүхий тосыг дамжуулах хоолойгоор тээвэрлэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан төслийн санхүүжилтийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр дамжуулах хоолойн санхүүжилтийг шийдвэрлэх санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул | Засгийн газрын 2020.02.19-ний өдрийн хуралдаанаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дамжуулах хоолойн дэд бүтцийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар танилцуулга хийж 11 дүгээр тэмдэглэл гаргуулсан. Дээрх шийдвэрийн дагуу тус яамнаас дамжуулах хоолойн санхүүжилтийн талаар санал боловсруулж ЗГ-ын хуралдаан танилцуулж өгөх хүсэлтийг УУХҮ-ийн сайдын 2020.02.17-ны өдрийн 01/464 дугаар болон 2020.04.10-ны өдрийн 01/1002 дугаар албан бичгүүдээр Сангийн сайдад хандаад байна. Сангийн сайдаас ирүүлсэн саналыг үндэслэн Үнэлгээний хороог байгуулахаар ажиллаж байна. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | | | |
| 49 | 6 | 6 | **2020 оны 2 дугаар сарын 19-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2020-02-19 Дугаар 2020_11** XIX.1. . Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дамжуулах хоолойн дэд бүтцийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг дор дурдсан Засгийн газрын гишүүдэд даалгав: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт: 2.1. Санхүүгийн эх үүсвэр шийдэгдэж, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэний дараа бүтээн байгуулалтын ажлыг удирдан зохион байгуулах. | Уг тэмдэглэлийн дагуу тус яамнаас дамжуулах хоолойн санхүүжилтийн талаар санал боловсруулж ЗГ-ын хуралдаанд танилцуулж өгөх хүсэлтийг УУХҮ-ийн сайдын 2020.02.17-ны өдрийн 01/464 дугаар тоотоор хандсан. СЯ-ны 2020.03.03-ны өдрийн 8-3/1247 тоотод уг төсөл нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан байх шаардлагыг хангаагүй тул Өрийн удирдлагын тухай хуулийн 33.11-д заасныг үндэслэн өрийн баталгаа гаргахгүйгээр шийдвэрлэх талаар хариу ирүүлсэн. Дээрх тоотын хариуг 2020.04.10-ны өдрийн 01/1002 дугаар тоотоор ЗГ-ын 2019 оны 290 дүгээр тогтоолоор уг төсөл нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан тул зохих дэмжлэг үзүүлэх хүсэлтийг Сангийн сайдад хүргүүлсэн. Газрын тос дамжуулах хоолойг барих төслийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтын урилга, туршлагын талаарх маягтуудад санал авахаар 2020.12.04 өдрийн 01/2971 тоотоор СЯ-нд хандаж саналыг 2020.10.04 өдрийн 6-1/7563 тоотоор авсан. Мөн газрын тос дамжуулах хоолойг барих төслийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах танилцуулгыг 2020.12.09-ний өдрийн ЗГ-ын хуралдаанд танилцуулж тэмдэглэл гаргуулсан. | 70% | |
| 50 | 7 | 7 | **2020 оны 3 дугаар сарын 19-ний өдөр 18 дугаар тэмдэглэл 2020-03-19 Дугаар 2020_18** III.2. . Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т даалгав: 1. Дэлхийн зах зээл дээр түүхий газрын тосны үнэ буурч | 1. ОХУ-ын “Роснефть” компаниас нийлүүлж буй шатахууны 2020 оны 04 дүгээр сарын хилийн үнэ өмнөх сартай харьцуулахад А-80, Аи-92, Аи-95, Аи-98 автобензин тонн тутамдаа 209 ам.доллар, дизелийн түлш тонн тутамдаа 187 ам.доллароор буурсан ба А-80 автобензин 330 ам.доллар/тн, Аи-92 автобензин 360 ам.доллар/тн, Аи-95 автобензин 430 ам.доллар/тн, Аи-98 автобензин 480 ам.доллар/тн, дизелийн түлш 369 ам.доллар/тн болж тус тус буурсан. Үүнтэй холбоотойгоор 4 дүгээр сарын 13-наас эхлэн импортлогч компаниуд шатахууны жижиглэнгийн үнийг 300-350 төгрөгөөр үе шаттайгаар бууруулж эхлээд байна. Шатахууны жижиглэнгийн үнэ дунджаар А-80 автобензин 1390 төгрөг, Аи92 автобензин 1470 төгрөг, Аи95 автобензин 2000 төгрөг, ДТ 2150 төгрөг болж тус тус буураад байна. Шатахууны улсын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шатахуун хадгалах агуулах шаардлагатай ба Рашаант өртөөн дэх газрын тосны бүтээгдэхүүний агуулах байгуулах концессийн гэрээний хэрэгжилтийг дүгнэх хүсэлтийг ҮХГ-т хүргүүлээд байна. Мөн улсын нөөцийн шатахууныг нэмэгдүүлэх санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналыг 2020 оны улсын төсвийн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байгаатай холбогдуулан Монгол Улсад шатахууны жижиглэнгийн үнийг үе шаттайгаар бууруулах; 2. Шатахууны үнэ хямд байгаа үед шатахууны улсын нөөцийг нэмэгдүүлэх талаар зохих арга хэмжээ авах. | хуулийн тодотголд тусгуулахаар хүргүүлсэн боловч төсөвт тусгагдаагүй болно. | | |
| 51 | 8 | 8 | **2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 37 дугээр тэмдэглэл 2020-06-23 Дугаар 2020_37** IY.. Бүтээгдэхүүн хуваах гэрээ цуцлах эрх олгох тухай асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов. 2. "Ди Дабль Юү Эм Петролеум АГ" ХХК-тай "Цагаан-Элс XIII", "Зүүнбаян XIY" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ", "Сансарын геологи хайгуул" ХХК-тай "Төхөм X хойд", "Цайдам XXYI" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-г цуцлах ажлыг зохион байгуулж, тэдгээр компанийн Газрын тосны тухай хуулийн 13.1.3-д заасан татвар, төлбөр, хураамжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-г цуцлахтай холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавьж, уг талбайд зарцуулсан хөрөнгийн тооцооллыг нягтлан шалгаж, зохих арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Газрын тосны газар болон "Ди Дабль Юү Эм Петролеум АГ" ХХК-тай "Цагаан-Элс XIII", "Зүүнбаян XIY" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ", "Сансарын геологи хайгуул" ХХК-тай "Төхөм X хойд", "Цайдам XXYI" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ", "Импайр газ Монголиа ХХК-тай "Борзон YII" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-г цуцлах тухай асуудлыг ЗГ-ын 2020.06.23-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэн 232 тоот тогтоолыг гаргуулсан. Уг тогтоолтой холбогдуулан холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар АМГТГ-ын даргын 2020.08.25-ны өдрийн А/85 тоот тушаалыг гарган ажиллаж байна. | 100% Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 52 | 8 | 9 | IY.3. . "Импайр газ Монголиа ХХК-тай "Борзон YII" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-г цуцлах ажлыг зохион байгуулахыг Ашигт малтмал, газрын тосны газар | Газрын тосны газар болон "Ди Дабль Юү Эм Петролеум АГ" ХХК-тай "Цагаан-Элс XIII", "Зүүнбаян XIY" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ", "Сансарын геологи хайгуул" ХХК-тай "Төхөм X хойд", "Цайдам XXYI" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ", "Импайр газ Монголиа ХХК-тай "Борзон YII" талбайд байгуулсан | 100% Тэмдэглэлийн дагуу холбогдох | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | (Х.Хэрлэн)-т, тус "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-г цуцлахтай холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, уг талбайд зарцуулсан хөрөнгийн тооцооллыг нягтлан шалгахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, татан буулгалтын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат нарт тус тус даалгав. | "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-г цуцлах тухай асуудлыг ЗГ-ын 2020.06.23-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэн 232 тоот тогтоолыг гаргуулсан. Уг тогтоолтой холбогдуулан холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар АМГТГ-ын даргын 2020.08.25-ны өдрийн А/85 тоот тушаалыг гарган ажиллаж байна. | арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 53 | 8 | 10 | YI.2. . Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжүүлж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1) гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалттай холбоотой асуудлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажлын сонгон шалгаруулалтад оролцогчийн санхүүгийн саналыг тус үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан дүнд багтаах хэлцэл хийж танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ын ерөнхий гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулж, хэлэлцээ хийж дууссан тухай танилцуулгыг 2020-08-05 өдрийн хуралдаанд танилцуулж 43 дугаар тэмдэглэл гаргуулсан. | 100%<br><br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 54 | 9 | 11 | **2020 оны 8 дугаар сарын 5-ны өдөр 43 дугаар тэмдэглэл** | Засгийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд өөрийн аймгийн нутаг дэвсгэрт орших хилийн боомтоор явагдаж газрын тосны экспортын тээвэрлэлтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх үйл ажиллагааг | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **2020-08-05**<br>**Дугаар 2020_43**<br>YI.4. 4. Монгол, Хятадын хилийн боомтын "Ногоон гарц"-ыг хэрэгжүүлэх түр журмын хэрэгжилтийг 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Гадаад харилцааны сайд Н.Энхтайван, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт; | холбогдох талуудтай хамтран зохион байгуулж, холбогдох арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн, хамтран ажиллах тухай 2020.08.13-ны өдрийн 01/1977 тоот албан бичгийг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар нарт тус тус хүргүүлсэн. Баянхошуу болон Бичигт боомтоор явагдаж буй газрын тосны экспортын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байгаа ба өнөөдрийн байдлаар дээрх боомтуудаар явагдаж буй газрын тосны экспортын тээврийг 48 автоцистернээр гүйцэтгэж байсныг нэмэгдүүлэн, өдөрт 70-74 автоцистерн болгон нэмэгдүүлээд байна<br>Нүүрс болон бусад эрдэс бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд тус яамнаас Монгол, Хятадын "Ногоон гарц" журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх, уул уурхайн салбарт ажиллах гадаадын ажиллах хүчийг хилээр нэвтрүүлэх тухай саналыг боловсруулж, Улсын Онцгой комиссын 2020.07.28-ны өдрийн 27 дугаар хуралдаан, Засгийн газрын 2020.08.05-ны өдрийн 43 дугаар хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулсан.<br>Монгол, Хятадын "Ногоон гарц" түр журмын хүрээнд нүүрс тээврийн жолооч нарыг Хятадын талд хонуулах арга хэмжээг авч эхэлсний дүнд өдөрт Гашуунсухайт боомтоор 1000, Шивээхүрэн боомтоор 700 орчим тээврийн хэрэгсэл нэвтэрч эхэлсэн нь цар тахал гарч, хорио, цээрийн дэглэм тогтоохоос өмнөх үетэй адил үзүүлэлт юм. | | |
| 55 | 9 | 12 | YI.4. 5. Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөлд зохион байгуулах түр журмын дагуу газрын тосны экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хил хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт) болон тухайн боомт байрлах аймгийн Засаг дарга болон Онцгой комиссын дарга нарт. | Засгийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд өөрийн аймгийн нутаг дэвсгэрт орших хилийн боомтоор явагдаж газрын тосны экспортын тээвэрлэлтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх үйл ажиллагааг холбогдох талуудтай хамтран зохион байгуулж, холбогдох арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн, хамтран ажиллах тухай 2020.08.13-ны өдрийн 01/1977 тоот албан бичгийг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар нарт тус тус хүргүүлсэн. Баянхошуу болон Бичигт боомтоор явагдаж буй газрын тосны экспортын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байгаа ба өнөөдрийн байдлаар дээрх боомтуудаар явагдаж буй газрын тосны экспортын тээврийг 48 автоцистернээр гүйцэтгэж байсныг нэмэгдүүлэн, өдөрт 70-74 автоцистерн болгон нэмэгдүүлээд байна | 100% | |
| 56 | 9 | 13 | YI.5. . Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд | Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ын ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 86 | 1 | 1 | **Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай**<br>**2019-12-31**<br>**Дугаар 2019_60/40**<br>2.8. Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, буруутай этгээдэд хариуцлага тооцох, учруулсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авах | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй аж ахуйн нэгжүүдтэй хариуцлага тооцох хүрээнд 2018 онд нийт 209 тусгай зөвшөөрөл цуцалсан бол 2019 онд 199 тусгай зөвшөөрлийг цуцалсан байна.<br>Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтад “тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан;” тохиолдолд Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай зохицуулалтыг Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан.<br>Дээр дурдсан хуулийн заалтын дагуу 2019 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Номгон, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дэвсгэрт нийт 20 аж ахуйн нэгжийн 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалж, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг албадан гүйцэтгүүлэх, цаашид хууль бусаар алт олборлох зөрчил гарахаас сэргийлэх, хууль бусаар алт олборлогч нар талбайг ухахаас хамгаалах зорилгоор 12 дугаар сарын 01-ийг хүртэл цагдаа болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад авах шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлж ажилласан. 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдрөөс 12 дугаар сарын 1-ийг хүртэл Цагдаагийн Ерөнхий газрын Эргүүл тусгай хамгаалалтын тасгийн 160, Архангай аймаг дахь Цагдаагийн газрын 160 нийт 320 алба хаагчид 22 тээврийн хэрэгсэлтэй хамгаалалтыг авч хэрэгжүүлсэн. | 100%<br>ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.e. Засгийн газрын тогтоол | | | | | | |
| 87 | 1 | 1 | **Гаалийн тарифын зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 2014-09-18 Дугаар 2014_306** 2. Гаалийн тарифтай холбоотой бодлогын асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийн өмнө Гаалийн тарифын зөвлөлөөр хэлэлцүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай. | Гаалийн тарифын зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай шийдвэр гарснаас хойш хуучнаар УУЯ, өнөөгийн УУХҮЯ-аас гаалийн тарифтай холбоотой асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй болно. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | |
| 88 | 2 | 2 | **Тогтоол хүчингүй болгох тухай 2017-03-20 Дугаар 2017_96** 4. Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг үндэслэн Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн боомтын төмөр замын төсөлд зарцуулсан хөрөнгийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд оруулах нийт хөрөнгө оруулалтад нь багтаан тооцуулах талаар хөрөнгө оруулахыг сонирхож байгаа этгээдтэй хэлэлцээ хийж тохиролцохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгасугай. | "Гашуун Сухайтын Төмөр Зам" ХХК-д оруулсан хувь хөрөнгийн хэмжээг татан авах ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, холбогдох дүгнэлтийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулсан. ТУЗ-өөс хувь хөрөнгөө татан авах ажлыг гүйцэтгэхийг даалгасан тогтоолыг 2017 оны 05 дугаар сарын 25-нд гаргасан. Үүний дагуу "Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт" аудитын шалгалт хийлгэх зардлыг шийдвэрлэх хүсэлтийг хүргүүлсэн.<br><br>Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замыг барьж байгуулах, ашиглалтад оруулах хөрөнгө оруулагчийг татах чиглэлээр тодорхой арга хэмжээнг үе шаттай авч хэрэгжүүлсэн. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн чиглэл болон Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд төмөр замын суурь бүтцийг өмчлөх эрх нь зөвхөн төрд хамаарах тул хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлээс бус төрийн өмчит компанийн санхүүжилтээр шийдвэрлэх шаардлага бий болсон. Энэ хүрээнд Тавантолгой ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай төмөр замын дэд бүтцийг барьж байгуулах чиглэлээр УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолыг батлуулсан. Тус тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоол батлагдан уг төмөр замыг барьж байгуулах этгээдээр төрийн өмчит компани болох ЭТТ ХК болон Монголын төмөр зам ХХК-ын хамтарсан охин компани болох Тавантолгой төмөр зам ХХК-г байгуулж, холбогдох төмөр зам барих тусгай зөвшөөрлийг уг компанид өгсөн. Монголын төмөр зам болон ЭТТ оруулсан хөрөнгийн хэмжээгээр тус компанид хувьцаа эзэмших бөгөөд төмөр зам эхлүүлэх ажлыг нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэхийг ЭТТ-д зөвшөөрч төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна. | 70% | |
| 89 | 3 | 3 | **Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төслийн тухай** | УУХҮЯамнаас "Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл"-ийн ТЭЗҮ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, Тавантолгойн нүүрс угаах үйлдвэр, Тавантолгойн цахилгаан станцын ТЭЗҮ, зураг | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **2017-08-17**<br>**Дугаар 2017_232**<br>1.. Өмнийн говьд байгуулагдах томоохон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн болон бусад төслүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх "Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл"-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгасугай. | төсөв хийх ажлыг шуурхай зохион байгуулж, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах тухай албан бичгийг 2019.12.18-ны өдрийн 01/3486 тоот албан бичгээр "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлсэн. Уг шаардлагатай санхүүжилтийн асуудлыг хувийн хэвшлийн оролцоотойгоор шийдвэрлэснээр Говийн бүсийг гадаргын усаар хангах боломж нөхцөл бүрдэнэ. Мөн "Өмнийн говьд хэрэгжих уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх, боломжит хувилбаруудыг тодорхойлох судалгаа", "Өмнийн говийн газрын доорх усны нөөцийн зураглал" хийлгэх хүсэлтийг Дэлхийн банкны "2030 Усны Нөөцийн Бүлэг"-ийн Монгол дахь суурин төлөөлөгчид 2019 оны 9 дүгээр сард албан ёсоор тавьсан бөгөөд тус саналын хүрээнд 2019.10.22-ны өдөр БОАЖЯ, УУХҮЯ, АМГТГ-ын газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачдаас бүрдсэн 50 гаруй оролцогчдын хүрээнд зохион байгуулагдсан "Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар дахь ус ашиглалт, засаглалын тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замууд" сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг, 2019.12.11-ний өдөр "2030 Усны Нөөцийн Бүлэг"-ийн Удирдах зөвлөлийн хурлаар судалгааны ажлын цар хүрээ, ажлын даалгаврын нөхцөл, шаардлагын талаар болоод Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан "Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр"-тэй хэрхэн уялдуулах, хэрэгжүүлэх асуудлууд дээр санал солилцсон зэрэг хэд хэдэн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Эдгээр уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнд УУХҮЯ, Дэлхийн банкны "2030 Усны Нөөцийн Бүлэг" хамтран "Өмнийн говьд хэрэгжих уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх, боломжит хувилбаруудыг тодорхойлох судалгаа"-ны ажлыг 2020.02.20-ны өдрөөс эхлэн 4 сарын хугацаанд хийж хэрэгжүүлэхээр УУХҮЯ-ны Хүнд үйлдвэрийн хэлтсийн дарга С.Сүхбат, Дэлхийн банкны "2030 Усны Нөөцийн Бүлэг"-ийн Монгол дахь суурин төлөөлөгч Д.Доржсүрэн нар харилцан тохиролцож, судалгааны ажлууд хийгдэж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас "Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тогтоолоор батлуулсан. Тогтоолын төслийг боловсруулах ажлын хүрээнд дэд бүтцийн болон усан хангамжийн төслүүдийн судалгааг хийж, Улсын Их хурал, Засгийн газрын гишүүдэд танилцуулсан. Уг тогтоолоор Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх, өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд гадаргын болон гүний усыг байгаль, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр зохистой ашиглах боломжийг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан. Энэ хүрээнд Засгийн газрын 2018 оны 196 дугаар тогтоолоор Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д "Говийн бүсийн уул уурхайн төслүүдэд үйлдвэрийн технологийн ус нийлүүлэх төсөл"-ийг уралдаант шалгаруулалтаар хэрэгжүүлэх тухай заалтыг нэмж тусгасан.<br>Өмнийн говьд хэрэгжих уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх, боломжит хувилбаруудыг тодорхойлох зорилгоор УУХҮЯ-ны захиалгаар Дэлхийн банкны санхүүжилттэйгээр "2030 усны нөөцийн бүлэг" Өмнийн говийн уул уурхай, хүнд үйлдвэрийн бүсийн усны эрэлт-хангамжийн гидроэкономик судалгаа, шинжилгээний ажлыг 2020.02.20-ны өдрөөс хийж эхлүүлсэн бөгөөд судалгааны ажлын үр дүн, эцсийн тайланг 2020.10.14-ний өдөр хүлээн авсан. Энэхүү тайлан нь Тавантолгой, Оюутолгойн бүсийн ус хангамжийн өнөөгийн байдлыг судлан, усны эрэлтийг 2030, 2040, 2050 оны түвшинд тодорхойлж, өсөн нэмэгдэж байгаа усны эрэлтийг хангах боломжит шийдлүүдийг харьцуулан судалж, тэдгээрт эдийн засгийн дүн шинжилгээ хийн, эрэмбэлснээрээ онцгой ач холбогдолтой ажил болсон. | | |
| 90 | 4 | 4 | **"Эрдэнэт үйлдвэр" хязгаарлагдмал хариуцлагатай компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны тодорхой хэсгийгиргэдэд эзэмшүүлэх тухай 2018-01-10 Дугаар 2018_10**<br>1.. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулах, нийт хувьцааны тодорхой хувийг Монгол Улсын нийт иргэдэд эзэмшүүлэх асуудлыг боловсруулан Засгийн газарт оруулж хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Сангийн сайд | Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 90 дүгээр тогтоолоор "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийг Төрийн өмчит улсын үйлдвэрийн газар болгохоор шийдвэрлэсэн.Улмаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 262 дугаар тогтоолоор "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг батлуулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | | | |
| 91 | 5 | 5 | **Аргачлал шинэчлэн батлах тухай “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал” 2018-01-24 Дугаар 2018_20** 4.. Хөгжлийн индексийн үр дүнг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлт боловсруулахад ашиглаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, тухайн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн төсөвт олгох хөрөнгийг хөгжлийн индекс ашиглан тодорхойлсон итгэлцүүрийг үндэслэн тооцож байхыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус даалгасугай. | Монгол Улсын 2020 оны төсвийн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд Улсын хэмжээнд нийт төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос Засгийн газрын 2015 оны 347 дугаар тогтоолын хавсралтад тусгагдсан улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч “Эрдэнэс-тавантолгой” ХК, “Оюу толгой” ХХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь, уг орлогын 33-аас доошгүй хувийг тухайн олборлолт хийсэн сумын орон нутгийн хөгжлийн санд олгоно. Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал”, Сангийн сайдын 2016 оны “Аргачлал батлах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос Орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал”, “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал”-д заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрээр тооцсон суурь тооцооллыг орон нутгийн төсвийн төсөл боловсруулах удирдамжийн хамт аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид хуваарилан хүргүүлдэг. | 100% | |
| 92 | 6 | 6 | **“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2018-08-08 Дугаар 2018_245** 1.. Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр үе шаттайгаар арилжаалахтай холбогдсон бэлтгэл ажлыг хангахад шаардагдах мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, техник, технологи шаардсан үйлчилгээг үзүүлэх чадвартай гүйцэтгэгчийн тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулахыг | Улсын Их Хурлын 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы хуралдаанаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэж тусган батлуулсан. ТУЗ-ийн 2019.07.30-ны өдрийн 28 дугаар тогтоолоор “Эрдэнэс-Тавантолгой Майнинг” ХХК охин компани байгуулагдсан. ТУЗ-ийн 2019.09.02-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор олон улсын зөвлөх үйлчилгээг “Эрдэнэс-Тавантолгой Майнинг” ХХК дотоодын зөвлөх үйлчилгээг “Эрдэнэс-Тавантолгой” ХК журмын дагуу тус тус зохион байгуулсан. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьд 2020.05.08-ны байдлаар дотоодын хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэхэд шаардлагатай дараах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгож, холбогдох гэрээг байгуулан тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан. Үүнд: | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт, холбогдох гэрээг байгуулан хэрэгжүүлж ажиллахыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт тус тус даалгасугай. | -Дотоодын андеррайтерийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Би Ди Сек" ХК, "MICC" ХХК-нэгдлийг;<br>-Дотоодын хуулийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Батбаяр энд партнерс" ХХН-ийг;<br>-Дотоодын аудитын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Конфидence аудит" ХХК-ийг;<br>-Дотоодын хөрөнгийн үнэлгээний зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "БДО аудит" ХХК-ийг;<br>-Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээний тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Экологийн бүтээмж" ХХК-ийг;<br>-Уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн сан бүрдүүлэх, хаалтын төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр RWE болон "Евро-Хан" ХХК-ийн нэгдлийг;<br>-Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "PwC Mongolia" ХХК-ийг;<br>-Мэдээллийн сан, проспектус, үнэт цаас танилцуулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "МЭК" ХХК-ийг;<br>-Зах зээлийн судалгааны тайлан бэлтгэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Шанхи Фенвэй Энержи Имформэйшин Сервис, "Прожект майнинг" ХХК-ийн нэгдлийг;<br>-Брэнд бүтээх, хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Жамух интернэйшнл" ХХК-ийг сонгон шалгаруулсан. Гэвч Засгийн Газрын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар 2019 оны Засгийн газрын 296 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай шийдвэр гаргасан тул гадаадын зах зээлд хувьцаа гаргах ажил зогсонги байдалд орсон. Иймд компанийн зүгээс "Эрдэнэс Тавантолгой Майнинг" ХХК-аас шаардлагатай баримт 96материалыг хүлэн авах, гадаад дотоодын зөвлөхүүдтэй байгуулсан гэрээг дүгнэх, зарим тайлан, дүгнэлтийг эцэслэн авах чиглэлээр ажиллаж байна | | |
| 93 | 6 | 7 | 7.. Азийн хөгжлийн банктай байгуулсан "Засаглал, менежментийн чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн зээлийн хөрөнгийн ашиглалтыг Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр үе шаттайгаар арилжаалах үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, | Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр үе шаттайгаар арилжаалах үйл ажиллаг эрчимжүүлэх зорилгоор УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоол болон ЗГ-ын 2018 оны 245, ЗГ-ын 2019 оны 296 дугаар тогтоолыг тус тус баталсан. Гэвч, цаг үеийн нөхцөл байдал, дэлхийн зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалж уг хөрөнгийн биржээр хувьцаа арилжаалах асуудлыг түр хугацаанд хойшлуулахаар ЗГ-ын 2020 оны 146 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүү нарт тус тус үүрэг болгосугай. | | |
| 94 | 7 | 8 | **Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2019-04-10**<br>**Дугаар 2019_135**<br>3.. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд шаардагдах хөрөнгийн үлдэгдэл санхүүжилтийг Монголбанкны дэмжлэгээр бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханд зөвлөсүгэй. | Засгийн газрын 2020 оны 117 дугаар тогтоолоор “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, зөвшөөрөл олгох, төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээ”-г баталсан. Уг тогтоолын 3-д “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн хувьцааг хаалттай хүрээнд нэрлэсэн үнээр худалдах замаар нийт хувьцааны 66 хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д тус тус эзэмшүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар /Б.Цэнгэл/, цаашид “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу үе шаттай шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар,“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Артур/,“Эрдэнэс-Тавантолгой ”ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Баярсайхан/-д тус тус даалгасугай гэж заасан.<br>Дээр дурдсан тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 39 дүгээр тогтоолыг баталсан байх бөгөөд “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн 66 хувийг эзэмших, гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн байна. Үүний дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас дараах гэрээ, хэлэлцээрүүдийг байгуулсан байна. Үүнд:<br>“Монголын төмөр зам” ТӨХК-тай “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ”, “Урьдчилгаа санхүүжилтийн гэрээ”-г тус тус байгуулсан.<br>Компанийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх, Засгийн газрын тогтоолын хэрэгжүүлэх зорилгоор дараах санхүүжилтийг 2020 онд хийсэн байна. Үүнд:<br>– Урьдчилгаа санхүүжилтээр 58 тэрбум төгрөг,<br>– Нэмэлт санхүүжилтээр 75 тэрбум төгрөг<br>“Эрдэнэс Тавантолгой” ХК-иас Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалтад нийт 526 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна. | 100% | |
| 95 | 8 | 9 | **“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2019-07-09**<br>**Дугаар 2019_296**<br>1.. 1. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж | Энэхүү тогтоол нь 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 146 дугаар тогтоолоор хүчингүй болсон. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байгаа хувьцааны хоёрдахь зах зээлийн арилжааг хөрөнгийн бирж дээр үе шаттайгаар эхлүүлэхтэй холбогдуулан дараахь ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт даалгаж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хороо (С.Даваасүрэн)-нд зөвлөсүгэй: 1.1. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааны өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомж, анхан шатны баримтад тулгуурлан хянаж, нягтлах ажлыг зохион байгуулж, хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн бүртгэлийг 2019 оны 12 дугаар сарын эхний 7 хоногт багтаан дуусгаж, үр дүнг танилцуулах; 1.2. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа хувьцааг гадаад улсын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх, арилжаалах бэлтгэл ажлыг хангуулах. | | | |
| 96 | 8 | 10 | 2.. 2. Тавантолгой нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааг зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад улсын хөрөнгийн биржээр арилжаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т тус тус даалгасугай: 2.1. Олон улсын хөрөнгийн зах зээлээс боломжит богино хугацаанд хамгийн бага зардлаар хөрөнгө босгох зорилгоор холбогдох хууль тогтоомж, | Энэхүү тогтоол нь 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 146 дугаар тогтоолоор хүчингүй болсон. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компаниудыг байгуулах; 2.2. Тавантолгой нүүрсний ордын үнэ цэнийг цаашид үе шаттайгаар нэмэгдүүлэх зорилгоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн эзэмшлийн тусгай зөвшөөрлүүдээс эхний ээлжинд MY-011943 дугаар бүхий Цанхийн зүүн хэсгийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компанид эзэмшүүлэх; 2.3. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компанийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад улсын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө оруулагчдад санал болгох, 70 буюу түүнээс доошгүй хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК эзэмшиж байхаар зохион байгуулах;<br>2.4. Гадаад улсын хөрөнгийн биржээр хувьцаа арилжаалах үйл ажиллагааг богино хугацаанд зохион байгуулах, түүнтэй холбогдсон татвар, зардлын хэмжээг хамгийн бага байлгах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллах. | | | |
| 97 | 8 | 11 | 3.. Тавантолгой нүүрсний ордын үнэ цэнэ, дэд бүтцийн холбогдох төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл зэргийг харгалзан “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ногдол ашгийн бодлогыг баталж, компанийн 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах чиглэлийг баримталж ажиллахыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа)-д зөвлөсүгэй. | Энэхүү тогтоол нь 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 146 дугаар тогтоолоор хүчингүй болсон. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 98 | 8 | 12 | 4.. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явц байдлыг Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т тус тус үүрэг болгосугай. | Энэхүү тогтоол нь 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 146 дугаар тогтоолоор хүчингүй болсон. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | |
| 99 | 9 | 13 | **Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын теслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>**2019-07-24**<br>**Дугаар 2019_304**<br>2.. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, ашиглахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг техник, эдийн засгийн үндэслэлд заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа)-д зөвшөөрч, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т даалгасугай. | Компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч УУХҮЯ-ны 2019 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 19/11 тоот удирдамжийг үндэслэн ТУЗ-өөс 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 31 дүгээр тогтоолыг баталж, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 66 хувийг эзэмших, гэрээ хэлцэл байгуулахыг Гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн. Үүний дагуу дараах гэрээ, хэлэлцээрүүдийг байгуулсан. Үүнд:<br>- "Монголын төмөр зам" ТӨХК-тай "Хувьцаа эзэмшигчдийн гэрээ"<br>- "Тавантолгой төмөр зам" ХХК, "Бодь интернейшнл" ХХК-тай "Санхүүжилтийн гэрээ"<br>- "Бодь интернейшнл" ХХК болон нүүрс худалдан авагч компаниудтай "Нүүрс худалдах, худалдан авах гэрээ"-г тус тус байгуулсан.<br>Компанийн зүгээс Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, ашиглахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор дараах санхүүжилтүүдийг хийсэн. Үүнд:<br>- Үйл ажиллагааны зардалд 15 тэрбум төгрөгийн шууд хөрөнгө оруулалт,<br>- Хувьцаа эзэмшигчдийн гэрээний дагуу урьдчилсан санхүүжилт хэлбэрээр 110 сая ам.долларын шууд хөрөнгө оруулалт,<br>- Гэрээний дагуу Тавантолгой төмөр зам ХХК-д санхүүжилт хийж 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар " Бодь Интернэшнл" ХХК-д 211,4 сая долларын 3,97 сая тонн нүүрсийг нийлүүлээд байна<br>Засгийн газрын тогтоолоор өгөгдсөн чиглэлийн дагуу үлдэгдэл хөрөнгө оруулалтыг нүүрс урьдчилан борлуулах замаар бүрэн шийдвэрлэсэн. | 100% | |
| 100 | 9 | 14 | 4.. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үргэлжлүүлж, 2021 онд ашиглалтад оруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул | ЗТХЯ | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт үүрэг болгосугай. | | | |
| 101 | 9 | 15 | 6.. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ажлын явц, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | ЗТХЯ | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | |
| 102 | 10 | 16 | **Дүрэм батлах тухай 2019-08-07 Дугаар 2019_313** 2.. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавихыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд тус тус үүрэг болгосугай. | Хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд цагдаа, тануул, онцгой байдал, мэргэжлийн хяналт, зэвсэгт хүчний жанжин штаб болон мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж байна. Тухайлбал тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулахын аюулгүйн бүсийг тогтоох асуудлаар холбогдох байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн комиссыг томилж хөдөө, орон нутагт 2020 онд 17 удаа томилолтоор ажилласан.<br>Мөн Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий цагдаа, тануул, онцгой байдал, мэргэжлийн хяналт, зэвсэгт хүчний жанжин штаб болон мэргэжлийн холбоодоос бүрдсэн мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг 2020 онд 7 удаа зохион байгуулж, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль болон "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан. | 100% | |
| 103 | 11 | 17 | **Үндэсний хөтөлбөр батлах тухай 2019-08-14 Дугаар 2019_317** 2.. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн А/232, А/66 дугаар тушаалаар баталж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | | | |
| 104 | 11 | 18 | 3.. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хамтран баталж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай. | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн А/232, А/66 дугаар хамтарсан тушаалаар Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг тус тус баталсан. | 100% | |
| 105 | 12 | 19 | **Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-09-18 Дугаар 2019_355** 1.. 1.4. Бичил уурхайгаар ашигт малтмал хууль бусаар олборлоход ашигласан болон ашиглахаар бэлтгэсэн техник, тоног төхөөрөмжийг талбайгаас гаргаж, харуул хамгаалалт зохион байгуулах, холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Цагдаагийн ерөнхий газар (С.Баатаржав), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цагаанхүү) болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар нарт; | Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасныг үндэс болгон 2019 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Номгон, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дэвсгэрт нийт 20 аж ахуйн нэгжийн 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалж, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг албадан гүйцэтгүүлэх, цаашид хууль бусаар алт олборлох зөрчил гарахаас сэргийлэх, хууль бусаар алт олборлогч нар талбайг ухахаас хамгаалах зорилгоор 12 дугаар сарын 1-ийг хүртэл цагдаа болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад авах шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлж ажиллав. 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдрөөс 12 дугаар сарын 1-ныг хүртэл Цагдаагийн Ерөнхий газрын Эргүүл тусгай хамгаалалтын тасгийн 160, Архангай аймаг дахь Цагдаагийн газрын 160 нийт 320 алба хаагчид 22 тээврийн хэрэгсэлтэй хамгаалалтыг авч хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайд үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгж, иргэдийн 163 ширхэг техник, тоног төхөөрөмж /Экскаватор 46, утгуурт ачигч 31, автосамосвал 46, алт угаах төхөөрөмж 40/-ийг талбайгаас албадан гаргаж, алт угаах зориулалтаар ашиглаж байсан хаягдал усны 10 даланг задалж усыг урсган аюулгүй болгож, хууль бусаар үйл ажиллагаа явуулж байсан 26 айлыг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авсан байна. | 100% | |
| 106 | 12 | 20 | 2.. Энэ тогтоолын 1.2 болон 1.5-д заасныг хэрэгжүүлэхэд шаардагдах үйл ажиллагааны зарим зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, уг зардлыг буруутай | Холбогдох зардлын хуулийн хүрээнд гаргаж ажилласан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт; | | | |
| 107 | 12 | 21 | 3.. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасны дагуу холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж 2019 оны IY улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт үүрэг болгосугай. | Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2019 оны 355 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлын хүрээнд тус тогтоолыг хэрэгжүүлэх, судалгааг хийх, шаардлагатай арга хэмжээг авах чиглэлээр Засгийн газрын 2020 оны 17 дугаар тогтоолыг батлуулсан. Тус тогтоолын дагуу хууль бусаар ашигт малтмал олборлосон этгээдэд хариуцлага хүлээлгэх тухай Эрүүгийн хуулийн холбогдох заалтад 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр өөрчлөлт оруулсан. | 100% | |
| 108 | 13 | 22 | **Тогтоолын хавсралт шинэчлэн батлах, хавсралтад өөрчлөлт оруулах тухай<br>2019-12-25<br>Дугаар 2019_465**<br>4.. Энэ тогтоолыг мөрдөж ажиллахыг Татварын ерөнхий газар (Б.Заяабал), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цагаанхүү)-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт тус тус үүрэг болгосугай. | Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.10.22-ны өдрийн 196/А-266 дугаар тушаалаар батлагдсан Экспортод гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох зах зээлийн үнийг нийтэд мэдээлэх үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, сар бүрийн эхний 10 хоногт экспортод гаргаж буй ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох жишиг үнийг нийтэд зарлаж мэдээлж байна. | 100% | |
| 109 | 14 | 23 | **Жагсаалт батлах тухай<br>2019-12-25<br>Дугаар 2019_469**<br>2.. 1. Хувь хүний орлогын албан татвараас хөнгөлөх "Нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксон түлш, хийн болон шингэн түлш гарган | Хувь хүний орлогын албан татвараас хөнгөлөх "Нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксон түлш, хийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуурын жагсаалтад хамрагдах бараа материалын жагсаалтыг 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 01/2487 албан тоотоор Сангийн сайдад хүргүүлсэн. Засгийн газрын тогтоол батлагдсантай холбогдуулан мэргэжлийн холбоодод мэдэгдсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуурын жагсаалт”-ыг хавсралт ёсоор батлсугай. 2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн нарт даалгасугай. | | | |
| 110 | 15 | 24 | **Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгах, зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 2019-12-25 Дугаар 2019_473** 4.. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч нь Ашигт малтмалын тухай хуулийн 43.1-д заасан хэмжээнээс илүү тооны гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулж байгаа тохиолдолд мөн хуулийн 43.2, 43.3-т заасныг хэрэгжүүлэх талаар орон нутгийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт үүрэг болгосугай. Энэ тогтоолын дагуу ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2020 онд буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд мэдэгдэхийг холбогдох сайд нарт даалгасугай. | Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.6-д заасны дагуу 2020 оны 12 сарын 17-ны өдрийн байдлаар нийт 98 аж ахуйн нэгжийн 4538 гадаадын иргэн ажиллуулах хүсэлт ирүүлснийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газарт уламжлав. | 100% | |
| 111 | 16 | 25 | **Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг** | Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/33 тоот тушаалаар “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг хүчингүй болгох асуудлыг судалж санал дүгнэлт гаргах, Ашигт малтмал, газрын тосны | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай** **2020-01-15** **Дугаар 2020_17** 11.. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөөгүй, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэн хүлээн авсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн тэмдэглэл, төрийн захиргааны байгууллагын шийдвэргүй болон Монгол Улсын хилийн зурваст олгосон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах, бичил уурхайтай холбогдох хуулийн зохицуулалтыг хүчингүй болгох асуудлыг тус тус судалж, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зохих журмын дагуу боловсруулж, 2020 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт үүрэг болгосугай. | даргын 2020 оны А/37 дугаар тушаалаар Бичил уурхайн журам, Засгийн газрын 355 дугаар тогтоолын явц, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж танилцуулах ажлын хэсэгт тус тус ажиллаж, өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд чанартай гүйцэтгэсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.12.25-ны өдрийн А-332 тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, хуулийн төслийг боловсруулж байна. | | |
| 112 | 17 | 26 | **Төлөвлөгөө батлах тухай** **2020-02-19** **Дугаар 2020_74** 3.. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хараат бус, консалтингийн зөвлөх үйлчилгээ авахтай холбоотой санхүүжилтийг олон улсын банк, санхүүгийн байгууллагын санхүүжилттэй төслийн зээл, бусад эх үүсвэрээс шийдвэрлэхийг Сангийн сайд | Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020.03.31-ний өдрийн 23 дугаар тушаалаар байгуулагдсан "Оюутолгон ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019.12.18-ны өдрийн 174 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, зохицуулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус яамнаас төлөөлөл ажиллаж байгаа бөгөөд Ажлын хэсгийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хараат бус, консалтингийн зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгаврын төслийг боловсруулж, Ажлын хэсэгт хүргүүлсэн. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал (П.Ганхүү), "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн гүйцэтгэх захирал (Ц.Түмэнцогт) нарт тус тус үүрэг болгосугай. | | | |
| 113 | 18 | 27 | **Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл батлах тухай 2020-03-18 Дугаар 2020_95** 3. Тэргүүлэх чиглэлд тусгагдсан инновацийн үйл ажиллагааны арга хэмжээг өөрсдийн үйл ажиллагааны жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, тухайн арга хэмжээнд батлагдсан төсөвт эх үүсвэрийн дунд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай | Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 29-ны өдрийн "Нийслэл Улаанбаатар хотын зүүн бүсэд сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барьж ашиглалтад оруулах тухай" 35 дугаар тогтоол батлагдсан.<br>Уг тогтоолын дагуу сайжруулсан шахмал түлшний 2 дах үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байгуулахаар барилгын суурийн ажлыг 2020 оны 4 дүгээр сард эхлүүлээд байгаа ба мөн оны 11 дүгээр сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна.<br>Тус үйлдвэр нь жилд 600 мян.тн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай ба ТЭЗҮ-ийг Тавантолгой түлш ХХК-ийн захиалгаар Эрчим хүчний Эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ хийж гүйцэтгэсэн байна. Цахилгаан хангамжийн эх үүсвэр 110кВт-ын Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК хийсэн.Эрдэмтдийн зөвлөх баг түлшний чанарыг сайжруулах, хорт хийн ялгарлыг бууруулах, олон улсын стандартад хүргэх талаар нарийн судлагаа, шинжилгээнүүдийг хийсэн бөгөөд, үйлдвэрийн үндсэн байгууламжийг газар доор байхаар төлөвлөсөн байна. Ингэснээр байгаль орчинд ээлтэй, агаарт дэгдэх тоосжилт зэрэг сөрөг асуудлуудыг үүсгэхгүй хэмээн тооцоолсон байна.<br>Үйлдвэрийн үндсэн байгууламжийг газар доор байхаар төлөвлөсөн байна. Ингэснээр байгаль орчинд ээлтэй, агаарт дэгдэх тоосжилт зэрэг сөрөг асуудлуудыг үүсгэхгүй байхаар тооцоолсон байна.<br>Үйлдвэрийг барьснаар шинээр 1500-1700 хүн шууд ажлын байраар хангагдаж, хоногт 3000 тонн түлш үйлдвэрлэж, Налайх дүүргийн хэмжээний хэрэгцээг хангахын зэрэгцээ, Улаанбаатар хотын хэрэглэгчдэд нийлүүлэх боломж бүрдэх ба Налайх дүүргийн агаарын бохирдол 50-70 хүртэл хувь, Улаанбаатар хотынх 70-80 хүртэл хувиар буурах боломжтой болох юм. | 70% | |
| 114 | 19 | 28 | **Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай 2020-03-25 Дугаар 2020_110** 4. Ашигт малтмалын ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөл, газрын | Ашигт малтмал, газрын тосны газраас Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн нэгдсэн мэдээллийн санг 2010 онд байгуулсан бөгөөд мэдээллийн санг шинэчлэх сайжруулалтын ажил тухай бүр хийгдэж байсан. Германы хамтын ажиллагааны BGR төслийн шугамаар Кадастрын хэлтсийн мэдээллийн сангийн нэмэлт сайжруулалт болон цахим архив тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн системийг нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. 2020 оны 1 дүгээр улиралд багтааж цахим архив болон тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу болон бичил уурхай эрхлэх зориулалтаар ашиглах талбайн мэдээллийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд тухай бүр бүртгэж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | системийн хөгжүүлэлт суурилуулалтын ажил хийгдэж дуусах байсан боловч системийг хөгжүүлэгч Германы ГАФ АГ компанийн үйл ажиллагаа COVID-19 өвчний улмаас түр зогсож ажилтнууд нь гэрээсээ ажиллаж байгаа тул системийн хөгжүүлэлт суурилуулалтын ажил удаашралтай явагдаж байгаа байна. | | |
| 115 | 20 | 29 | **Жагсаалт батлах тухай**<br>**2020-05-13**<br>**Дугаар 2020_175**<br>2. "Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт"-ыг хавсралт ёсоор батлсугай. 2. Энэ тогтоолыг нийтээр дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд тус тус үүрэг болгосугай. | Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалтын дагуу МХЕГ, ЦЕГ, ТЕГ, ГЕГ болон аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж байна. | 100% | |
| 116 | 21 | 30 | **Төв, суурин газрын 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай**<br>**2020-08-25**<br>**Дугаар 2020_69**<br>3. "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК, "Шарын гол" ХК-ийн үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангахад шаардлагатай дизелийн түлш, шатахууны нөөцийг бүрдүүлэн уурхайн хөрс хуулалт, их засварын ажлыг хугацаанд нь хийх, нүүрсний бэлэн нөөцийг хэвийн хэмжээнд байлгах, аваар ослын үед хэрэглэх техник, тоног төхөөрөмж, сэлбэг | 10 сарын 23-ны өдрийн байдлаар "Багануур" ХК-ийн уурхайн өвөлжилтийн бэлтгэл ажил 88%, дизель түлшний нөөц 740,000 л, бэлэн нүүрсний нөөц 850 мянган тонн байгаа бол "Шивээ-Овоо" ХК-ийн өвөлжилтийн бэлтгэл ажлын гүйцэтгэл 89%, дизель түлшний нөөц 48,448 л бэлэн нүүрсний нөөц 180 мянган тонн байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгслийн нөөц бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал (П.Ганхүү)-д тус тус даалгасугай. | | | |
| 117 | 21 | 31 | 6. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн түүхий эд (мидлинг)-ийн нөөцийг үйлдвэрийн хашаанд 300.000 тонн, Төв аймаг дахь дундын агуулахад 700.000 тонныг татан төвлөрүүлж, 120.000 тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэх арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Ганхуяг)-д тус тус даалгасугай. | Засгийн газрын 2018 оны 387 дугаар тогтоол, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 42 дугаар тогтоол болон "Таван толгой түлш" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 14 дүгээр тогтоол, 2019 оны 3 дугаар сарын 01-ны өдөр байгуулсан "Таван толгой түлш" ХХК-тай байгуулсан ЭТТ-2019/172 тоот "Нэмэлт санхүүжилт олгох гэрээ"-нд 76 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нийгмийн хариуцлагын хүрээнд, эргэн төлөх нөхцөлтэй өгөхөөр заасан. Гүйцэтгэх захирлын 2019 оны 1 дүгээр сарын 29-ны өдрийн А/33 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж санхүүжилтийг үйл ажиллагааг хянаж ажиллаж байна. 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 7 удаагийн санхүүжилтээр 76 тэрбум төгрөгийг олгосон. Ажлын хэсэг гэрээ дүгнэх, ТУЗ-д тайлан танилцуулахаар ажиллаж байна.<br>Төв аймгийн Сэргэлэн сумын Гүн бүрдийн аманд 12 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмших гэрээ байгуулж, дундын бус байгуулсан. Уг дундын бүсэд 427,457 тонн түүхий эд /мидлинг/-ийн нөөцийг татан төвлөрүүлээд байна.<br>2020 оны 01 дүгээр сарын 01 ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 14 ний өдрийн байдлаар Өмнөговь аймгийн Цогтцэций суман дахь "Энержи Ресурс" ХХК-ийн Ухаа худгийн уурхайгаас өөрийн авто баазын 60 Шакманаар болон 815 гэрээт тээвэрлэгчдээр 306,510 тонн түүхий эд /мидлинг/-ийг Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах дундын бүсэд татан төвлөрүүлсэн. Хүйтний улирал эхэлсэнтэй болон Коронавирус "Ковид-19" цар тахлын улмаас хөл хорио тогтоосонтой холбогдуулан 2020 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 5-10 гэрээт тээвэрлэгчээр түүхий эдийн тээвэрлэлтийг явуулж байна. Өөрийн автобаазын Шакман машинууд нь Дундын бүсээс Баруун, Зүүн бүсийн үйлдвэр рүү түүхий эд мидлингийн татан авалтыг хийж байна. Нөөц: Дундын бүс- 382,934тонн, Зүүн бүс-17,454тонн, Баруун бүс-58,296.2 тонн, Нийт: 458,684 тонн мидлингийн нөөцтэй байна.<br>2020 оны 11 дүгээр сарын 01- ний өдрийн байдлаар нийт 112 ширхэг агуулах болон хангамжийн баазад нийт 95,260 тонн сайжруулсан шахмал түлш нөөцлөснөөс Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Зорилтот өрхийг сайжруулсан түлшээр хангах тухай" А/30 дугаар захирамжийн хүрээнд дэлхий нийтэд өндөр хурдацтай тархаж байгаа Коронавируст "COVID-19"-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | зорилгоор зорилтот бүлгийн өрхүүдийг сайжруулсан шахмал түлшээр хангах арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дүүргүүдийн Онцгой комисс, Нийслэлийн Нийгмийн халамжийн газар, Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар, "Таван толгой түлш" ХХК хамтран зохион байгуулж 10 000 тонн түлш олгосон. Түүнчлэн түлшний үнийг хямдруулсантай холбогдуулан үе шаттайгаар нөөц агуулахаас түгээлт хийж байна. 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 56,265 тонн шахмал түлшний нөөцтэй байна. | | |
| 118 | 21 | 32 | 13. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн түүхий эд (мидлинг)-ийн тээвэрлэлтэд шаардагдах нэмэлт хөрөнгө болон нийслэлийн зүүн бүсэд шинээр баригдаж буй сайжруулсан шахмал түлшний үйлдвэрээс Налайх-Чойрын чиглэлийн хатуу хучилттай авто зам хүртэлх 4 км урттай сайжруулсан шороон зам барих, бусад дэд бүтцийн ажлуудад шаардагдах хөрөнгийг холбогдох зураг төсөв, тооцоо, судалгаанд үндэслэн зохих журмын дагуу санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Баярсайхан), "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Ганхуяг)-д тус тус даалгасугай. | Засгийн газрын 2018 оны 387 дугаар тогтоол, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 42 дугаар тогтоол болон "Таван толгой түлш" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 14 дүгээр тогтоол, 2019 оны 3 дугаар сарын 01-ны өдөр байгуулсан "Таван толгой түлш" ХХК-тай байгуулсан ЭТТ-2019/172 тоот "Нэмэлт санхүүжилт олгох гэрээ"-нд 76 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нийгмийн хариуцлагын хүрээнд, эргэн төлөх нөхцөлтэй өгөхөөр заасан. "Таван толгой түлш" ХХК-иас 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанд холбогдох санхүүжилт болон үйл ажиллагааны талаарх тайлан мэдээг танилцуулсан. "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2020 оны 09 сарын 14-ний өдрийн 37 дугаар тогтоолын 2 дугаар заалтад "...шаардагдах санхүүжилтийг тооцоо судалгаанд үндэслэн гэрээ байгуулсны үндсэн дээр санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт зөвшөөрсүгэй..."гэж заасан. "Эрдэнэс тавантолгой" ХК болон "Таван толгой түлш" ХХК хооронд ЭТ/581 дугаартай "Нэмэлт санхүүжилт"-ийн гэрээний дагуу Нийслэлийн зүүн бүсэд шинээр баригдаж буй сайжруулсан шахмал түлшний үйлдвэрээс Налайх-Чойрын чиглэлийн хатуу хучилттай авто зам хүртэлх 4 км урттай сайжруулсан шороон зам барих, бусад дэд бүтцийн ажлуудад шаардагдах хөрөнгийг шийдвэрлэж, хуваарийн дагуу санхүүжилтийг олгож байна. Үүнээс Үйлдвэрийн бүсээс Налайх-Чойрын А0101 улсын чанартай автозам хүртэлх 5,091 км хайрган хучилттай автозамын ажлыг хийж дуусган, үндсэн түүхий эдийн авто тээврийн татан авалт хийгдэж байна. | 100% | |
| 119 | 22 | 33 | **Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай**<br>**2020-09-23**<br>**Дугаар 2020_113**<br>2. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын суурь бүтцийн инженерийн | Таван толгойн ордыг түшиглэн Цахилгаан станц, нүүрс баяжуулах үйлдвэр, нүүрс химийн үйлдвэр, ус хангамжийн цогцолбор, Таван толгой- Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, авто зам, Таван толгой –Ханги- Мандал чиглэлийн авто зам зэрэг төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна.<br><br>Гэвч төсөл хэрэгжүүлэгч нарт Тавантолгойн ордын нэгдсэн гадаргын төлөвлөлтийн зураг байхгүйгээс үүдэлтэй улсын нэгдсэн санд | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | нарийвчилсан зураг төсөл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэсний үндсэн дээр барилгын ажлыг 2020 онд багтаан эхлүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | бүртгэлтэй нөөцийн биет дээр орон нутаг болон бусад төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд дэд бүтэц, барилга байгууламжийг барьж байгаа нь уул уурхайн үйлдвэрлэлд хүндрэл үүсгэхээр байна.<br><br>Иймд Тавантолгойн ордыг түшиглэн баригдах дэд бүтэц, уулын үйлдвэр зэргийг багтаасан гадаргын зураг төслийг боловсруулах Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нарын 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/198, А/139 дүгээр хамтарсан тушаалаар байгуулж, санал боловсруулж, эрх ашиг нь хөндөгдөх талуудад танилцуулж, нэгдсэн байр сууринд хүрсний дагуу Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 51 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. Дээр дурдсан төлөвлөлтөд авантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын асуудал тусгагдсан болно. | | |
| 120 | 23 | 34 | **Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, зөвшөөрөл олгох, төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээний тухай**<br>**2020-09-23**<br>**Дугаар 2020_117**<br>3. "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн хувьцааг хаалттай хүрээнд нэрлэсэн үнээр худалдах замаар нийт хувьцааны 66 хувийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д, 34 хувийг "Монголын төмөр зам" ТӨХК-д тус тус эзэмшүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т, цаашид "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг "Монголын төмөр зам" ТӨХК-д эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу үе шаттай шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн | Засгийн газрын 2020 оны 117 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн ТУЗ-өөс 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 39 дүгээр тогтоолыг баталж, "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн 66 хувийг эзэмших, гэрээ хэлцэл байгуулахыг Гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн. Үүний дагуу дараах гэрээ, хэлэлцээрүүдийг байгуулсан. Үүнд:<br>"Монголын төмөр зам" ТӨХК-тай "Хувьцаа эзэмшигчдийн гэрээ", "Урьдчилгаа санхүүжилтийн гэрээ"-г тус тус байгуулсан. Тус компанийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх, Засгийн газрын тогтоолын хэрэгжүүлэх зорилгоор дараах санхүүжилтүүдийг хийгээд байна. Үүнд: Урьдчилгаа санхүүжилтээр 58 тэрбум төгрөг, Нэмэлт санхүүжилтээр 75 тэрбум төгрөг<br>Тус компанийн зүгээс үлдэгдэл санхүүжилтийг өөрийн эзэмшлийн хувь, хэмжээнд тулгуурдан шинээр үүсгэн байгуулагдаад байгаа "Зүүнбаян төмөр зам" ХХК-д үе шаттай олгохоор төлөвлөж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | удирдах зөвлөл (Б.Артур), "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Баярсайхан)-д тус тус даалгасугай. | | | |
| 121 | 24 | 35 | **Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**<br>**2020-09-30**<br>**Дугаар 2020_125**<br>2. Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт даалгасугай. | Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тавдугаар хэсгийн 5.1.8-д "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ." гэсэн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтран баталсан 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 167, А/698, А/336, А/242 дугаартай хамтарсан тушаал гарсан. Дээрх тушаалын хүрээнд 2021 оны төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөн ажиллаж байна. | 100% | |
| 122 | 25 | 36 | **Сайжруулсан шахмал түлшний талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2020-12-02**<br>**Дугаар 2020_200**<br>1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан нийслэлийн гэр хорооллын иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сайжруулсан шахмал түлшний нэг тонн тутмын үнийг 50 хувиар хөнгөлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Таван толгой түлш" ХХК-ийн Төлөөлөн удирдах | Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээг баталсан.<br>Уг тогтоолын 6 дахь заалтаар "Сайжруулсан шахмал түлшний талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 200 дугаар тогтоолын 1 дэх заалтыг "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан нийслэлийн гэр хорооллын иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сайжруулсан шахмал түлшний нэг тонн тутмын үнийг 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрөөс 50, 12 дугаар сарын 14-ний өдрөөс 25, нийт 75 хувиар хөнгөлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Тавантолгой түлш" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ж.Батбаясгалан)-д тус тус даалгасугай" гэж өөрчлөн найруулсан.<br>"Таван толгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлшийг Засгийн газрын 200 дугаар тогтоолын дагуу 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 13-ны өдрийг хүртэл гэр хорооллын иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор<br>50 хувийн хөнгөлөлттэй үнээр, 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс Засгийн Газрын 211 дүгээр тогтоолын дагуу 75 хувийн хөнгөлөлттэй үнээр борлуулж эхэлсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зөвлөл (Ж.Батбаясгалан)-д тус тус даалгасугай. | 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Сайжруулсан шахмал түлшний 679 борлуулалтын цэгээр дамжуулан 135,776.8 тонн түлшийг хөнгөлөлттэй үнээр борлуулсан. | | |
| 123 | 25 | 37 | 2. Энэ тогтоолын 1-д заасан хугацаанд хөнгөлөлттэй үнээр олгосон сайжруулсан шахмал түлшний үнийн зөрүүг гүйцэтгэлээр нь тооцож нөхөн санхүүжүүлэхийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ), гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх нарт тус тус даалгасугай. | 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хөнгөлөлттэй үнээр борлуулсан 135,776.8 тонн түлш сайжруулсан шахмал түлшний үнийн зөрүү болох 15,7 тэрбум төгрөгийг гүйцэтгэлээр нь “Эрдэнэс тавантолгой” ХК санхүүжилтийг олгосон. Цаашид сар бүрийн гүйцэтгэл тоо мэдээг үндэслэн үнийн зөрүүг санхүүжүүлнэ. | 100% | |
| 124 | 25 | 38 | 3. Сайжруулсан шахмал түлшний нөөц, борлуулалт, үлдэгдлийн хэмжээнд өдөр тутамд хяналт тавьж, хомсдол үүсгэхгүй, иргэдэд хүртээмжтэй байхаар түгээлтийг зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт, сайжруулсан шахмал түлшний борлуулалтын нэг тонн тутамд олгох мөнгөн урамшууллыг хэвээр үргэлжлүүлж олгохыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо (Д.Сарангэрэл)-нд тус тус үүрэг болгосугай. | 2020 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний Баруун бүсийн 4 үйлдвэрийн 12 шугам, Зүүн бүсийн 3 үйлдвэрийн 7 шугам хэвийн горимоор ажиллаж байна.<br>Баруун, зүүн бүсийн үйлдвэрүүд нь өдөрт дунджаар 3500-4800 тонн түлш үйлдвэрлэж байгаа бөгөөд түлшний нөөц одоогийн байдлаар 65 агуулах хангамжийн баазуудад 18,008 тонн, Үйлдвэрийн бүсийн гадна талбайд 11,276 тонн, нийт **29,284** тонн байна.<br>Өдрийн борлуулалтын дундаж хэмжээ: 3500-4000 тонн байна. Сайжруулсан шахмал түлшний түгээлтийг дотоод тээврийн компаниудын нийт 522 автомашинаар зохион байгуулан ажиллаж байна. | 100% | |
| 3.ё. Ерөнхий сайдын захирамж | | | | | | |
| 125 | 1 | 1 | **Ажлын хэсэг байгуулах тухай“ Гацууртын алтны үндсэн ордыг ашиглах төсөл”-ийн хөрөнгө оруулагчтай Хөрөнгө оруулалтын** | Засгийн газар 2016 онд шинээр байгуулагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 20 болон 21 дүгээр захирамжуудаар шинэ ажлын хэсэг байгуулагдаж, орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг бэлтгэн хөрөнгө оруулагч талд | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **гэрээбайгуулах талаар хэлэлцээ хийх үүрэг бүхий 2017-01-25 Дугаар 2017_20** 2. Хэлэлцээний үр дүнг эцэслэн тохирсон гэрээний төслийн хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай. | хүргүүлсэн. Гацууртын үндсэн ордыг ашиглах төслийн хувьд Засгийн газрын зүгээс төрийн эзэмшлийн 34 хувийг Ашигт малтмалын тухай хуульд тусгайлан заасан "ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр"-өөр орлуулах зарчмыг баримтлан ажиллаж байна. Шинэ ажлын хэсгийн хүрээнд бэлтгэсэн гэрээнүүдэд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах нөхцөлүүдийг бүрдүүлж, оруулж өгөхийн зэрэгцээ төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох өөрчлөлтүүд орсон болно.<br>Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс Гацууртын ордын нөөцийг дахин тодотгох шаардлагыг "Сентерра Гоулд Монголиа" ХХК-д тавьсаны дагуу нөөцийг шинэчлэн тодотгох ажлыг хийж байна. Үүний дараа энэхүү төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах бөгөөд уг ТЭЗҮ-д төслийн хөрөнгө оруулалт болон эдийн засгийн тооцоо өөрчлөгдөж болзошгүй тул Хөрөнгө оруулалтын болон Орд ашиглах гэрээний зарим заалтыг эргэн харахаар ойлголцолд хүрсэн.<br>Өмнөх хэлэлцээний үеэр энэхүү төсөлд төрийн эзэмших ашигт малтмал ашигласны тусгай төлбөрийн хувь хэмжээ 3 хувиар яригдаж байсныг нэмэгдүүлэхээс гадна орон нутагт зайлшгүй шаардлагатай зарим асуудлыг шийдвэрлүүлэх саналыг тусгай зөвшөөрөл эзэмшигч буюу хөрөнгө оруулагч талд тавиад байна.<br>Гацууртын алтны ордын тусгай зөвшөөрлийн асуудал нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.03.15-ний өдрийн №128/ШШ2019/0180 дугаартай шийдвэрээр ордын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг АМГТГ-т даалгасан байна. | Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 126 | 2 | 2 | **Ажлын хэсэг байгуулах тухай /Гацууртын алтны үндсэн ордю 2017-01-25 Дугаар 2017_21** 2. Хэлэлцээний явц, үр дүн, орд ашиглах гэрээний төслийн талаар тухай бүр Засгийн газарт танилцуулж, гэрээг 2017 оны 3 дугаар сард багтаан байгуулах ажлыг удирдан зохион байгуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. | Засгийн газар 2016 онд шинээр байгуулагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 20 болон 21 дүгээр захирамжуудаар шинэ ажлын хэсэг байгуулагдаж, орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг бэлтгэн хөрөнгө оруулагч талд хүргүүлсэн. Гацууртын үндсэн ордыг ашиглах төслийн хувьд Засгийн газрын зүгээс төрийн эзэмшлийн 34 хувийг Ашигт малтмалын тухай хуульд тусгайлан заасан "ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр"-өөр орлуулах зарчмыг баримтлан ажиллаж байна. Шинэ ажлын хэсгийн хүрээнд бэлтгэсэн гэрээнүүдэд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах нөхцөлүүдийг бүрдүүлж, оруулж өгөхийн зэрэгцээ төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох өөрчлөлтүүд орсон болно.<br>Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс Гацууртын ордын нөөцийг дахин тодотгох шаардлагыг "Сентерра Гоулд Монголиа" ХХК-д тавьсаны дагуу | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | нөөцийг шинэчлэн тодотгох ажлыг хийж байна. Үүний дараа энэхүү төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах бөгөөд уг ТЭЗҮ-д төслийн хөрөнгө оруулалт болон эдийн засгийн тооцоо өөрчлөгдөж болзошгүй тул Хөрөнгө оруулалтын болон Орд ашиглах гэрээний зарим заалтыг эргэн харахаар ойлголцолд хүрсэн. Өмнөх хэлэлцээний үеэр энэхүү төсөлд төрийн эзэмших ашигт малтмал ашигласны тусгай төлбөрийн хувь хэмжээ 3 хувиар яригдаж байсныг нэмэгдүүлэхээс гадна орон нутагт зайлшгүй шаардлагатай зарим асуудлыг шийдвэрлүүлэх саналыг тусгай зөвшөөрөл эзэмшигч буюу хөрөнгө оруулагч талд тавиад байна. Гацууртын алтны ордын тусгай зөвшөөрлийн асуудал нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.03.15-ний өдрийн №128/ШШ2019/0180 дугаартай шийдвэрээр ордын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг АМГТГ-т даалгасан байна. | | |
| 127 | 3 | 3 | **Ажлын хэсэг байгуулах тухай /Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгойн зэс-алтны ордын төслийн хэрэгжилттэй холбогдуулан 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр хөрөнгө оруулагч талтай байгуулсан "Нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон Хувь нийлүүлэ 2018-02-21 Дугаар 2018_27**<br>3.. Оюутолгой төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Өмнийн говийн хөгжил, дэд бүтцийн асуудлаар дэд ажлын хэсэг байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт, эрчим хүчний асуудлаар дэд ажлын хэсгийг байгуулахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэнд тус тус хариуцуулж ажлын явц, үр дүнг тухай бүр танилцуулж байхыг даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/74 дүгээр тушаалаар Өмнийн говийн хөгжил, дэд бүтцийн төлөвлөлтийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсгээс Өмнийн говийн хөгжил, дэд бүтцийн судалгааг хийх шаардлагатай гэж үзсэн бөгөөд Үндэсний хөгжлийн газрын захиалгаар уг ажлын судалгаа хийгдэж байна. | 70% | |
| 4.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 128 | 1 | 1 | **2015 оны 03 дугаар сарын 30-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2015-03-30 Дугаар 2015_18** | Гацууртын алтны ордын тусгай зөвшөөрлийн асуудал нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.03.15-ний өдрийн №128/ШШ2019/0180 дугаартай шийдвэрээр ордын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг АМГТГ-т даалгасан байна. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, Цаг | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | XXII.2. . Гацууртын ордын хөрөнгө оруулагчтай хийж байгаа хэлэлцээний явцын талаар Үүнтэй холбогдуулан хэлэлцээг эцэслэх чиглэлээр шуурхай ажиллаж, явц, үр дүнг тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав. | | хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 129 | 2 | 2 | **2015 оны 05 дугаар сарын 4-ний өдөр 24 дүгээр тэмдэглэл 2015-05-04 Дугаар 2015_24** XXI. 2. . Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Сентерра гоулд Монголиа" ХХК-тай тус ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээний талаар хийж байгаа хэлэлцээний явцын тухай Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан уг хэлэлцээг 2015 оны 5 дугаар сарын 25-ны дотор дуусгахыг Ажлын хэсэг (Г.Тэмүүлэн)-т даалгав. | Гацууртын алтны ордын тусгай зөвшөөрлийн асуудал нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.03.15-ний өдрийн №128/ШШ2019/0180 дугаартай шийдвэрээр ордын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг АМГТГ-т даалгасан байна. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 130 | 3 | 3 | **2016 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2016-04-18 Дугаар 2016_22** XXYIII.4. . Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах талаар хийж байгаа хэлэлцээний явцын талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хэлэлцээг цаашид үргэлжлүүлж, 2016 оны 4 дүгээр сард багтаан орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахыг Ажлын хэсэг (Р.Жигжид)-т даалгав. | Гацууртын алтны ордын тусгай зөвшөөрлийн асуудал нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.03.15-ний өдрийн №128/ШШ2019/0180 дугаартай шийдвэрээр ордын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг АМГТГ-т даалгасан байна. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 131 | 4 | 4 | **2018 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 15 дугаар тэмдэглэл** | Улсын Их Хурлын Байнгын хорооны 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн "Чиглэл өгөх тухай" 32 дугаар тогтоолд "Монгол Улсын Засгийн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **2018-03-27**<br>**Дугаар 2018_15**<br>XXIX.14.. Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудалтай холбогдуулан хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх үндэслэл, тооцоог гаргасны үндсэн дээр аж ахуйн нэгж байгуулах тухай шийдвэрийн төсөл боловсруулан хууль тогтоомжийн хүрээнд Монголбанк болон яамдын саналыг авч, Засгийн газрын хуралдаанд зохих журмын дагуу оруулж хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.69 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд 2019 онд багтаан дотооддоо алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ү.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд чиглэл болгосны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А-303 тогтоолоор Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлын цогц төлөвлөгөө боловсруулах, холбогдох тооцоо судалгаа хийж танилцуулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын хуралдаанаар алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлаар хэлэлцэж "Стратегийн ач холбогдолтой том төслийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тэмдэглэл гарсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлаар "Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах тухай" зөвлөмж гарсан. Тус зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Тагнуулын ерөнхий газраас Засгийн газрын хэрэг эрхлэх газарт алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг нууцад хамруулах асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар зохих журмын дагуу хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх тухай албан бичгийг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүргүүлэн Засгийн газрын 2019.05.17-ны өдрийн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 196 дугаар тогтоолоор Засгийн газрын 2017.9.13-ны өдрийн 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамруулж нэн чухал асуудлаар анхааран ажиллаж байна./<br>"Алт 2" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, алтны олборлолт, баяжуулалт, цэвэршүүлэлтэд бүрэн хяналт тавьж, хууль бус алтны экспортыг зогсоох, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх төгрөгийн ханшийг тогтворжуулахад түлхэц үзүүлэх зорилгоор Эрдэнэс Алт Ресурс ХХК-ыг 2018 оны 3 сард ("Эрдэнэс Монгол" ХХК-ын охин компани) 100 хувь төрийн өмчит компани хэлбэрээр байгуулсан.<br>Эрдэнэс Алт Ресурс ХХК нь байгаль орчинд халгүй, орчин үеийн инновацийн технологи ашиглан жилд 50 тн алт, 25 тн мөнгө цэвэршүүлж олон улсын стандартад нийцсэн 99.99 хувийн сорьцтой алт, мөнгөн гулдмай, үрэл, хөрөнгө оруулалтын гулдмай, гоёл чимэглэлийн хайлш, электрон техникийн салбарт зориулсан бэлдэц бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай "Алт цэвэршүүлэх үйлдвэр"-ийг барьж, ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа бөгөөд алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 196-р тогтоолоор Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хүрээнд стратегийн ач холбогдол бүхий төслийн жагсаалтад хамруулсан;<br>2. Нийслэлийн засаг даргын захирамжийн 2019 оны 08 сарын 27-ны өдрийн А/883 тоот шийдвэрээр үндэслэн Улаанбаатар хотын Сонгинохайран дүүргийн 32-р хороонд 4 га газрыг үйлдвэрлэлийн барилга байгууламж барих зориулалтаар авсан;<br>3. Төслийн Байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийн, дүгнэлт гаргасан;<br>4. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 09 сарын 09-ны өдрийн СТР/19-01-01 тоот дүгнэлтээр төслийн Техник, эдийн засгийн үндэслэлийг баталсан;<br>5. Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Бүгд найрамдах Казахстан улсад хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд "Алт цэвэршүүлэх үйлдвэр"-ийг түлхүүр хүлээлцэх нөхцөлөөр барих гэрээнд 2019 оны 10 дугаар сарын 11-ны өдөр гарын үсэг зурсан;<br>6. - УУХҮ-ийн сайдын 2020.03.02-ний өдрийн "Тусгай зөвшөөрөл олгох тухай" А/28 дугаар тушаалаар "Эрдэнэс Алт Ресурс" ХХК-д үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх тусгай зөвшөөрлийг олгосон. | | |
| 132 | 5 | 5 | **2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл 2018-07-04 Дугаар 2018_29**<br>XX.4. 2. . Байгалийн өнгөт чулууг хууль бусаар олборлох, улсын хилээр гаргахыг хориглох асуудлыг судлах, байгалийн өнгөт чулууны жишиг үнэлгээг тогтоолгохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт; | Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2014 оны 220 дугаар тогтоол, 2015 оны 102, 103, 488 дугаар тогтоол , 2016 оны 81 дүгээр тогтоолын дагуу уул уурхайн экспортын дараах бүтээгдэхүүнүүдийн олон улсын зах зээлийн үнийг Сангийн сайд болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын хамтарсан 2018 оны 200/А/177 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийтэд мэдээлж байгаа болно. Үүнд: Цайр, зэс, цагаан тугалга, хар тугалга, хөнгөн цагаан, молибдени, алт, мөнгө, нүүрс, төмөр, жонш, гянтболдын хүдэр, манганий хүдэр зэрэг багтаж байна. Мөн Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамнаас Монгол Улсад үнэт металл, эрдэнийн чулуугаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүхий эдээр хангах болон худалдаалах зэрэг асуудлуудыг олон улсын чиг хандлагад нийцүүлэх зорилгоор "Үнэт металл, эрдэнийн чулууны үйлдвэрлэл, түүний эргэлтийн тухай" хуулийн төслийг үзэл баримтлалын төслийн хамтаар боловсруулж, үзэл баримтлалын төслийг батлуулахаар Хууль, зүй дотоод хэргийн яаманд 2018.07.25-ны өдрийн 01/2026 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 70% | |
| 133 | 6 | 6 | **2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр 35 дугаар тэмдэглэл 2018-08-22 Дугаар 2018_35** | УУХҮ-ийн сайдын 2018.04.20-ны өдрийн А/86 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг "Тавантолгой" ХК нь "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас нүүрс олборлон ашигласан асуудлыг хянан үзэж, дүгнэлт гаргах, цаашид авч | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | XIX.6. . “Тавантолгой” ХК нь “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн уурхайн талбайгаас хууль бусаар нүүрс олборлосон эсэх асуудлыг шалгах үүрэг бүхий Ажлын хэсгийн дүнг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав. -Уул уурхайн компаниудын олборлолтын үйл ажиллагаа уулын ажлын төлөвлөгөө, тайлан, нөөцийн хөдөлгөөн болон ТЭЗҮ-ийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих, гарсан зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгуулах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Шадар сайд Ө.Энхтүвшин, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт; | хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах ажлын хүрээнд 2018.04.19-нөөс 05.06-ны өдрүүдэд дараах үе шаттай ажлуудыг гүйцэтгэн, дүгнэлт, саналыг боловсруулсан. Үүнд:<br>1. Тусгай зөвшөөрлийн солбилцлын удаа дараагийн өөрчлөлт, хөдөлгөөн нь тусгай зөвшөөрлийн хил давж нүүрс олборлосон асуудлын үндсэн үүсэл шалтгаан биш болохыг тогтоосон.<br>2. Хил давж олборлогдсон нөөцийн гурван удаагийн тооцооллын зөрүү 0.3%-3.5% байгаа нь тус хоёр аж ахуй нэгжийн харилцан зөвшөөрсөн нөөцийн тооцоо үнэн зөв байх боломжтой гэж үзэв. (а.“Тавантолгой” ХК болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-иудын хамтарсан ажлын тооцоо; б.Уламжлалт арга буюу блокын аргаар тооцоолсон хяналтын тооцоо; в.Хөндлөнгийн тусгай зөвшөөрөл бүхий маркшейдерийн компаниар хийлгэсэн хэмжилт, хяналтын тооцоо)<br>3.Ажлын хэсгийн томилолтын үед олборлолтонд өртсөн нүүрсний мөргөцөгүүдээс авсан хяналтын дээжлэлт, лабораторийн шинжилгээний үр дүн нь өмнө нь хийгдсэн “Тавантолгой” ХК болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-иудын хамтарсан ажлын хэсгийн тайланд тусгагдсан лабораторийн шинжилгээний үр дүнгүүдтэй ойролцоо үр дүнг илэрхийлж байна.<br>4.Хил давж олборлосон он цагийг нарийвчлан тогтоох ажлыг гүйцэтгэхийн тулд агаар, сансрын зургийг он тус бүрээр гаргуулж, холбогдох суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэх.<br>Мөн Монгол улсын Ерөнхий сайдын чиглэл болгосны дагуу Сангийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 109 тушаал болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 01/174 тоот удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Орон нутгийн өмчит "Тавантолгой" ХК нь өөрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас хил даван "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд нэвтэрч, их хэмжээний нүүрс олборлосон гэх асуудлыг шалгаж, дүгнэлт гаргах, холбогдох арга хэмжээ авах, санал боловсруулах зорилго бүхий Ажлын хэсэг газар дээр нь хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br><br>Хяналт шалгалтаар “Тавантолгой” ХК нь уурхайн 4 дүгээр амны зүүн, зүүн хойд хэсэгт IVа давхаргын таазнаас олборлолт явуулсан, 4 дүгээр амны хойд хэсэгт IVа давхаргын таазнаас олборлолт явуулсан, 4 дүгээр амны зүүн хойд хэсэгт IVб давхаргын хэсэгт олборлолт явуулсан, 4 дүгээр амны баруун хэсэгт IVа давхаргын хэсгүүдээр зааглагдан нийт таван хэсэгт 340,092.98 тонн нүүрс “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайгаас олборлосныг мэргэжлийн | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | итгэмжлэгдсэн байгууллага "Хос Алтан Пирамид" ХХК-ийн хийсэн маркшейдерийн хэмжилтээр тогтоосон байна.<br>"Эрдэнэс-Тавантолгой" ХК нь өөрийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь уурхайн талбайн аюулгүй байдал, шав тэмдгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалаагүйгээс орон нутгийн өмчит "Тавантолгой" ХК-ийн ашиглалтын MV-016882, MV-011943 тоот тусгай зөвшөөрлийн хилийг даван нүүрс олборлох үйл ажиллагаа эхлэхэд таслан зогсоох арга хэмжээ авч ажиллаагүй нь хууль бусаар нүүрс олборлох нөхцөлийг бүрдүүлсэн байна гэж Ажлын хэсэг дүгнэсэн.<br>Авлигатай тэмцэх газрын 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр 09/236 тоот албан бичгээр "Тавантолгой" ХК, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хамтарсан баг 2015, 2016 онуудад 3 удаагийн хэмжилт хийж, "Тавантолгой" ХК нь "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайгаас 268.3 мян.тн нүүрс олборлосон, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны а/86 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг "Их нэмүүн" ХХК-аар хэмжилт хийлгэхэд "Тавантолгой" ХК нь "Эрдэнэс-Тавантолгой" ХК- ийн тусгай зөвшөөрлийн талбайгаас 267.68 мян.тн нүүрс олборлосон, МХЕГ-ын даргын 2018 оны 01/174 тоот удирдамжаар батлагдсан Ажлын хэсэг "Хос Алтан Пирамид" ХХК-аар хэмжилт хийлгэхэд "Тавантолгой" ХК нь "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайгаас 340,09298 тонн нүүрс олборлосон тухай зөрүүтэй 3 тайланг гарсан байгааг буруушаасан. Дээрх зөрүүтэй байдлаас үүдэн хөндлөнгийн маркшейдерийн байгууллагаар хэмжилт хийлгэн нэгдсэн үнэн зөв үндэслэл бүхий тооцоолoлтой дүгнэлт, тайлан гаргуулах тухай албан хүсэлтийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт ирүүлсэн байна.<br>Уг хүсэлтийн дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 29-ний А/21 дугаар тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Монголын Маркшейдерийн холбоо, "Тавантолгой" ХК, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн төлөөллийг оролцуулсан хөндлөнгийн геологи, маркшейдерийн хэмжилт хийлгэн нэгдсэн үнэн зөв үндэслэл бүхий тооцоололтой дүгнэлт, тайлан гаргуулах үүрэг бүхий Ажлын хэсэг болон дүгнэлт, тайлан гаргах үүрэг бүхий геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг тус тус байгуулан ажилласан.<br>Хөндлөнгийн тайлан гаргуулах үүрэг бүхий ажлын хэсэг маркшейдерийн хяналтын хэмжилт хийх байгууллагыг сонгон шалгаруулах ажлын даалгаврыг боловсруулан сонгон шалгаруулах Ажлын хэсэгт хүргүүлснээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд Тендерийн бичиг | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | баримтыг боловсруулан 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдөр цахим тендер зарласан бөгөөд 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр 11:30 цагт нээхэд аж ахуйн нэгжүүдээс тухайн тендерт оролцох санал ирүүлээгүй тул дахин 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 02-ны хооронд 7 хоногийн хугацаатай зарласан боловч мөн тухайн тендерт оролцох саналыг ирүүлээгүй болно,<br>Иймд хөндлөнгийн маркшейдерийн хяналтын хэмжилтийг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах боломжгүй болсон тул Ажлын хэсгээс хуульд заасан холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар Авлигатай тэмцэх газарт 2019 оны 04 дүгээр сарын 10-ны 03/1236 дугаар албан бичгийг хүргүүлэн ажилласан болно.<br>Улмаар Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газраас Таван толгой" ХК нь Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг зөрчин "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн ашиглалтын лицензтэй талбайд хөрс хуулалтын үйл ажиллагаа явуулж, 268.3 мянган тонн нүүрс олборлосон гэх эрүүгийн 180200174 дугаартай хэрэгт шинжээч томилуулах хүсэлтийг тус яаманд ирүүлсний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Гаалийн ерөнхий газар зэрэг байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн албан хаагчид шинжээчийн бүрэлдэхүүнд ажиллаж, мөрдөгчийн асуулгын дагуу холбогдох дүгнэлтийг боловсруулж, Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт хүргүүлсэн.<br>Мөн уг шинжээчдийн бүрэлдэхүүнд хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар "Аглаг уул" ХХК ажиллаж, холбогдох хэмжилтийг хийж тайланг боловсруулсан. | | |
| 134 | 6 | 7 | XIX.6. . -"Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн уурхайн талбайгаас хууль бусаар олборлосон нүүрсний хэмжээг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар эцэслэн нарийвчлан тогтоолгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай зохион байгуулж шийдвэрлэх, цаашид компанийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу явуулж, уурхайн олборлолт, экспортын үйл ажиллагаанд хяналт тавьж байхыг "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Г.Нандинжаргал)-д, | Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газраас Таван толгой" ХК нь Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг зөрчин "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн ашиглалтын лицензтэй талбайд хөрс хуулалтын үйл ажиллагаа явуулж, 268.3 мянган тонн нүүрс олборлосон гэх эрүүгийн 180200174 дугаартай хэрэгт шинжээч томилуулах хүсэлтийг тус яаманд ирүүлсний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Гаалийн ерөнхий газар зэрэг байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн албан хаагчид шинжээчийн бүрэлдэхүүнд ажиллаж, мөрдөгчийн асуулгын дагуу холбогдох дүгнэлтийг боловсруулж, Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт хүргүүлсэн.<br>Мөн уг шинжээчдийн бүрэлдэхүүнд хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар "Аглаг уул" ХХК ажиллаж, холбогдох хэмжилтийг хийж тайланг боловсруулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт; | | | |
| 135 | 7 | 8 | **2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2018-11-28 Дугаар 2018_49** 2.2. нүүрсний ачилт, тээвэрлэлтийг авто замын даац, техникийн бүрэн байдал, аюулгүй ажиллагааг хангасан автотээврийн хэрэгслийн тоо, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, аж ахуйн нэгж тус бүрийн нүүрс олборлолтын хэмжээ, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадалтай уялдуулан зохион байгуулж, нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт; | Засгийн газрын тэмдэглэлийн дагуу тус яамнаас Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ болон холбогдох төрийн байгууллагуудад хилээр нэвтрэх олон улсын С зөвшөөрлийг замын даац, техникийн бүрэн бүтэн байдал, уурхайн олборлолтын хэмжээтэй уялдуулж олгох тухай чиглэлийг улирал бүр тогтоож өгч байна. Энэхүү ажлын хүрээнд тус яамнаас 2020.03.06-ны өдрийн 03/645, 2020.03.18-ны өдрийн 03/746 тоот албан бичгүүдээр Тавантолгой, Нарийнсухайтын нүүрсний ордуудад үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд хилээр нэвтрэх олон улсын С зөвшөөрлийг хэрхэн олгох саналыг Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-т хүргүүлсэн. Мөн түүнчлэн Засгийн газрын 2019 оны 01 тоот албан даалгавар гарсан бөгөөд уг албан даалгаврын 6-д Уурхайн гадна болон хилийн боомт дээр тээврийн хэрэгслийн үргэлжилсэн дараалал үүсгэхгүйн тулд уурхайн нүүрсний ачилт, зөвшөөрлийн бичгийн олголт, гаалийн бүрдүүлэлтийг хятадын талаас нэг өдөрт хүлээн авах нүүрсний хэмжээ, автомашины тоотой уялдуулан зохицуулж ажиллахыг ГЕГ, "АТҮТ" ТӨҮГ "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Тавантолгой" ХК, "Энержи ресурс" ХХК-иудад даалгасан. | 100% | |
| 136 | 7 | 9 | 2.3. нүүрс худалдах, худалдан авах талаар хоёр улсын аж ахуйн нэгж хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах, шаардлагатай бол нүүрсийг урт хугацаанд тогтвортой худалдах чиглэлээр гэрээг шинэчлэх болон хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлаар Хятадын талтай яриа хэлэлцээ хийхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджав БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хайминтай 2017 оны 10 дугаар сарын 12-нд уулзаж, Гашуунсухайт-Ганцмод боомт дээр үүсээд буй Тавантолгойн бүлэг ордоос нүүрс тээвэрлэж буй хүнд даацын автомашины түгжрэлийн асуудлыг шуурхай шийдвэрлэх боломжийн талаар санал солилцож, Гаалийн шалгалтын хугацааг богиносгон, боомт дээрх татан авалтын хурдыг нэмэгдүүлэх тал дээр анхаарлаа хандуулж өгөхийг хүссэн ба уг асуудлыг нааштайгаар шийдвэрлэхийн төлөө хичээн ажиллахаа элчин сайд илэрхийлсэн.<br>2017 оны 11 дүгээр сарын 02-нд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хайминтай уулзалт хийхдээ Тавантолгойн хэлэлцээрийг үргэлжлүүлж, ажлын хэсгийг байгуулан Хятадын талтай хамтран ажиллах, Гашуунсухайт-Ганцмод боомт дээр үүсээд байгаа нүүрс тээвэрлэж байгаа хүнд даацын автомашины түгжрэлийн асуудлыг шийдвэрлэхэд БНХАУ-ын зүгээс анхаарал тавьж ажиллахыг хүссэн.<br>Монгол Улсын Гадаад хэргийн яам ахалсан Монгол, Хятадын хилийн Ганцмод-Гашуунсухайт боомтод үүссэн нөхцөл байдлыг судлан | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллаж, тухай бүр холбогдох мэдээллийг хүргүүлсэн. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2018 оны 08 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд Улаанбаатар хотод БНХАУ-ын талтай уулзалт хийсэн болно.<br><br>Монгол улсад шинэ төрлийн коронавирус дотоодод тархсантай холбоотойгоор Хятадын талаас хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн тоог багасгаж, Хятадын талд шинжилгээнд хамрагдаагүй жолооч нарыг хилээр нэвтрүүлэхийг зогсоосон. Иймд Монгол Улсаас Хөх хотод суугаа Ерөнхий Консул Б.Гантулга ӨМӨЗО-ны Баяннуур хотын Ганц мод боомтын зөвлөлийн орлогч дарга Хичээлттэй уулзаж, Гашуунсухайт-Ганц мод боомтын нэвтрэлтийг нэмэгдүүлэх талаар ярилцсаны дагуу нүүрсний тээврийн хэрэгслийн жолооч нарыг автобусаар хил нэвтрүүлж, PCR шинжилгээ хийлгэх ажлыг 2020 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлүүлсэн. | | |
| 137 | 8 | 10 | **2018 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл**<br>**2018-12-12**<br>**Дугаар 2018_51**<br>II.2. . "Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Ажлын хэсгийг холбогдох яам, агентлагийн төлөөлөлтэй байгуулан ажиллуулж, хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн нь тогтоогдсон хуулийн этгээдээр нөхөн сэргээлт хийлгэх, тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авч, дүнг 2019 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт даалгав. | Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 77 дугаар тушаалаар байгуулагдсан Улсын хэмжээнд 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар олгогдсон ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн олголт, бүрдүүлсэн баримт материал, тэдгээрийн үндэслэл, тусгай зөвшөөрлийн хэрэгжилтийн явц, байдалд хяналт хийж, санал, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий "Дэд ажлын хэсэг"-т тус яам болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Ашигт малтмал, газрын тосны газраас холбогдох албан тушаалтнууд ажилласан болно.<br>Улмаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанд танилцуулсан болно.<br>Мөн Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй аж ахуйн нэгжүүдтэй хариуцлага тооцох хүрээнд 2018 онд нийт 209 тусгай зөвшөөрөл цуцалсан бол 2019 онд 199 тусгай зөвшөөрлийг цуцалсан байна.<br>Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтад "тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан;" тохиолдолд Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай зохицуулалтыг Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан.<br>Дээр дурдсан хуулийн заалтын дагуу 2019 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Номгон, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дэвсгэрт нийт 20 аж ахуйн нэгжийн 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалж, | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг албадан гүйцэтгүүлэх, цаашид хууль бусаар алт олборлох зөрчил гарахаас сэргийлэх, хууль бусаар алт олборлогч нар талбайг ухахаас хамгаалах зорилгоор 12 дугаар сарын 01-ийг хүртэл цагдаа болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад авах шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлж ажилласан. 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдрөөс 12 дугаар сарын 1-ийг хүртэл Цагдаагийн Ерөнхий газрын Эргүүл тусгай хамгаалалтын тасгийн 160, Архангай аймаг дахь Цагдаагийн газрын 160 нийт 320 алба хаагчид 22 тээврийн хэрэгсэлтэй хамгаалалтыг авч хэрэгжүүлсэн | | |
| 138 | 8 | 11 | II.3. . Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа "Бадрах Энержи" ХХК-ийн "Зөөвч-Овоо" туршилтын үйлдвэрийн түр зориулалтын барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссыг 2018 оны 12 дугаар сард багтаан томилж ажиллуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав. | Тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу хоёр сайдын хамтарсан 2019 оны А/18/16 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан 2019 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр газар дээр ажиллаж, холбогдох дүгнэлтийг боловсруулсан болно. | 100% | |
| 139 | 9 | 12 | **2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл**<br>**2019-01-16**<br>**Дугаар 2019_4**<br>XII.1. . Стратегийн ач холбогдолтой том төслийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан стратегийн ач холбогдолтой том төслүүдийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай танилцуулгыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2019 оны 2 сарын 27-нд Н05/05 тоот зөвлөмж гарсан ба уг зөвлөмжийг үндэслэн Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 196-р тогтоолоор Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хүрээнд стратегийн ач холбогдол бүхий төслийн жагсаалтад "Алт цэвэршүүлэх үйлдвэр барих төсөл"-ийг хамруулсан бөгөөд нууцын зэрэглэлтэй төсөл хэрэгжих журмын дагуу Төрийн болон албаны нууцын хуулийн хүрээнд дагаж мөрдөх дүрэм, журмуудыг мөрдөн хэрэгжүүлж эхлээд байна | 100% | |
| 140 | 10 | 13 | **2019 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 8 дугаар тэмдэглэл** | Засгийн газрын 2018 оны 387 дугаар тогтоол, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 42 дугаар тогтоол болон | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **2019-02-08**<br>**Дугаар 2019_8**<br>XIII.3. . “Таван толгой түлш” ХХК-ийн түүхий эд болох эрчим хүчний баяжуулсан нүүрс (мидлинг)-ийг нөөцлөх дундын агуулах талбайг Улаанбаатар хот, Төв аймгийн нутагт сонгон 1 жилийн хэрэгцээнд зориулан 800.000 хүртэл тонн нөөцийг татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт даалгав. | “Таван толгой түлш” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 14 дүгээр тогтоол, 2019 оны 3 дугаар сарын 01-ны өдөр байгуулсан “Таван толгой түлш” ХХК-тай байгуулсан ЭТТ-2019/172 тоот “Нэмэлт санхүүжилт олгох гэрээ”-нд 76 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нийгмийн хариуцлагын хүрээнд, эргэн төлөх нөхцөлтэй өгөхөөр заасан. Гүйцэтгэх захирлын 2019 оны 1 дүгээр сарын 29-ны өдрийн А/33 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж санхүүжилтийг үйл ажиллагааг хянаж ажиллаж байна. 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 7 удаагийн санхүүжилтээр 76 тэрбум төгрөгийг олгосон. Ажлын хэсэг гэрээ дүгнэх, ТУЗ-д тайлан танилцуулахаар ажиллаж байна.<br>Төв аймгийн Сэргэлэн сумын Гүн бүрдийн аманд 12 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмших гэрээ байгуулж, дундын бус байгуулсан. Уг дундын бүсэд 427,457 тонн түүхий эд /мидлинг/-ийн нөөцийг татан төвлөрүүлээд байна. | | |
| 141 | 10 | 14 | XIII.7. . “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018 оны санхүүгийн жилийн ногдол ашиг хуваарилах асуудлыг Засгийн газрын гишүүдийн саналыг авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн хэрэгжилт бүрэн хангагдсан бөгөөд энэ хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөл 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 09 дүгээр тогтоолыг гарган, компанийн 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 90 /ерэн/ төгрөгийн ногдол ашгийг иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хувьцаанд мөнгөн хөрөнгөөр, төрийн эзэмшлийн хувьцаанд компанийн эзэмшиж байгаа үнэт цаасаар 2020.05.01-ний өдрөөс эхлэн олгохоор шийдвэрлэсэн. Мөн Төлөөлөн Удирдах зөвлөл 04 дүгээр сарын 13-ны өдрийн 20 дугаар тогтоолоор төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ногдол ашгийг “Монголын Төмөр зам” ХК-ийн гаргасан хаалттай өрийн бичиг, “Таван толгой түлш” ХХК-аас авах авлагаар төлөхөөр тус тус шийдвэрлэсэн болно. | 100% | |
| 142 | 11 | 15 | **2019 оны 2 дугаар сарын 27-ны өдөр 9 дугаар тэмдэглэл**<br>**2019-02-27**<br>**Дугаар 2019_9**<br>XY.1. . “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн талаар цаашид авах арга хэмжээний талаар | “Эрдэнэс Монгол” ХХК нь 2007 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд болон стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялгийн ордыг ашиглахтай холбоотой харилцаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан.<br>Өнөөдрийн байдлаар тус компани нь “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэс Оюутолгой” ХХК, “Багануур”” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Мон-Атом” ХХК, “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК, “Эрдэнэс Метан” ХХК, “Эрдэнэс Ассет Менежмент” ХХК-иудын 50 буюу түүнээс дээш хувийн хувьцааг эзэмшиж байна. Мөн “Оюу толгой” ХХК-ийн Монголын талын 34 хувийг өөрийн охин компаниар дамжуулан эзэмшиж, Тавантолгой -Гашуунсухайт чиглэлийн авто замын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан ажилладаг “Гашуун | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 170 | 2 | 2 | **2020 оны 2 дугаар сарын 12-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2020-02-12 Дугаар 2020_9**<br><br>ХҮI.6. . "Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн хэрэгжүүлж байгаа "Алт цэвэршүүлэх үйлдвэр барих" төслийн хэрэгжилтийн явц, шаардлагатай санхүүжилтийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан "Алт цэвэршүүлэх үйлдвэр барих" төслийг дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийн талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс Монгол" ХХК (П.Ганхүү) нарт даалгав. | Төслийн санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, төслийг гадаад, дотоодын эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжийн талаар санал боловсруулж Засгийн газарт танилцуулах тухай Монгол улсын Засгийн газрын 2020.02.12-ны өдрийн 9 дүгээр хуралдаанаас чиглэл авсан бөгөөд гадаад, дотоодын банкны зээлийн нөхцөл, тавигдах шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалтын нарийвчилсан шинжилгээ хийлгэж, Япон, Швейцар, Сингапурын хөрөнгө оруулалтын банкнуудтай хамтран ажиллаж байна.<br>Япон улсын SBI групп төсөлд хөрөнгө оруулах боломтой гэдгээ илэрхийлсэн бөгөөд хөрөнгө оруулсан тохиолдолд хувь эзэмшлийн хэмжээг тодорхой болгохыг хүссэн энэ асуудлыг "Эрдэнэс Монгол" ХХК-иар дамжуулан Засгийн газрын хэрэг эрхлэх газарт уламжилсан. Монгол Улсын Засгийн 2020.06.01-ний өдрийн 212 тоот тогтоолоор ашигт малтмал хайх эрх олгогдсон ба тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2020.08.26-ны өдрийн 308 тоот шийдвэрээр Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумдын нутагт орших Хүрэнцав нэртэй 1704.51 гектар талбай /XV-021666/, Мухар хар толгой нэртэй 4313.57 гектар талбай /XV-021667/, Довжоот нэртэй 1393.37 гектар талбай /XV-021668/, Халзан нэртэй 453.89 гектар талбай /XV-021669/ нийт 7865.34 гектар талбай бүхий 4 талбайн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг "Эрдэнэс алт ресурс" ХХК-д компанид олгосон бөгөөд дээрх хайгуулын тусгай зөвшөөрлийг эргэлтэд оруулах замаар төслийн хөрөнгө оруулалтын зарим хэсгийг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэхээр ажиллаж байна. | 100%<br><br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 171 | 3 | 3 | **2020 оны 9 дүгээр сарын 23-ний өдөр 51 дүгээр тэмдэглэл 2020-09-23 Дугаар 2020_51** XII.1. . Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Дархан-Уул, Сэлэнгэ аймагт ажилласан талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад даалгав:<br><br>XII.1. 12. Дархан-Уул аймагт хэрэгжих уул уурхай, металлургын цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор гангийн үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, төсөлд шаардлагатай цахилгаан эрчим хүчний дэд бүтцийн асуудлыг судалж, үе шаттай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалтаар газар ашиглах эрхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох арга хэмжээ авахыг Дархан-Уул аймгийн Засаг дарга Н.Насанбат нарт | УУХҮСайдын 2020.10.28-ны өдрийн А-268 дугаар тушаалаар Дархан-Уул аймагт хэрэгжих Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, концессын гэрээнд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан ба мөн УУХҮСайдын 2020.12.08-ны өдрийн А-314 дүгээр тушаалаар Уул уурхай, металлургийн цогцолбор төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гангийн үйлдвэрийн бүтээн байгуулалтын бэлтгэл хийх ажлын хэсгийн төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. | 30% | |
| | 8 | 9 | Хүнд үйлдвэрийн бодлогын дундаж: 77.7 хувь | | | |

САЛБАР ЧИГЛЭЛ: 5. НИЙТЛЭГ АСУУДАЛ

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5.а. Монгол Улсын хууль | | | | | | |
| 172 | 1 | 1 | **Хууль тогтоомжийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-05-29 Дугаар 2017.01.01** 49.1. Улсын Их Хурал, Засгийн газар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтолцоог бүрдүүлж, холбогдох бүтцийн нэгжийг ажиллуулна. | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 105 дугаар тогтоолоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны бүтцэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар байхаар батлагдсан бөгөөд тус газар нь 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. | 100% | |
| 173 | 1 | 2 | 52.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг Улсын Их Хурал, Засгийн газар жилд нэг удаа тогтмол хэлэлцэж хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хууль тогтоомжид зохих нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль тогтоомжийг хооронд нь уялдуулах, хууль тогтоомжийг системчлэн кодификаци хийх, шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжид үнэлгээ хийж, хуулийн давхардал хийдлийн судалгааг гаргаж, Хууль тогтоомжийн хуулийн дагуу Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, хийж, шаардлагатай хуулийн төслийг боловсруулан ажиллаж байна. | 100% | |
| 174 | 1 | 3 | 49.3.. Засгийн газраас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг холбогдох төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ. | "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргуулан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, холбогдох газруудад хүргүүлж байна. | 100% | |
| 175 | 1 | 4 | 49.5.. Улсын Их Хурал, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний бүтцийн нэгж нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн эерэг, сөрөг үр дагаврын талаарх хяналт шинжилгээний дүнг хууль санаачлагчид тогтмол мэдээлнэ. | "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг жил бүрийн 1, 7-р сард ЗГХЭГ-т хүргүүлж ажиллаж байна.<br>Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжид үнэлгээ хийж, хуулийн давхардал хийдлийн судалгааг гаргаж, Хууль тогтоомжийн хуулийн дагуу Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, хийж, шаардлагатай хуулийн төслийг боловсруулан ажиллаж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 176 | 1 | 5 | 49.6.. Энэ хуулийн 49.5-д заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээний дүнд үндэслэн хууль тогтоомжийн зорилгын түвшин хангалтгүй, хууль тогтоомжийн үзэл баримтлалд заасан үр дүнд хүрч чадахгүй тохиолдолд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийнэ. | "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, дүнг жил бүрийн 1, 7-р сард ЗГХЭГ-т хүргүүлж ажиллаж байна. | 100% | |
| 177 | 1 | 6 | 49.7.. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг жилд 2 удаа зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, түүний дагуу ажиллаж байна. | 100% | |
| 178 | 2 | 7 | **Олон улсын гэрээний тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-01 Дугаар 2017.01.01**<br>9.1.. Хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах саналыг тухайн гэрээний эцэслэн тохиролцсон, эсхүл үзэглэсэн төсөл, эсхүл баталсан буюу жинхэлсэн эх бичвэрийн хуулбар, боломжтой бол баталгаат хуулбар, шаардлагатай бол түүний орчуулгын хамт уг олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр холбогдох журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. | БНХАУ-тай тавантолгойн нүүрсний худалдааны урт хугацааны түншлэлийн хэлэлцээр хийх асуудлаар БНХАУ-ын Гадаад хэргийн сайдыг 2020 оны 9 сард ирэх үед санал тавьсан. Хятадын талаас асуудлыг судлан үзэхээр болсон. | 70% | |
| 179 | 2 | 8 | 24.2.. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн олон улсын гэрээгээр салбар хоорондын харилцааг зохицуулсан | НҮБ хүний эрхийн илтгэлийг хэлэлцүүлэх 4 жил тутмын 2020 онд хэлэлцүүлэх 3 дугаар тайланд Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүнд орж ажилласан. Энэ хүрээнд манай улс гар аргаар олборлоход мөнгөн усны хэрэглээг багасгах Парисын конвенцийг хэрэгжүүлж байгаа талаар тайланг 2020 оны 11 сард хүргүүлсэн бөгөөд нутгийн уугуул иргэдийн эрх ашгийг уул уурхайн салбарт хамгаалах асуудлаар тодорхой үүрэг амлалтыг авч ажиллаад байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | бол холбогдох байгууллагатай хамтран биелүүлнэ. | | | |
| 180 | 2 | 9 | 24.5.. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг гэрээний нөгөө тал, эсхүл бусад тал хэрхэн биелүүлж байгаа, монголын талын эрхийг хэрхэн хангаж байгаад тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина. | НҮБ хүний эрхийн илтгэлийг хэлэлцүүлэх 4 жил тутмын 2020 онд хэлэлцүүлэх 3 дугаар тайланд Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүнд орж ажилласан. Энэ хүрээнд манай улс гар аргаар олборлоход мөнгөн усны хэрэглээг багасгах Парисын конвенцийг хэрэгжүүлж байгаа талаар тайланг 2020 оны 11 сард хүргүүлсэн бөгөөд нутгийн уугуул иргэдийн эрх ашгийг уул уурхайн салбарт хамгаалах асуудлаар тодорхой үүрэг амлалтыг авч ажиллаад байна. Хэлэлцээрийн хүрээнд мөнгөн усны хэрэглээг хорих тал дээр хяналт тавин ажиллаж байна. | 100% | |
| 181 | 2 | 10 | 25.1.. Монгол Улс олон улсын гэрээний дагуу тухайн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан гаргах үүрэг хүлээсэн бол тайланг уг олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн олон улсын гэрээгээр салбар хоорондын харилцааг зохицуулсан бол холбогдох төрийн байгууллагатай хамтран боловсруулна. | 1. НҮБ хүний эрхийн илтгэлийг хэлэлцүүлэх 4 жил тутмын 2020 онд хэлэлцүүлэх 3 дугаар тайланд Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүнд орж ажилласан. Энэ хүрээнд манай улс гар аргаар олборлоход мөнгөн усны хэрэглээг багасгах Парисын конвенцийг хэрэгжүүлж байгаа талаар тайланг 2020 оны 11 сард хүргүүлсэн бөгөөд нутгийн уугуул иргэдийн эрх ашгийг уул уурхайн салбарт хамгаалах асуудлаар тодорхой үүрэг амлалтыг авч ажиллаад байна. | 100% | |
| 182 | 2 | 11 | 25.3.. Энэ зүйлийн 25.1, 25.2-т заасны дагуу боловсруулсан тайланг төрийн захиргааны төв байгууллага гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. /25.1.Монгол Улс олон улсын гэрээний дагуу тухайн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан гаргах үүрэг хүлээсэн бол тайланг уг олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн олон улсын гэрээгээр салбар хоорондын харилцааг зохицуулсан бол холбогдох төрийн байгууллагатай | НҮБ хүний эрхийн илтгэлийг хэлэлцүүлэх 4 жил тутмын 2020 онд хэлэлцүүлэх 3 дугаар тайланг Засгийн газрын хуралдаанаар 2020 оны 12 дугаар сард танилцуулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хамтран боловсруулна./ /25.2.Тайлан боловсруулах үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага тайланг түүнд тавигдах шаардлагад нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, шаардлагатай хэлээр орчуулах үүрэгтэй./ | | | |
| 183 | 2 | 12 | 34.2.. Энэ зүйлийн 34.1-д заасан хуулийн төслийг тухайн олон улсын гэрээг хариуцан байгуулж байгаа төрийн захиргааны төв байгууллага холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу боловсруулах үүрэгтэй. /34.1.Олон улсын гэрээ байгуулснаар, түүнд нэгдэн орсноор, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хүчин төгөлдөр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах, батлах саналыг өргөн мэдүүлэхдээ тухайн хуулийн төслийг хамт өргөн мэдүүлнэ./ | Уул уурхайн харуул хамгаалалттай холбоотой олон улсын сайн дурын зарчимд нэгдэх эсэх асуудлаар төрийн холбогдох эрх бүхий байгууллагатай 2019 онд хэлэлцэн зөвшилцсөний дагуу түр хугацаанд байр суурь илэрхийлэхгүй байхаар шийдвэрлэсэн.<br>Олборлох салбарын ил тод байдлын санаачлагын хүрээнд гэрээний ил тод байдлыг хангах чиглэлээр нээлттэй нийгэм форумтай хамтран ажиллаж, улмаар Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулан ажиллаж байна. | 70% | |
| 184 | 3 | 13 | **Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01**<br>13.3.. Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ. | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулан 2020.09.24-ний өдрийн 01/2346 албан тоотоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Үүнд: Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;<br>Мөн одоогийн мөрдөгдөж байгаа үндэсний хөтөлбөрүүдийг цаашид энэ хуультай хэрхэн нийцүүлэх, шинээр ямар зорилтот хөтөлбөрүүд хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаар Үндэсний хөгжлийн газартай уулзалт зохион байгуулж, саналаа Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан тоотоор хүргүүлсэн. | 30% | |
| 185 | 3 | 14 | 21.5.. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулан 2020.09.24-ний өдрийн 01/2346 албан тоотоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ. | | | |
| 186 | 4 | 15 | **Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай**<br>**2020-04-29**<br>**Дугаар 2020.04.29**<br>8.1.4.. Дамжин өнгөрөх болон улс хоорондын ачаа тээвэр, эрдэс баялгийн экспортын хүрээнд ачаа тээврийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох журмыг батлах; (8.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Улсын онцгой комисс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:) | Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2020.04.30-ны өдрийн тушаалаар "Хилийн автозамын боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам"-ыг баталсан. Энэхүү журмын 1.4.-д "Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг Онцгой нөхцөл байдалд зохион байгуулах" тухай асуудлыг тусгуулсан. | 100% | |
| 5.б. Улсын Их Хурлын тогтоол | | | | | | |
| 187 | 1 | 1 | **Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай**<br>**2020-01-10**<br>**Дугаар 2020 №04**<br>1.1/. Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль батлагсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: 1/төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах замаар орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, шаардлагатай тохиолдолд “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг судалж, саналаа холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийн хамт | Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль баталсантай холбогдуулан төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах замаар орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, шаардлагатай тохиолдолд “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах тухай холбогдох хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар байгуулан ажилласан.<br>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг тус тус боловсруулан батлуулахаар Сангийн яаманд 2020.09.04-ний өдрийн 01/2161 тоот албан бичгээр хүргүүлсэн. Гэвч, Сангийн яамнаас тус хуулийн төслийг дэмжих боломжгүй хариу тайлбарыг 2020.09.11-ний өдрийн 4-2/5928 тоот албан бичгээр ирүүлсэн. Татвараас хөнгөлөх, чөлөөлөх асуудал нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний чиг үүрэгт хамаарах тул сангийн сайдын саналын дагуу дээрх хуулийн төслийг боловсруулах шаардлагагүй гэж шийдвэрлэсэн. | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | | | |
| 188 | 2 | 2 | **Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-12-04 Дугаар 2020 №39** 1.1/. 1.Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: 1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсвийн орлого нэмэгдүүлэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, бүх салбарын төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх; | Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар УУХҮ-ийн сайдын 2021 оны төсвийг 40,1 тэрбум төгрөгөөр баталсан. Батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг улсын төсөвт төвлөрүүлэх орлого, хөрөнгө оруулалт, урсгал зардлаар харьяа байгууллага тус бүрээр боловсруулан сангийн яаманд хүргүүлж, батлагдсан хуваарийн дагуу 1 сарын эрхийг нээлгүүлээд байна. | 100% | |
| 189 | 2 | 3 | 1.2/. Төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гарган, хэрэгжилтийг хангаж ажиллах; | Төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах талаар удаа дараагийн албан бичгийг сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хүргүүлэн ажилласан. Үүнд: Зөвлөмжийн биелэлт ирүүлэх тухай 2020.08.21-ний өдрийн 01/2050 дугаар албан бичиг, Татвар нийгмийн даатгалын өр барагдуулах тухай 2020.12.22–ны өдрийн 01/3165 албан бичиг, албан шаардлага хүргүүлэх тухай 2020.11.25-ны өдрийн 01/2910 дугаар албан бичиг, Мөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг нэгтгэн 2020.06.15-ны өдрийн 03/1615 албан бичиг, албан шаардлагын биелэлт хүргүүлэх тухай 2020.07.06-ны өдрийн 03/1745 бичиг, 2020.11.10-ны өдрийн 03/2793 албан бичгээр Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлсэн. | 100% | |
| 190 | 2 | 4 | 1.4/. Монгол Улсын 2021 оны төсвийн төслөөс хасагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцон эрэмбэлж, төсвийн тухай | Монгол Улсын 2021 оны төсвийн төслөөс хасагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцон эрэмбэлж, төсвийн тухай хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн 2022 оны төсвийн төсөлд тусгах чиглэлийн дагуу арга хэмжээг авч ажиллаж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн дараа оны төсвийн төсөлд тусгах асуудлыг шийдвэрлэх; | | | |
| 5.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | | |
| 191 | 1 | 1 | **“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ**<br>3.20.. Уул уурхай, барилга, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийх гэрээнд “Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөж ажиллах талаар тусгаж, иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах. | Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх /2020-2021/ II шатны төлөвлөгөөнд тус яамны эрхлэх асуудлын хүрээнд “Насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон жагсаалтыг дагаж мөрдөх” талаар ГУУХҮ-ийн салбарын хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2019-2020 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 2.13-т уг заалтыг нэмж оруулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” 2018 оны 128 дугаар зарлиг, Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолын НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор “Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай” Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 06 тоот албан даалгаврыг гарган харьяа байгууллага, орон нутаг дахь төр захиргааны байгууллагууд руу хүргүүлснээр: Сумын Засаг дарга бичил уурхай эрхлэгч нөхөрлөлүүдтэй байгуулах 2020 оны гэрээнд “Хүүхдийн хөдөлмөрийг үл тэвчих, зөрчсөн этгээдтэй гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах” заалтыг тусгасан; Аймгууд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ, нөхөрлөлүүдэд 2019-2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 32 удаа хяналт шалгалтыг зохион байгуулж 158 ААНБ хамруулсан; 2020 оны жилийн эцсийн байдлаар Уул уурхайн салбарт насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулсан зөрчил илрээгүй. | 100% | |
| 192 | 2 | 2 | **Чиглэл өгөх тухай 2018-04-25 Дугаар 2018 №08 ЭЗБХ**<br>2.2/. Төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах; | Засгийн газрын хэрэг эрхлэх газраас терийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталыг ашиглалтад оруулсантай холбогдуулан www.opendata.gov.mn цахим хуудсанд эрдэс баялгийн салбарын статистик мэдээллийг сар бүр тогтмол байршуулж байна.<br>Энэ хүрээнд дараах мэдээллийг холбогдох эх үүсвэрээс авч, цахим санд оруулж байна. Үүнд: геологи, уул уурхай, газрын тосны салбараас Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээлэл, аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон борлуулалтын хэмжээ, ашигт малтмалын голлох бүтээгдэхүүний экспорт болон импортын мэдээлэл, кадастрын бүртгэлийн мэдээлэл, геологи, хайгуулын мэдээлэл, нүүрс, газрын тос болон хүнд үйлдвэрийн салбарын статистик мэдээлэл, Ашигт малтмал, газрын тосны газрын Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээлэл зэрэг багтаж байна.<br>Мөн түүнчлэн салбарын хэмжээнд статистик мэдээллийн бэлэн байдлыг сайжруулах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.12.07- | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ны өдрийн А-311 дугаар тушаалын дагуу Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанаас холбогдох мэдээ, тайланг хүлээн авч ажиллаж байна. Мэдээллийг тухай бүрт нь байршуулсан. | | |
| 193 | 3 | 3 | **Төрийн албаны зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлд үүрэг өгсөн хуралдааны тэмдэглэл 2018-05-01 Дугаар 2018 №07 ТББХ** 5.. Олон удаагийн шүүхийн шийдвэртэй яамдууд хүний нөөцийн бодлого алдагдсан асуудлыг засаж, сайжруулах арга хэмжээг нэн даруй авах; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд шүүхийн маргаантай нийт 4 албан тушаалтны асуудлыг шийдвэрлэж ажилд нь эргүүлэн томилсон. | 100% | |
| 5.г. Еренхийлөгчийн зарлиг | | | | | | |
| 194 | 1 | 1 | **Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46** 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хаягийг Крилл болон Үндэсний монгол бичгээр бичүүлсэн. Шагнал, урамшуулал тэргүүний байгууллагын өргөмжлөл зэргийг Үндэсний Монгол бичгээр бичдэг болсон. | 100% | |
| 5.д. УАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | | |
| 195 | 1 | 1 | **Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай 2017-07-19 Дугаар 2017_19/5** | Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжийн хүрээнд тус яамны төлөөлөл орж ажиллан, салбарын чиглэлийн мэдээллээр ханган ажиллаж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 1.. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах. | | | |
| 196 | 2 | 2 | **Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын талаар авах арга хэмжээний тухай**<br>**2020-11-13**<br>**Дугаар 2020_26/16**<br>1. Дэлхий нийтэд тархаад байгаа коронавируст халдвар /Коюид-19/-ын цар тахал иргэдийн дунд илэрч, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан гамшгийн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хохирлын хэмжээг бууруулах, цар тахлын халдварын тархалтыг зогсоох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг шуурхай зохион байгуулах. | "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 178 дугаар тогтоолыг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас "Халдваргүйжүүлэлт, хамгаалалтын аюулгүйн бүс байгуулах тухай" тушаалыг гаргаж, аюулгүйн бүсийг уул уурхайн Тавантолгой, Нарийнсухайт, Айлбаян, Ерөө-Хүдрийн бүлэг ордуудад нэгдсэн байдлаар, Оюутолгой, Эрдэнэт, Бор-Өндөр, Хөшөөт, Таяннуур, Улаан, Төмөртийн овоо, Багануур, Шивээ-Овоо, Адуунчулуун, Шарын гол, газрын тосны Зүүнбаян, Тосон уул, Тамсагийн ордуудад тус тус байгуулсан. Ингэснээр нүүрсний экспортын 95%, зэсийн экспорт 100%, газрын тосны экспорт 100%, төмрийн экспортын 90%, жоншны экспортын 70%-ийг халдваргүйжилтийн хамгаалалтанд авах боломжоог бүрдүүлсэн. Уурхайнуудын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс УУХҮ-ийн сайд, Эрүүл мэндийн сайд болон Зам тээврийн хөгжлийн сайдын хамтарсан тушаалаар "Ажилтнуудын ээлж солилцож, шилжилт хөдөлгөөн хийх үйл ажиллагаанд баримтлах түр журам"-ыг боловсруулан Эрүүл мэндийн яаманд хүргүүлээд байна. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 3 дахь удаагаа шилжсэн хугацаа 2021.01.11-ний өдрөөр дуусгавар болмогц уурхайн ажилчдын ээлж солих асуудлыг дээрх журмын дагуу зохион байгуулж ажиллана. Уг журмаар ажилчдын шинжилгээ авах цэгүүд, шинжилгээний төлбөр, шинжилгээний хариу гарах хугацаа болон тэднийг орон нутгийн иргэд болон ээлжээс бууж буй ажилчидтай хавьтал үүсгэхгүй тээвэрлэх асуудлуудыг зохицуулах тул цаашид энэ журмын дагуу 21-28 хоногийн давтамжтайгаар ажилчдын ээлжийг солих нөхцөл бүрдэх юм. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд 5.1.4.газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэвийн бус өсөлт, хангамжийн тасалдал, хомсдол үүсэх нөхцөлд зохицуулалт хийх гэж заасны дагуу шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангах талаар шуурхай арга хэмжээ авч ажиллаж байна. Цагааннуур, Боршоо, Эрээнцав боомтуудын үйл ажиллагааг зогсоосонтой холбоотой 2020.11.20-ны өдрийн 01/2882 дугаар асуудал шийдвэрлүүлэх тухай албан бичиг Улсын онцгой комисст, 2020.11.17-ны өдрийн 01/2860 дугаар санал, танилцуулга хүргүүлэх тухай албан бичгийн МУ-ын Шадар сайд, Онцгой комиссын дарга Я.Содбаатарт, 2020.11.10-ны өдрийн 01/2785 дугаар баруун бүсийн шатахуун хангамжийн тухай албан | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | бичгийг Улсын онцгой комисст тус тус хүргүүлж Улсын онцгой комиссын 34,35 дугаар хурлын тэмдэглэл, Засгийн газрын 2020.11.11-ний өдрийн Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай 172 дугаар тогтоол, 2020.11.29-ний өдрийн Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай 195 дугаар тогтоолуудыг тус тус гаргуулж Цагааннуур, Эрээнцав боомтуудыг гаригийн зохицуулалттайгаар нээх талаар холбогдох албан тушаалтан, төрийн байгууллагуудад шуурхай үүрэг чиглэл болгуулан ажиллаа. Мөн Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтын үйл ажиллагааг нээсэн холбогдуулан Улсын онцгой комиссын даргын тушаалаар байгуулагдсан Шуурхай ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж газар дээр нь ажиллаж боомтын үйл ажиллагааг жигдрүүлж, шатахууны импортыг эхлүүлсэн. | | |
| 5.е. Засгийн газрын тогтоол | | | | | | |
| 197 | 1 | 1 | **Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай**<br>**2019-03-21**<br>**Дугаар 2019_111**<br>2.. Бүх шатны төсвийн байгууллага, төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллан Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1, 111.2, 111.3 дахь хэсгийг тус тус хэрэгжүүлэх, үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулж ажиллахыг УУХҮСайдын 2018.12.04-ний өдрийн 06 дугаар албан даалгавраар ААНБ, Яам, Ашигт малтмал газрын тосны газар, Аймаг нийслэл, сум дүүргийн засаг дарга нарт биелэлтийг улирал бүрийн 15-ны дотор яаманд ирүүлж байхыг даалгаж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө ирүүлсэн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүдэд Хөдөлмөрийн тухай хуулийн 111-т заасны дагуу 25 түүнээс дээш ажилтантай ААНБ нь ажил, албан тушаалынхаа 4 түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай албан бичгийг Аж ахуйн нэгжүүдэд мөн хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газрын нэгтгэсэн дүн мэдээгээр 2019 онд 287 аж ахуйн нэгжид нийт 258 үүнээс Ашигт малтмал, газрын тосны газарт 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байна. | 100% | |
| 198 | 2 | 2 | **Жагсаалт батлах тухай**<br>**2020-01-22**<br>**Дугаар 2020_21**<br>3.. Худалдан авах ажиллагааг (tender.gov.mn) цахим системээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүн, гэрээг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт болон | УУХҮ-ийн сайдын 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулж, нэмэлт өөрчлөлт орох бүрд Сангийн яамаар батлуулан ил тод байдлыг хангасан. 2020 онд зарласан 30 тендерийн урилгыг цахим системээр зарлаж, үр дүн болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнүүдийг 100 хувь байршуулж ажилласан. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Төрийн худалдан авах ажиллагааны газарт үүрэг болгосугай. | | ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 199 | 3 | 3 | **Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай**<br>**2020-02-12**<br>**Дугаар 2020_62**<br>3.. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж"-ийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай. | Монгол Улсын Засгийн газрын 2020.02.12-ны өдрийн "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 62 дугаар тогтоолын дагуу УОК-ийн даргын 2020.02.13-ны өдрийн "Удирдамж батлах тухай" 04 дүгээр тушаалаар баталсан "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж"-ийг хүлээн авч Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албанаас дараах арга хэмжээнүүдийг авч ажилласан. Үүнд:<br>1. УУХҮЯ-ны 2020.02.14-ний өдрийн "Удирдамж хүргүүлэх тухай" 03/460 тоот албан бичгээр удирдамжийг улсын албаны мэргэжлийн ангиудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг мэдэгдсэн. 2. УУХҮ-ийн сайд бөгөөд Гамшгаас хамгаалах Уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны даргын 2020.02.14-ний өдрийн "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" А/21 дүгээр тушаалаар Гамшгаас хамгаалах Уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны мэргэжлийн ангиудад бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллах үүргийг өгч, биелэлтийг хангуулсан. 3. УУХҮ-ийн сайдын 2020.02.17-ны өдрийн "Мэргэжлийн ангийг нэмж томилгоожуулах тухай" А/23 дугаар тушаалаар мэргэжлийн 11 ангийн даргыг нэмэлтээр томилж, Гамшгаас хамгаалах Уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын алба нь мэргэжлийн 18 ангитай болж, удирдлагаар ханган ажилласан. | 100% | |
| 200 | 4 | 4 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2020-01-08**<br>**Дугаар 2020_10**<br>3.. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай үнэлэгдсэн барилга байгууламжийн үнэлгээ, төсвийн зардал, чанар байдлыг нягтлан үзэж, шаардлагатай тохиолдолд залруулах, зөрчил гаргасан албан тушаалтанд зохих журмын дагуу хариуцлага тооцохыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | УУХҮСайдын эрх асуудлын хүрээний 21 Төрийн өмчит үйлдвэрийн газруудын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар болон гэрээт аудитын байгууллагууд аудит хийж хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой ямар нэгэн зөрчил гаргаагүй байна. УУХҮСайдын санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт хүргүүлэн ажиллаж байна. УУХҮСайдын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний нэгдсэн дүнд ТӨБЗГ-аас хяналт хийн тайланг УУХҮЯ-д хүргүүлсэн. Зарим үнэлгээ хийгдээгүй хөрөнгийн тодруулгыг ТӨБЗГ-т албан бичгээр хүргүүлэн хамтран ажиллаж байна. | 100% | |
| 201 | 5 | 5 | **Төлөвлөгөө батлах тухай**<br>**2020-02-19**<br>**Дугаар 2020_66** | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийг үндсэн хууль нэмэлт өөрчлөлттэй уялдуулан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан холбогдох судалгаа шинжилгээг хийж байна. Уул уурхай, | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2.. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай. 2. Төлөвлөгөөнд тусгагдсан хуулийг тогтоосон хуваарийн дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай. | хүнд үйлдвэрийн яамнаас Ашигт малтмалын тухай хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн болович Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй дахин уялдуулах нь зүйтэй гэсэн чиглэлийн дагуу холбогдох ажиллагааг хийж байна. | | |
| 202 | 6 | 6 | **Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 2020-03-22 Дугаар 2020_102** 4. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ажлын байр, орон сууц болон өрөө, тасалгаанд ариутгал халдваргүйтгэл хийх арга хэмжээг улсын хэмжээнд 14 хоногийн хугацаанд багтаан зохион байгуулахыг нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд даалгасугай. | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ажлын байр, өрөө, тасалгаанд ариутгал халдваргүйтгэл хийх арга хэмжээг авч ажиллахыг бүх мэргэжлийн ангиудад зөвлөж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон харьяа байгууллагуудад ариутгалыг хийлгэж, тусгай уулзалтын өрөөг ажиллуулан /өдөр бүрийн тогтмол цагт ариутгал хийж, агаар оруулж/ гадны хүн хүлээн авахгүй нөхцлийг бүрдүүлж, өрөө тасалгаанууд болон бие засах өрөө, шат, коридор, гаднаас орж ирэх үүдэнд ариутгагч тавьж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан. | 100% | |
| 203 | 7 | 7 | **Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2020-03-25 Дугаар 2020_106** 1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” -ийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2020.01.15-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Хуваарийн дагуу төлөвлөсөн нийт 14 ажлаас 7 нь хийгдсэн бөгөөд дараагийн үзлэгээс өмнө 7 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 70% | |
| 204 | 7 | 8 | 2. Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, | Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэх ажлын хүрээнд жил бүрийн байгууллагын батлагдсан төсөвт цахим | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай. | архив үүсгэхэд шаардагдах хөрөнгө, өрөө тасалгааны хүрэлцээт байдал, техник, технологи, программын шинэчлэл, баримтын хайрцаг, сав баглаа, боодол нэгдсэн стандартыг баримтлан ажиллахад шаардлагатай зардлыг тусгайлан 2021 оны төсөвт зохих хэмжээний хөрөнгийн эх үүсвэрийг суулгасан болно. | | |
| 205 | 8 | 9 | **БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2020-03-27 Дугаар 2020_114** 3.2. 3.2. Төсвийн урсгал зардлаас дараахь зардлыг тэргүүн ээлжид санхүүжүүлэх: 3.2.1. бүх шатны эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны зардал; 3.2.2. бүх шатны төсвийн байгууллагын коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахтай холбоотой бүх төрлийн зардал; 3.2.3. бүх шатны төсвийн байгууллагын цалин хөлс, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай зардал; 3.2.4. нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ. | УУХЗ-ийн сайдын 2020 оны төсвийн урсгал зардлаас дараах зардлыг тэргүүн ээлжид санхүүжүүлсэн. Үүнд:<br>1. УУХҮЯ болон харьяа байгууллагуудын коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахтай холбоотой бүх төрлийн зардал /ариутгалын бодис, амны хаалт, гар ариутгагч, нэг удаагийн бээлий, дархлаа сэргээх бүтээгдэхүүн, халуун хэмжигч/;<br>2. Төрийн албан хаагчдын цалин хөлс, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал, хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай зардал/ариутгагч бодис бүхий хаалга, нэг удаагийн хувцас, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, хэрэглэл/<br>3. УУХҮЯамны аппаратын 2020 оны батлагдсан төсөвт төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг суулгасан ба энэ онд ажилтан албан хаагчдад нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг тухай бүр олгосоор ирсэн, өндөр насны тэтгэвэрт гарахаар төлөвлөгдсөн 3 хүнээс 2 хүнд нь 07 сар болон 11 сард нэг удаагийн буцалтгүй тусламжинд нийт 65.6 сая төгрөгийг олгосон. Үлдсэн 1 хүний тэтгэвэрт гарах хугацаа хойшлогдсон тул 34.4 сая төгрөгийн хэмнэлт үүссэн.<br>Ашигт малтмал, газрын тосны газрын хувьд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан төсвийн орлого, зардлын сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан 2020.05.01-ний өдрийн 1/2056 тоот, 2020.10.28-ны өдрийн 1/5011 тоот, 2020.12.15-ны өдрийн 1/5512 тоот албан бичгээр тус тус Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд, 2020.07.21-ний өдрийн 1/3266 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлсэн. Сангийн яаманд зарцуулалтын эрх нээлгэх замаар төсвийн урсгал зардлаас тэргүүн ээлжид санхүүжүүлэх зардлыг санхүүжүүлсэн бөгөөд санхүүжилтийг түр зогсоосон зардлуудыг санхүүжүүлээгүй. | 100% | |
| 206 | 8 | 10 | 5. 5. Олон улсын зах зээлд түүхий тосны үнэ буурч байгаатай холбогдуулан бүх төрлийн шатахуун, дизель түлшний жижиглэнгийн үнийг | Энэ ажлын хүрээнд Засгийн газрын 2020 оны 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Эрчис Ойл” төрийн өмчит компаниар дамжуулан “АИ-92 төрлийн автобензиний үнийг тогтворжуулах” хамтын ажиллагааны гэрээ байгуулах ажлыг УУХҮЯ болон АМГТГ хамтран зохион байгуулав. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | литр тутамд 300-400 төгрөгөөр бууруулах, цаашид жижиглэнгийн үнийг тогтворжуулах зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан өмнө нь байгуулсан гэрээ, хэлцлээр тохиролцсон нөхцөлийн хүрээнд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т үүрэг болгосугай. | Энэхүү тогтоолоор хэрэгжүүлж буй гэрээ нь эрсдэлийн сан буюу /Hedge Fund/ үүсгэн газрын тосны бүтээгдэхүүний бирж дээр санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан арилжаалах буюу урт болон богино хугацааны гэрээ хийж, үнэ болон нийлүүлэлтээ тогтмол хэмжээнд барьдаг туршлагаас үндэслэн Монгол Улсад анх удаа хийгдэж буй шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулж буй арга юм.<br>Манай улсын хувьд иргэдийн өргөн хэрэглээний суурь бүтээгдэхүүн болох АИ-92 шатахууны үнийг тогтворжуулах нь нийт эдийн засагт эерэг уур амьсгал бүрдүүлэх бөгөөд эдийн засгийн өсөлтийг дэмжих, бусад бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хязгаарлах гол ач холбогдолтой бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн "Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна" гэсэн заалтыг хэрэгжүүлэх боломжтой болж байна.<br>Энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс аливаа санхүүжилт шаардагдахгүй бөгөөд түлш, шатахууны импорт эрхлэгч компаниудын гадаад улстай хийсэн аливаа гэрээ хэлцэлд өөрчлөлт орохгүй эерэг талтай гэдгийг гэрээ байгуулах мэдэгдэл ирүүлсэн 18 аж ахуйн нэгжийн удирдлагуудад танилцуулан "Эрчис Ойл" ТӨК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Гэрээ байгуулснаар улсын хэмжээнд АИ-92 шатахууны бөөний болон жижиглэнгийн үнийг бүсчлэлээр жигд тогтоож 8 сарын хугацаанд хэрэгжүүлэн ажиллах бүрэн боломжтой юм. Засгийн газрын 2020.05.13-ны өдрийн хуралдаанд УУХҮСайд Д.Сумъяабазар Бүх төрлийн шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга хийв. | | |
| 207 | 8 | 11 | 3.4. 3.4. Төсвийн урсгал зардлаас дараах зардлын санхүүжилтийг түр зогсоох: 3.4.1. бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт семинар зохион байгуулах, тавилга эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх; 3.4.2. хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал; 3.4.3. цалин хөлснөөс бусад бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр; 3.4.4. бараа үйлчилгээний бусад зардал. | Сангийн яамнаас Төсвийн урсгал зардлын дараах зардлын санхүүжилтийг түр зогсоосны дагуу, ТЕЗ-ын төсөвт холбогдох өөрчлөлтүүдийг тухай бүрд хийлгэж, коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахтай холбоотой бүх төрлийн зардалд зарцуулсан.<br><br>1. Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал<br>2. Эрдэм шинжилгээ судалгааны зардал<br>3. Бараа, үйлчилгээний зардал<br>4. Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал;<br>5. Цалин хөлснөөс бусад бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр<br>6. бараа үйлчилгээний бусад зардал. | 100% | |
| 208 | 9 | 12 | **Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт** | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаа явуулж буй байр, Уул уурхай, газрын тосны төв | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **байгууллагуудыг тоолууржуулах тухай 2020-04-22 Дугаар 2020_144** 1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улирал багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай. | лаборатори нь 2019 онд цахилгаан хэмжих тоолуурыг тавиулсан бөгөөд тоолуур тавигдаагүй байр байхгүй болно. | Холбогдох нөхцөлийг бүрдүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 209 | 10 | 13 | **Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2020-04-29 Дугаар 2020_151** 3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгасугай. | УУХҮЯамны аппаратын 2020 оны батлагдсан төсөвт төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг суулгасан ба энэ онд ажилтан албан хаагчдад нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг тухай бүр олгосоор ирсэн өндөр насны тэтгэвэрт гарахаар төлөвлөгдсөн 3 хүнээс 2 хүнд нь 07 сар болон 11 сард нэг удаагийн буцалтгүй тусламжинд нийт 65.6 сая төгрөгийг олгосон. Үлдсэн 1 хүний тэтгэвэрт гарах хугацаа хойшлогдсон тул 34.4 сая төгрөгийн хэмнэлт үүссэн. | 100% | |
| 210 | 11 | 14 | **Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай 2020-05-06 Дугаар 2020_163** 3. Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй | Засгийн газрын 2019.12.25-ны өдрийн Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай 472, 2020.02.19-ний өдрийн Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээг тогтоох тухай 75 дугаар тогтоолын дагуу тухай бүр өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байдлыг хангаж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай. | | | |
| 211 | 12 | 15 | **Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай 2020-05-06 Дугаар 2020_167** 1. Эдийн засгийг идэвхжүүлэхэд чиглэсэн дараахь арга хэмжээг ариутгал, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг чанд сахиулсны үндсэн дээр хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүдэд даалгасугай: 1.1. алт олборлолт, нүүрс, газрын тосны экспортыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгаланд; | Алтны олборлолтыг нэмэгдүүлэх хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монголбанк хооронд алтны салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох ажлыг зохион байгуулахаар тогтсон. Энэ хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч нарын 2020.05.20-ны өдрийн А/102, А-177 тоот хамтарсан тушаалаар алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл олгох төлөвлөгөө, журмыг хамтран баталсан. Алт-2 хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй зээлийн хүрээнд 12 аж ахуй нэгжид 200 орчим тэрбум.төг олгогдож, 2020 оны 11 дүгээр сарын байдлаар Монголбанкинд тушаасан алтны хэмжээ 21 тн хүрээд байна. Эдийн засгийг идэвхжүүлэх, алтны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд алтны салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж Алт-2 хөтөлбөрийн хүрээнд олгож буй хөнгөлөлттэй зээл болон бусад асуудлаар санал солилцсон.<br>Мөн коронавирусын цар тахлаас үүдэн Улсын онцгой комиссын 2020.02.10-ны өдрийн 4 дүгээр хуралдаанаас Монгол, Хятадын хилийн авто замын боомтуудыг 2020.03.02-ны өдөр хүртэл хаах шийдвэрийг гаргасан. Үүний дагуу нүүрс болон газрын тосны экспортын тээвэрлэлтийг 2020.02.14-ний өдрөөс эхлэн бүрэн зогсоосон бөгөөд тус яамнаас хилийн боомтуудыг дор дурдсан хугацаанд нээх бэлтгэл ажлыг хангаж, Улсын онцгой комиссын хуралдаанд танилцуулсны дагуу дор дурдсан хугацаанд хилийн боомтуудыг нээсэн. Замын-Үүд дэх гаалийн газар: 2020.03.02-ны өдөр нээсэн. Гашуунсухайт дахь гаалийн газар: 2020.03.21-ний өдөр нээсэн. Шивээ-Хүрэн дэх гаалийн газар: 2020.03.28-ны өдөр нээсэн.. Ханги дахь гаалийн газар: 2020.03.26-ны өдөр нээсэн. Хилийн боомтуудыг нээсэн эхний 1 сарын хугацаанд хоногт ойролцоогоор 200-250 машин нүүрс хилээр нэвтэрч байсан бол 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар энэ тоо 800-1000 орчим болж нэмэгдсэн. Түүнчлэн Монгол улсын шадар сайд, улсын онцгой комиссын даргын 2020.11.21-ний өдрийн 30 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсгийн хүрээнд Өмнөговь аймагт 2020.11.22-27-ны өдрүүдэд Гашуунсухайт, Шивээхүрэн боомтууд дээр нүүрсний экспортыг нэмэгдүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажилласан. Энэ дээр дурдсан хугацаанд тус яамнаас хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад томилолтоор ажиллаж, нөхцөл байдалтай танилцах ажлыг зохион байгуулсан болно. Газрын тосны экспортын тээвэр гүйцэтгэх автомашины тоог нэмэгдүүлэх талаар Улсын онцгой комиссын шуурхай штаб, Уул уурхай хүнд үйлдвэрийн яамтай байнгын | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | харилцаа холбоотой ажиллаж, холбогдох мэдээллээр хангасан. Үүний үр дүнд Улсын онцгой комиссоос 2020.08.13-ны өдөр 1926, 1927 тоот албан бичгээр, Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдаас 01/1977 тоот албан бичгээр Дорнод болон Сүхбаатар аймгийн Засаг даргад газрын тосны экспортын тээврийн хэрэгслийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх тухай мэдэгдэл хүргүүлсэн. Үүний үр дүнд Монгол Улсын Засгийн газрын 2020.08.05-ны едрийн хуралдааны 43 дугаар тэмдэглэлийн хэрэгжилт хангагдаж, 2020.08.12-ны едрөөс эхлэн Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайгаас экспортын тээвэрлэлт гүйцэтгэж буй автомашины тоог тус бүр 49 машинаар нэмэгдүүлж, хоногт 65 автомашин буюу 2112 тонн (15843 баррель) түүхий тос нэмж экспортлох боломж бүрдсэн. Ингэснээр газрын тосны хоногийн экспортын хэмжээг 62%-аар нэмэгдүүлсэн. | | |
| 212 | 13 | 16 | **КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2020-05-06 Дугаар 2020_168** 3. 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулах замаар энэ тогтоолын 1 дэх заалтад заасан төсвийн зохицуулалтыг тусган баталж мөрдүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй. 3. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу төрийн үйлчилгээг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй байхаар үйл ажиллагааг зохион байгуулж төсвийн сахилга хариуцлагыг өндөржүүлэн ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсөвт Монгол Улсын Засгийн газрын шийдвэр болон Сангийн сайдын өгсөн чиглэлийн дагуу 2020.10.06, 2020.12.07-ны өдрүүдэд холбогдох зохицуулалтыг хийлгэж, түүнтэй уялдуулан сар, улирлын хуваарьт өөрчлөлтийг оруулж, төрийн үйлчилгээг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй байхаар үйл ажиллагааг зохион байгуулж төсвийн сахилга хариуцлагыг өндөржүүлэн ажилласан. Шинээр байгуулагдсан Үндэсний геологийн албанд АМГТГ-ын төсвөөс зохицуулалт хийх замаар төсвийг хуваарилуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. | 100% | |
| 213 | 14 | 17 | **Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай 2020-11-23 Дугаар 2020_187** 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын батлагдсан төсвийн | Төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийн хэмнэлтийг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль үйлчлэх хугацаанд тухайн салбарын хэмжээнд цар тахалтай тэмцэх арга хэмжээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах эрхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосны дагуу УУХҮ-ийн сайдын багцад 2020.12.07-ны өдөр холбогдох зохицуулалтыг | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмнэлтийг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль үйлчлэх хугацаанд тухайн салбарын хэмжээнд цар тахалтай тэмцэх арга хэмжээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах эрхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосугай. Төсвийн зохицуулалтын батлагдсан хуваарийн дагуу төрийн үйлчилгээг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй байхаар зохион байгуулж, төсвийн сахилга, хариуцлагыг өндөржүүлэн ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай. | хийж, байгууллагын гадны хүн хүлээж авах өрөөг тохижуулж, гаднаас орох үүдэнд ариутгагч бодистой хаалгыг байршуулж, амны хаалт, ариутгалын бодис, бээлий, дархлаа сэргээх бүтээгдэхүүн, нэг удаагийн хувцас, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, өрөөний агаар цэвэршүүлэгчийг худалдан авч цар тахлаас урьдчилан сэргийлэх нөөцийг бүрдүүлэн, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулахаар ажиллаж байна. | | |
| 214 | 15 | 18 | **БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРГИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ 2020-11-29 Дугаар 2020_194** 7. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан хязгаарлалтыг авч, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, бүх шатны боловсролын байгууллага, иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай. | Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан хязгаарлалтыг авч, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж, улсын албаны мэргэжлийн ангиуд, харьяа байгууллагуудын ажилчдын ээлжээр ажиллах нөхцлийг бүрдүүлж, аль болох гэрээс ажиллах зөвлөмжийг хүргүүлж, зайлшгүй ажиллах ажилчдын жагсаалтыг гаргуулж, өдөр тутмын хариуцлагатай жижүүрийг томилуулан ОБЕГ, УОК-ийн шуурхай штабт тайланг хүргүүлж байна. Бүх мэргэжлийн анги, аж ахуйн нэгжүүдтэй нэг сувгаар холбогдох мэдээ, мэдээллийг шуурхай хүргэж, зөвлөмжөөр ханган ажиллаж байна. Мөн УУ Аюулгүйн бүс viber группийг тогтмол ажиллуулж, шаардлагатай, тулгамдсан арга хэмжээг тухай бүрд нь шуурхай авч хэрэгжүүлж байна. | 100% | |
| 215 | 16 | 19 | **Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан** | Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн дагуу энэ онд улсын хэмжээнд нийт 6.6 сая баррель буюу 897.0 мянган тонн газрын тос олборлож, | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2020-02-28 Дугаар 2020_78** 1.. Нүүрс, газрын тос болон ашигт малтмалын бусад бүтээгдэхүүний экспортыг эхлүүлэхтэй холбогдуулан хилийн боомтуудыг бүрэн хүчин чадлаар ажиллуулан дараалал үүсгэхгүйгээр тээвэрлэлтийг зохион байгуулах, тээвэрлэлт хийж байгаа жолооч нарын хоол хүнсний хангамж, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, жолооч нарт эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх, тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цагаанхүү), Хил хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн), холбогдох аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | экспортлон, газрын тосны борлуулалтын орлогоос улсын төсөвт 266 тэрбум төгрөг төвлөрүүлэх үүрэг хүлээсэн боловч дэлхий нийтэд тархсан шинэ төрлийн коронавирус /Ковид 19/ цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор газрын тосны экспортын үйл ажиллагааг 2020.01.30-ны өдрөөс эхлэн бүрэн зогсоосон. Улсын онцгой комиссоос баталсан уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журмын дагуу 2020.04.15-ны өдрөөс эхлэн Тамсаг XXI талбайгаас Баянхошуу хилийн боомтоор хоногт 24 автоцистернээр, 2020.06.16-ны өдрөөс эхлэн Тосон-Уул XIX талбайгаас Бичигтийн хилийн боомтоор хоногт 25 автоцистернээр газрын тосны экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг тус тус явуулж эхэлсэн.<br>Тус яамнаас 2020.03.05-ны өдрийн 02/636 тоот албан бичгээр Шивээхүрэн, Гашуунсухайт, Ханги, Баян-Хошуу зэрэг боомтуудад үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд холбогдох зардлыг шийдвэрлэх, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавьж ажиллах чиглэлийг өгсөн. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, дэд сайд Д.Загджаваар ахлуулсан холбогдох төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг 2020.03.06-07-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн нутагт орших Гашуунсухайт, Шивээхүрэн боомт, тус боомтуудаар нүүрсний экспорт гүйцэтгэж буй уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, нөхцөл байдалтай танилцсан. Томилолтоор ажиллах үедээ Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад шаардагдах ариутгалын пункт, албан хаагчдын халдвараас урьдчилан сэргийлэх хувийн хамгаалах хэрэгсэл болон ариутгалын бодисын 1 сарын хэрэглээнд шаардагдах нийт 296.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Хилийн Гашуунсухайт боомтод ариутгалын 4 пункт, Шивээхүрэн боомтод ариутгалын 3 пунктыг тус тус барьж байгуулсан. Хилийн боомтуудад ажиллах албан хаагчдын халдвараас урьдчилан сэргийлэх хувийн хамгаалах хэрэгсэл болон ариутгалын бодисын 1 сарын нөөцийг бүрдүүлсэн. Сэжигтэй тохиолдлын үед тусгаарлах байрыг хилийн боомт дээр болон уурхайнуудын кемпүүдэд бэлтгэсэн. Улмаар хилийн Гашуунсухайт боомтыг 2020.04.23-ны өдрөөс нээсэн бөгөөд өнөөгийн байдлаар хилийн тус боомтоос гадна Шивээхүрэн, Ханги, Замын үүд, Баянхошуу боомтуудаар уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогдож байна.<br>Өнөөгийн байдлаар Уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэж, | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | экспортлох үйл ажиллагаа Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2020.03.14-ний өдрийн тушаалаар батлагдсан "Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд кохион байгуулах түр журам"-ын дагуу зохион байгуулж байна. | | |
| 216 | 16 | 20 | 8.. Энэ онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шуурхай зохион байгуулж, мэдээллийг ил тод нийтэлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл арга хэмжээг 11 багцаар хэрэгжүүлсэн. Тэдгээрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг төрийн цахим системээр 100% зохион байгуулж гэрээг байгуулан, тендерийн урилга, үр дүн, гэрээний хувийг байршуулж ил тод байдлыг хангасан. | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 217 | 17 | 21 | **Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай<br>2020-11-18<br>Дугаар 2020_183**<br>9. Ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжийг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд шилжүүлж, нийт ажиллагсдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, хамгаалах, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд үүрэг болгосугай. | Газрын тос экспортлогч аж ахуйн нэгжийг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд шилжүүлж, нийт ажиллагсдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, хамгаалах, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлж ажиллах талаар УУХҮСайдын 2020.11.12-ны өдрийн 01/2832 албан тоотоор УУХҮСайдын А/282 дугаар тушаалаар гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны Шуурхай штабын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, А/289 дүгээр тушаалаар бэлэн байдлыг хангаж ажиллах үүргийг улсын албаны Шуурхай штаб болон мэргэжлийн ангиудад өгсөн.<br>Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанд Тавантолгой, Нарийнсухайт, Айлбаян, Ерөө-Хүдрийн бүлэг ордод нэгдсэн байдлаар, Оюутолгой, Эрдэнэт, Бор-Өндөр, Хөшөөт, Таяннуур, Улаан, Төмөртийн овоо, Багануур, Шивээ-Овоо, Адуунчулуун, Шарын голын уурхай, газрын тосны Зүүнбаян, Тосон уул, Тамсагийн орд тус бүрт халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах Аюулгүйн тусгай бүс байгуулах тухай асуудлыг танилцуулж, хуралдааны 64 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. Улмаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А-297 дугаар тушаалаар Халдваргүйжүүлэлт, хамгаалалтын аюулгүйн бүс байгуулах тухай тушаалыг батлуулж, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагуудтай цахим хурал хийж дээр дурдсан шийдвэрүүдийн талаар танилцуулсан. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 218 | 17 | 22 | 10. Монгол, Хятадын хилийн боомтод хэрэгжүүлж буй “Ногоон гарц”-ын үйл ажиллагааг эрчимжүүлж, ашигт малтмал, газрын тосны экспортыг хэвийн, тасралтгүй явуулах саналыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд дипломат шугамаар тавьж харилцан тохиролцохыг Гадаад харилцааны сайд Н.Энхтайван, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасугай. | Засгийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд өөрийн аймгийн нутаг дэвсгэрт орших хилийн боомтоор явагдаж газрын тосны экспортын тээвэрлэлтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх үйл ажиллагааг холбогдох талуудтай хамтран зохион байгуулж, холбогдох арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн, хамтран ажиллах тухай 2020.08.13-ны өдрийн 01/1977 тоот албан бичгийг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар нарт тус тус хүргүүлсэн. Баянхошуу болон Бичигт боомтоор явагдаж буй газрын тосны экспортын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байгаа ба өнөөдрийн байдлаар дээрх боомтуудаар явагдаж буй газрын тосны экспортын тээврийг 48 автоцистернээр гүйцэтгэж байсныг нэмэгдүүлэн, өдөрт 70-74 автоцистерн болгон нэмэгдүүлээд байна<br>Монгол, Хятадын хилийн боомтод хэрэгжүүлж буй “Ногоон гарц”-ын үйл ажиллагааг эрчимжүүлж, ашигт малтмал, газрын тосны экспортыг хэвийн, тасралтгүй явуулах саналыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд Гадаад харилцааны яамаар дамжуулан хүргүүлж байна. Энэ дагуу Монгол Улсаас Хөх хотод суугаа Ерөнхий Консул Б.Гантулга ӨМӨЗО-ны Баяннуур хотын Ганц мод боомтын зөвлөлийн орлогч дарга Хичээлттэй уулзаж, Гашуунсухайт-Ганц мод боомтын нэвтрэлтийг нэмэгдүүлэх талаар ярилцсаны дагуу нүүрсний тээврийн хэрэгслийн жолооч нарыг автобусаар хил нэвтрүүлж, PCR шинжилгээ хийлгэх ажлыг 2020 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлүүлсэн. | 100% | |
| 219 | 17 | 23 | 11. Хилийн боомтуудыг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд бүрэн хүчин чадлаар ажиллуулах, Тавантолгойн бүлэг орд, Нарийнсухайтын бүлэг орд, Оюутолгойн ордын хүрээнд байгуулагдсан ариутгал, халдваргүйжүүлэлт, хамгаалалтын аюулгүйн бүсийн үйл ажиллагаа, нөхцөл байдалтай уялдуулан Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор тээвэрлэлт хийж байгаа жолооч нарыг шинжилгээнд бүрэн хамруулж, эдгээр боомтыг “Ногоон бүс” болгон зарлаж, тээвэрлэлтийн дараалал үүсгэхгүй байхаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар | Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 30, 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 37, 39 дүгээр тушаалаар тус тус байгуулагдсан Ажлын хэсгийг Өмнөговь аймгийн Өмнөговь аймгийн нутагт орших Оюутолгой, Тавантолгойн ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, хилийн Гашуунсухайт боомт, Нарийнсухайтын ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам, хилийн Шивээхүрэн боомтод ажиллуулж, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахал хүн амын дунд тархахаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар, хамгааллын дэглэмийг сахиулах, боомтын аюулгүй байдлыг хангуулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй газар дээр нь үзэж танилцаж, хяналт тавьж, заавар, зөвлөмж өгч, холбогдох зохион байгуулалтыг тухай бүр гүйцэтгэсэн. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | | | |
| 220 | 17 | 24 | 18. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлбөрийг түргэн шуурхай барагдуулж ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх 44 аж ахуйн нэгж/урсгал зардлаас санхүүжүүлэх 33, хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 11/-тэй гэрээг байгуулан дүгнэж, санхүүжүүлсэн. Төсвийн орлого төвлөрүүлэлттэй холбогдуулан 1 гүйцэтгэгчийн санхүүжилт, Улсын комисс ажиллуулах 2 гүйцэтгэгчийн санхүүжилтийг тус тус Сангийн яаманд уламжилж, зохион байгуулалттай арга хэмжээнд оруулан Захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд санхүүжилтийг байршуулах арга хэмжээг аваад байна. | 100% | |
| 221 | 17 | 25 | 19. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 101 дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай. | Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 101 дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг харьяа бүх байгууллагууд, төрийн өмчит компаниудад зөвлөж, 2020 онд дотоодын үйлдвэрлэлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг нэгтгэж байна. | 70% | |
| 222 | 17 | 26 | 20. Аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах зорилгоор бэлэн байдал зарласан хугацаанд хүлээн авах бүх төрлийн сонгон шалгаруулалтын хугацааг 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдөр хүртэл сунгахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай. | Аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах зорилгоор бэлэн байдал зарласан хугацаанд хүлээн авах Мэдээлэл технологийн үйлчилгээ болон Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг 12 сард дүгнэж, гэрээг байгуулан, богино хугацаанд гүйцэтгэлийг хангуулсан. 2020 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын урсгал зардлаар санхүүжүүлэх нийт 9 нэр төрлийн 320.6 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөж жилийн эцсийн байдлаар гэрээ байгуулагдсан 5, дараа жил хийхээр хойшлуулсан 1 (Төсвийн тодотголоор хасагдсан), шууд худалдан | 100%<br><br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | авалтаар 3 арга хэмжээг тус тус зохион байгуулан ажилласан. Тогтоолын сунгасан хугацаанд зарлагдсан тендер байхгүй байсан. | | |
| 223 | 17 | 27 | 22. Салбарын хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэвийн явуулах санал боловсруулан Улсын онцгой комиссын хуралдаанд танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай. | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5.1.4.-д "газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэвийн бус өсөлт, хангамжийн тасалдал, хомсдол үүсэх нөхцөлд зохицуулалт хийх" гэж, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.18-д "цар тахлын үед өргөн хэрэглээний болон стратегийн ач холбогдол бүхий зарим бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байхад чиглэсэн төрийн зохицуулалтын арга хэмжээг авах" гэж тус тус заасан байдаг. Дэлхий нийтэд тархаад байгаа Ковид-19 цар тахлын нөхцөл байдал ОХУ-д хүндэрсэнтэй холбоотойгоор коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор Монгол, Оросын хилийн Цагааннуур, Боршоо авто замын боомтыг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс мөн оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хүртэл хааж, түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг зогсоохоор шийдвэрлэсэн. Тус боомтуудыг хааж, нэвтрэх хөдөлгөөнийг зогсоосонтой холбоотойгоор тухайн боомтуудаар явагдаж байсан шатахууны импорт зогсож, баруун бүсийн шатахууны хангамж тасалдах, хомсдол үүсэх, үнэ өсөх нөхцөл байдал үүссэн. Иймд баруун бүсийн шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хадгалах, хомсдлоос сэргийлэх хүрээнд тус боомтуудаар халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн, зөвхөн стратегийн ач холбогдол бүхий шатахуун импортлох асуудлыг судлан, шийдвэрлүүлэх тухай саналыг 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 01/2785 тоот албан бичгээр УОК-т хүргүүлсэн. Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 172 дугаар тогтоолоор хилийн Цагааннуур авто замын боомтыг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн сар бүрийн 2, 4 дэх долоо хоногт хуваарийн дагуу ажиллуулж, зөвхөн шатахуун тээвэрлэх авто машиныг улсын хилээр нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн. УОК-ын даргын 2020 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 31 дугаар тушаалаар байгуулагдсан "Цагааннуур боомтыг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн сар бүрийн 2, 4 дэх долоо хоногт хуваарийн дагуу ажиллуулж эхлэхтэй холбогдуулан халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, бэлэн байдлыг дээшлүүлж, хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэг бүхий" Шуурхай бүлгийн бүрэлдэхүүнд 2020.11.22-ны өдрөөс 12 дугаар сарын 02-ны өдрүүдэд Баян-Өлгий аймагт ажиллан, боомтын үйл ажиллагааг жигдрүүлж, шатахууны импортыг эхлүүлэх ажлыг холбогдох талуудтай хамтран зохион байгуулсан. 2020 оны 11 сарын 20-ны өдрийн 01/2882 дугаар асуудал шийдвэрлүүлэх тухай албан бичиг | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Улсын онцгой комисст, 2020 оны 11 сарын 17-ны өдрийн 01/2860 дугаар санал, танилцуулга хүргүүлэх тухай албан бичгийн МУ-ын Шадар сайд, Онцгой комиссын дарга Я.Содбаатарт, 2020 оны 11 сарын 10-ны өдрийн 01/2785 дугаар баруун бүсийн шатахуун хангамжийн тухай албан бичгийг Улсын онцгой комисст тус тус хүргүүлж Улсын онцгой комиссын 34,35 дугаар хурлын тэмдэглэл, Засгийн газрын 2020 оны 11 сарын 11-ний өдрийн Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай 172 дугаар тогтоол, 2020 оны 11 сарын 29-ний өдрийн Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай 195 дугаар тогтоолуудыг тус тус гаргуулж Цагааннуур, Эрээнцав боомтуудыг гаригийн зохицуулалттайгаар нээх талаар холбогдох албан тушаалтан, төрийн байгууллагуудад шуурхай үүрэг чиглэл болгуулан ажилласан.<br>УОК-ын 35 дугаар тэмдэглэлийн 3.4-т санал боловсруулан тусгуулсан. | | |
| 5.ё. Ерөнхий сайдын захирамж | | | | | | |
| 224 | 1 | 1 | **Төлөвлөгөө батлах тухай**<br>**2020-07-01**<br>**Дугаар 2020_99**<br>2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)”-г хавсралт ёсоор баталсугай. 2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутагт хэрэгжүүлэх жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт Жендэрийн талаар баримтлах бодлого /2019-2026/-ыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019.05.06-ны А/114 дүгээр тушаалаар батлуулсан. Мөн жил бүрийн төлөвлөгөөг Жендэрийн салбар зөвлөлөөр батлуулж, тайланг хуулийн хугацаанд хүргүүлж, биелэлтийг хангаж ажиллаж байна.<br>ҮГА-нь 2020.09.15-нд албан хаагчдаа мэдэлдээ аван үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулдаг ямар нэг судалгаанд хамруулж амжаагүй болно.<br>- Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 “Хүйсийн 60:40 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах” тухай заалтын дагуу Үндэсний Геологийн алба 59:41 гэсэн хүйсийн харьцаагаар хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>-Тайлан хугацаанд ҮГА-ны мэдэлд шилжин ирсэн 29 албан хаагч АМГТГ-т ажиллах хугацаандаа УУХҮЯ болон “МЭРИТ” төслөөс хамтран зохион байгуулсан<br>1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого” " Жендэрийн хэвшмэл ойлголтын талаар бүлгийн ажил -Жендэр, эцгийн эрхт ёс жендэрийн тэгш эрх” сэдэвт сургалтуудад тус тус хамрагдсан. | 100% | |
| 5 ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 225 | 1 | 1 | **2019 оны 7 дугаар сарын 24-ний өдөр 33 дугаар тэмдэглэл**<br>**2019-07-24**<br>**Дугаар 2019_33** | Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн дагуу Монгол, Канадын дугуй ширээний уулзалтын VIII хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2019.08.07-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд баталж 2019.08.14-ний өдөр 01/2316 дугаар албан тоотоор Гадаад харилцааны яаманд хүргүүлэв. Баталсан төлөвлөгөөний хэрэгжилтэд | 100%<br><br>Тус уулзалтын Монголын хэсгийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | II.. Улаанбаатар хотноо 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулсан Монгол, Канадын Дугуй ширээний уулзалтын 8 дугаар хуралдааны дүнг сайшааж, уг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд бөгөөд Дугуй ширээний уулзалтын монголын хэсгийн дарга Д.Сумъяабазарт даалгав. | тухай бүр хяналт тавьж тус яамтай холбогдолтой ажлын биелэлтийг 2020.11.10-ны өдрийн 04/2797 дугаар албан тоотоор Гадаад харилцааны яаманд хүргүүлэв. Засгийн газрын 2020.09.02-ны өдрийн 97 дугаар тогтоолоор тус уулзалтын Монголын хэсгийн даргаар Сангийн сайд томилогдсон болно. | даргаар Сангийн сайд томилогдсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 226 | 1 | 2 | III.. ХБНГУ-ын Берлин хотноо 2019 оны 5 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулсан “Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол, Германы Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн 7 хуралдааны дүнг сайшааж, уг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, тус Ажлын хэсгийн монголын хэсгийн дарга Д.Сумъяабазарт даалгав. | Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн дагуу "Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол, Германы Засгийн газар хоорондын ажлын хэсгийн 7 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2019.08.07-ны өдөр баталж 2019.08.14-ний өдрийн 01/2317 дугаар албан тоотоор Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтэд тухай бүр хяналт тавьж ажилласан бөгөөд тус яамтай холбогдолтой ажлын биелэлтийг 2020.09.28-ны өдөр цахим шуудангаар Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. | 100% | |
| 227 | 2 | 3 | **2019 оны 10 дугаар сарын 2-ны өдөр 42 дугаар тэмдэглэл 2019-10-02 Дугаар 2019_42** XYI.8. . Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4 дүгээр конгрессыг зохион байгуулсан дүнгийн талаар | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газрын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр 2020 онд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн дарга, бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүрэг бүхий орон тооны бус дэд зөвлөлийн даргаар 2020.03.23-ны өдөр батлуулж, төлөвлөгөөний дагуу тусгасан ажлыг хийж гүйцэтгэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүний эрхийг хангах чиглэлээр хийж гүйцэтгэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний дагуу дараах ажил үүргийг хийж гүйцэтгэсэн байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4 дүгээр конгрессоос баталсан "Улаанбаатарын тунхаглал"-д дурдсан ажлыг жил бүрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгав. | • АМАҮА-ны төлөвлөгөө ирүүлсэн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1-д заасны дагуу 25 түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах тухай албан бичгийг ААНБ, аймгуудын засаг дарга нарт хүргүүлсэн.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4 дүгээр конгрессоос баталсан "Улаанбаатарын тунхаглал"-д дурдсан ажил болон УУХҮ-ийн Сайдын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай 2018 оны 06 тоот албан даалгаврын хэрэгжилтийг жил бүрийн төлөвлөгөөнд тусган, биелэлтийг хангуулан ажиллаж байна.<br>• Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2-ийг хэрэгжүүлэх зорилгоор АМГТГ-ын даргын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн а/44 тоот тушаалаар батлагдсан хайгуулын болон ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ хүлээн авах зааврын 12 дугаар маягтад өөрчлөлт оруулж хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүний судалгааг аж ахуйн нэгжүүдээс авч мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газрын нэтгэсэн дүн мэдээгээр 2019 онд 287 аж ахуйн нэгжид нийт 258 үүнээс Ашигт малтмал газрын тосны газарт 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байна. | | |
| 228 | 3 | 4 | **2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл**<br>**2020-03-27**<br>**Дугаар 2020_21**<br>III.1. . 1. Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрээр Засгийн газар, сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах; 2. Үүрэг, даалгавар болгосон шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу тогтоосон хугацаанд | "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, гарсан үр дүнг яамны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн жил бүрийн 1, 7-р сард ЗГХЭГ-т хүргүүлж, "Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем" (www.unelgee.gov.mn)-д байршуулж ажиллаж байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | "Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем" (www.unelgee.gov.mn)-д байршуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээг үнэн зөв, бодитой хийж, гарсан үр дүнг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсны үндсэн дээр эрх бүхий байгууллагад тайлагнах; 3. 2019 оны жилийн эцсийн байдлаар удаашралтай, гүйцэтгэл нь хангалтгүй байгаа үүрэг, даалгаврын шалтгааныг тодорхойлон хэрэгжилтийг эрчимжүүлэх, гүйцэтгэлийг сайжруулах, шаардлагатай бол тухайн шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх; 4. Хэрэгжилт нь тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн, нэг удаагийн буюу цаг үеийн шинжтэй шийдвэр, заалтыг хяналтаас хасуулахдаа хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санд зохих тэмдэглэгээ хийж байх; 5. Төрийн эрх бүхий байгууллагууд хамтран баталж, хэрэгжүүлэх эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-ыг тогтоосон хугацаанд нь батлан мөрдүүлдэг байх; 6. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төсөлд тусгах харилцаа зохицуулалтыг урьдчилан судалж, үр нөлөөг тооцон, санхүү төсвийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн, хэрэгжихүйц байхаар төлөвлөн боловсруулдаг байх; 7. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд салбар, орон нутгийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоог сайтар хангаж ажиллах. | | | |
| 229 | 3 | 5 | III.3.. 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 230 | 4 | | чиглэлийн биелэлттэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгов: 2.1. үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж байх; 2.2. үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлэх. | батлагдсан төсөл, арга хэмжээнд зарцуулагдах төсөв, хөрөнгийн хэмжээг зарцуулсан дүнтэй нь харьцуулан нэгтгэж жилийн эцсийн тайлангийн хамт хүргүүлж ажилласан бөгөөд зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлсэн. | Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 230 | 4 | 6 | **2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2020-04-01 Дугаар 2020_22** XYIII.2.2. Дараахь арга хэмжээ авахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: 2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах; 2.2. Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнах; 2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, тендерийн явцын мэдээг сар бүр Шилэн дансанд байршуулж худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллаж байна. Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тухай бүрд нь байршуулж байна. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээг байгуулж, хүчинтэй хугацааг нэг ч удаа сунгуулаагүй ба гэрээний хэрэгжилтэд хяналтыг тавьж, акт үйлдэн санхүүжилтийг олгож байна. 2020 онд гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгж байхгүй байна. | 100% Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг тус хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр Сангийн яаманд хүргүүлэх; 2.4. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа захиалагч бусдад давуу байдал олгох, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн, гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавихгүй байх, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар, эцсийн үр дүнд үндэслэн боловсруулах. | | | |
| 231 | 5 | 7 | **2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр 26 дугээр тэмдэглэл 2020-04-22 Дугаар 2020_26** YII.. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгох; 2. Дулааны тоолуур худалдан авах, суурилуулахад шаардагдах хөрөнгийг төсөвт байгууллагын зарлагын хэмнэлт, давсан орлогоос холбогдох хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлэхийг Төсвийн захирагч нарт зөвшөөрөх; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаа явуулж буй байр, Уул уурхай, газрын тосны төв лаборатори нь 2019 онд цахилгаан хэмжих тоолуурыг тавиулсан бөгөөд тоолуур тавигдаагүй байр байхгүй болно.. | 100%<br><br>Холбогдох нөхцөлийг бүрдүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 232 | 6 | 8 | **2020 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр 28 дугээр тэмдэглэл 2020-04-29 Дугаар 2020_28** IX.3. . Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн албан хаагчид | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчдад улирал бүр холбогдох журмын дагуу урамшуулал олгосон. 2020 онд нийт 2 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарч нуг удаагийн буцалтгүй тусламжийн хуулийн дагуу олгосон. | 100%<br><br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгах. | | авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 5.з. Засгийн газрын албан даалгавар | | | | | | |
| 233 | 1 | 1 | **Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай 2019-10-16 Дугаар 2019_03** 1.1. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний төлбөр тооцоонд "Цахим төлбөрийн баримтын систем" /ebarimt/ нэвтрүүлэх ажлыг 2019 онд багтаан иргэдэд чиргэдэл үүсгэлгүйгээр шуурхай зохион байгуулах. | УУХҮ-ийн сайдын 2019.11.04-ний өдрийн А/216 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний геомэдээллийн сан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.6.2 "Цахим үйлчилгээний төлбөрийн систем нэвтрүүлэх" арга хэмжээг 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд оруулсан. Геологийн баримтын төв архив иргэд, аж ахуйн нэгжид үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг цахимаар авч, ebarimt ашиглаж байна. | 100% | |
| 234 | 1 | 2 | 1.2. Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургаж бэлтгэх, төлбөр тооцооны системийн талаар иргэдэд сурталчилан таниулах. | Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургах, төлбөр тооцооны талаар иргэдэд сурталчилан таниулах ажлыг эхлүүлсэн. Салбарын 2021-2024 оны цахим шилжилтийн төлөвлөгөөний төсөлд тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | 100% | |
| 235 | 1 | 3 | 1.3. Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх. | Салбарын хэмжээнд цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Мон Пасс СА ХХК-иас УУХҮЯ-нд 2020.11.09-ний өдөр "Тоон гарын үсэг нэвтрүүлэх" тухай ирүүлсэн албан хүсэлтийн дагуу УУХҮ-ийн сайдад танилцуулга бэлтгэж танилцуулсан бөгөөд цаашид тус компанитай хамтарч ажиллахаар төлөвлөж байна. Мөн Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний дата төвийн хооронд 2020.05.28-ны өдөр байгуулагдсан БА99, 2020/34 дугаартай хамтран ажиллах гэрээний дагуу Тоон гарын үсгийн гэрчилгээ олгогдсон бөгөөд Уул уурхайн компьютержсан кадастрын системд нэвтрүүлэх ажил хийгдэж байна. | 70% | |
| 236 | 1 | 4 | 1.4. Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах. | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаар УУХҮЯ нь газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, уламжлалт бус газрын тос хайх, газрын тос ашиглах, | 30% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | уламжлалт бус газрын тос ашиглах, төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх, үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх. үүсмэл орд ашиглах, тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх, пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах тэсэлгээний ажил явуулах зэрэг тусгай зөвшөөрлүүдийг олгодог.<br>Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд тус яамнаас тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд цахим системийг нэвтрүүлэх ажлыг 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Энэ хүрээнд тусгай зөвшөөрлүүдийг цахимаар олгодог болсноор төрийн байгууллагын үйлчилгээ нээлттэй, ил тод, түргэн шуурхай болохын зэрэгцээ тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн зардал тодорхой хэмжээгээр буурах боломжтой. Төрийн цахим үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах асуудал нь хуулиар зохицуулагдана. | | |
| 237 | 1 | 5 | 1.5. Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан шаардлагатай бол эрхлэх асуудлын хүрээнд болон нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөж байгаа эрх зүйн актуудад зохих өөрчлөлт оруулах. | УУҮХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн ба шаардлагатай эрх зүйн актуудад өөрчлөлт оруулах холбогдох арга хэмжээг авч ажиллана. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | |
| 238 | 1 | 6 | 3.. Албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэж, тайланг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд. | УУҮХЯ-ны эрхлэх асуудлын хүрээний цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргын 2020.12.25-ны өдрийн 03/3218 албан тоотоор ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100% | |
| 239 | 2 | 7 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>**2020-11-19**<br>**Дугаар 2020_2**<br>1. Дор дурьдсан арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:<br>1.1. Салбар болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх цахим | Эрдэс баялгийн салбарын хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний төслийг хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж Төрийн нарийн бичгийн даргын 2020.12.25-ны өдрийн 03/3218 албан тоотоор ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100%<br><br>Албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | шилжилтийн арга хэмжээний төслийг хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх; | | тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 240 | 2 | 8 | 1.2. Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia" цонхонд нэгтгэх болон цаашид иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг үйлчилгээний жагсаалтын хамт боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлэх; | Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж "e-Mongolia" цонхонд нэгтгэх ажлуудын санал боловсруулж Харилцаа холбоо мэдээллийн технологийн газарт Төрийн нарийн бичгийн даргын 2020.12.24-ний өдрийн 03/3205 албан тоотоор хүргүүлсэн. | 100%<br><br>Албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 241 | 2 | 9 | 1.3. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх; | Эрдэс баялгийн салбарын хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний төсөлд тусган ЗГХЭГ-т хүргүүлсэн. УУХҮЯ-нд төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх ажлын хүрээнд ХШҮДАГ-т Цахим бодлого, мэдээллийн технологийн хэлтэс байгуулан дарга, 3 мэргэжилтэнтэй үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү ажлыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж шинээр авч яамны дотоод ажлын хэрэгцээнд ашиглан төрийн үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Төрийн энтерпрайз архитектурын платформыг нэврүүлэх сургалтанд 2 мэргэжилтэн сургасан. Мөн "Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" УҮГ-тай хамтран УУХҮЯ-наас олгогдох тусгай зөвшөөрлийг цахимжуулах системүүдийн суурилуулалт хийхээр серверийг бүрэн шинэчилсэн. Үүнд: R740 сервер 32 core, Vmware вертуал үйлдлийн систем хуулгах программ, PA-220 firewall, Microsoft 365 нэвтрүүлж ажилсан. "Office 365"-ийн Sharepoint хөгжүүлхэд 1 ажилтанг сургасан. УУХҮЯ-наас аж ахуйн нэгжид олгогдож буй тусгай зөвшөөрлүүдийг цахим системд шилжүүлэх болон ЭБМЗ-ийн үйл ажиллагааны бүртгэлийн систем хөгжүүлэх ажлуудыг гүйцэтгэгч компанитай хамтран хэрэгжүүлж байна. | 70% | |
| 242 | 2 | 10 | 1.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулж байх, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, | Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж "e-Mongolia" цонхонд нэгтгэх ажлуудын санал боловсруулж Харилцаа холбоо мэдээллийн технологийн газар хүргүүлсэн.<br>УУХҮЯ-наас аж ахуйн нэгжид олгогдож буй тусгай зөвшөөрлүүдийг цахим системд шилжүүлэх болон ЭБМЗ-ийн үйл ажиллагааны бүртгэлийн систем хөгжүүлэх ажлуудыг гүйцэтгэгч компанитай хамтран | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | албан тушаалтанд хүргүүлж, харилцан солилцож байх; | хэрэгжүүлж байна. Мөн Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" УҮГ-тай хамтран УУХҮЯ-наас олгогдох тусгай зөвшөөрлийг цахимжуулах системүүдийн суурилуулалт хийхээр серверийг бүрэн шинэчилж ажиллаж байна. УУХҮЯ-ны удирдлагын мэдээллийн цахим сан, ухаалаг хэрэглээ /mobile application/ систем нэвтрүүлэлтийн шатандаа явж байна. Дээрх цахим мэдээллийн системүүд нэвтэрсэнээр шийдвэр гаргалт хурдан болох ба төрийн үйлчилгээ цахимжсанаар төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоо түргэн шуурхай болно. | | |
| 243 | 2 | 11 | 1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах; | Салбарын хэмжээнд цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Мон Пасс СА ХХК-иас УУХҮЯ-нд 2020.11.09-ний өдөр "Тоон гарын үсэг нэвтрүүлэх" тухай ирүүлсэн албан хүсэлтийн дагуу УУХҮ-ийн сайдад танилцуулга бэлтгэж танилцуулсан бөгөөд цаашид тус компанитай хамтарч ажиллахаар төлөвлөж байна. Мөн Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний дата төвийн хооронд 2020.05.28-ны өдөр байгуулагдсан БА99, 2020/34 дугаартай хамтран ажиллах гэрээний дагуу Тоон гарын үсгийн гэрчилгээ олгогдсон бөгөөд Уул уурхайн компьютержсан кадастрын системд нэвтрүүлэх ажил хийгдэж байна. | 70% | |
| 244 | 2 | 12 | 1.6. Төрийн цахим үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах; | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаар УУХҮЯ нь газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, уламжлалт бус газрын тос хайх, газрын тос ашиглах, уламжлалт бус газрын тос ашиглах, төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх, үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх, үүсмэл орд ашиглах, тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх, пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах тэсэлгээний ажил явуулах зэрэг тусгай зөвшөөрлүүдийг олгодог.<br>Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд тус яамнаас тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд цахим системийг нэвтрүүлэх ажлыг 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Энэ хүрээнд тусгай зөвшөөрлүүдийг цахимаар олгодог болсноор төрийн байгууллагын үйлчилгээ нээлттэй, ил тод, түргэн шуурхай болохын зэрэгцээ тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн зардал тодорхой хэмжээгээр буурах боломжтой. Төрийн цахим үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах асуудал нь хуулиар зохицуулагдана. | 30% | |
| 245 | 2 | 13 | 1.7. ХУР системд холбогдсон мэдээллийн системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Харилцаа холбоо, | Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний дата төвийн хооронд 2020.03.04-ний өдөр байгуулагдсан ХУР/20-12, 2020/33 дугаартай мэдээлэл солилцох, систем ашиглах гэрээний дагуу ХУР системтэй холбох аж ахуйн нэгжийн мэдээллийн сантай Уул уурхайн компьютержсэн кадастрын системийг холбох ажил хийгдсэн. Одоогоор | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийн технологийн газартай нягт хамтран ажиллах; | туршилт сайжруулалтын ажил хийгдэж байна.Мөн төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд УУХҮЯ-наас тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд цахим системийг нэвтрүүлэх ажлыг 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Уг систем нь төрийн мэдээлэл солилцооны ХУР системтэй холбогдон ажиллах бөгөөд системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай нягт хамтран ажиллах болно. | | |
| 246 | 2 | 14 | 1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах; | УУХҮЯ-ны цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ /facebook/-гээр дамжуулан холбогдох хууль, тогтоомжийн хэлэлцүүлэг, аж ахуйн нэгжид чиглэсэн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллийг түгээж салбар үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан таниулдаг. Эрдэс баялгийн мэдээллийн хайлтын систем болох https//www.mris.mn// төрөлжсөн өгөгдлийн сангийн мэдээллийн хураангуйг хэрэглэгчдэд интернетийн орчинд нээлттэйгээр хүргэж байна. | 100% | |
| 247 | 2 | 15 | 1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг “Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем”-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох. | УУХҮЯ, АМГТГ, ҮГА дотоод ажлын хэрэгцээнд ABLE cloud цахим систем ашиглаж албан бичиг болон бусад материалыг цахимаар солилцдог. 2021 оноос "Office 365"-ыг нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 100% | |
| | 38 | 76 | Нийтлэг асуудлын дундаж: 91.3 хувь | | | |
| НИЙТ ДҮН: 90.3 хувь | | | | | | |

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР БАТЛАГДСАН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ЖАГСААЛТ
/2020 оны жилийн эцсийн байдлаар/

2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр

| № | *Шийдвэрийн дэс дугаар* | *Зүйл, заалтын дэс дугаар* | *Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга* | *Хэрэгжилтийн явц* | *Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)* |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | | | а. Монгол Улсын хууль - 3/5 | | |
| 1 | 1 | 1 | **Ашигт малтмалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2006-07-08 Дугаар 2006.08.26** 3.2.. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална. | Засгийн газрын 2017.5.24-ний өдрийн 151 дугаар тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” батлуулж, мөрдөж байна.<br>Жич: /Монгол улсын Засгийн газрын 2020 оны 17 дугаар тогтоолын 8-д “Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилтийг шалгаж, зөрчил гаргасан буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх, учруулсан хохирлыг арилгуулах талаар холбогдох арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад даалгаж шийдвэрлэсэн/ | 100% Журмыг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 2 | 1 | 2 | 16.6.. Улсын төсвийн хөрөнгөөр хийх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг хянаж хүлээн авах журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуульд нийцүүлэн батална. | Улсын төсвийн хөрөнгөөр хийх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох тухай журмыг УУС-ын 2015 оны 108 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж захиргааны хэм хэмжээ тогтоосон актын Улсын бүртгэлд 2015.07.01-ний өдрийн 3542 дугаарт бүртгүүлсэн. | 100% Журмыг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 3 | 2 | 3 | **Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай 2009-07-16 Дугаар 2009.07.16** 4.6.. Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлахдаа уг тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор төлөх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар тогтооно. | Монгол улсын Засгийн газрын 2010.11.17-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд нөхөх олговор олгох журам”-ыг баталсан. | 100% Журмыг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | 2 | 4 | 5.1.2.. 5.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг батлах; | “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор 2019.08.07-ны өдөр батлуулсан. | 100% Дүрмийг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 5 | 3 | 5 | **Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-05-12 Дугаар 2017.05.12** 8.6.2.. 8.6.Хог хаягдлын талаар уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.6.2. Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих; | “Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам”-ын төслийг боловсруулан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.04.27-ны өдрийн А/87 дугаар тушаалаар баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4797 дугаарт бүртгүүлсэн. Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журмыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.04.27-ны өдрийн “Журам батлах тухай” А/87 дугаар тушаалаар батлуулан Захиргааны ерөнхий хуулийн дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 2020.05.15-ны өдрийн 4797 дугаарт бүртгүүлсэн бөгөөд хэрэгжилтийн хяналтын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. | 100% Журмыг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| б. Улсын Их Хурлын тогтоол – 3/4 | | | | | |
| 6 | 1 | 1 | **Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай 2012-01-05 Дугаар 2012 №01** 1.1.. 1.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай: 1.1. Газрын тос боловсруулах бага болон дунд хүчин чадлын үйлдвэрийг газрын тосны ордод түшиглэсэн байдлаар ойрын хугацаанд барьж байгуулах ажлыг түргэтгэх; | Уул уурхайн яам /хуучнаар/-наас газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг нийт 15 компанид олгосон хэдий ч тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын хөрөнгө санхүүжилт, техник технологи болон зарим тодорхойгүй шалтгааны улмаас дорвитой ажил хийгдээгүй. Нүүрс шингэрүүлж шатахуун үйлдвэрлэхээр тусгай зөвшөөрөл авсан "Багануур Энержи Корпорэйшн", "Гермон Газ", “МАК Си Ти Эл” компаниуд тодорхой ажлууд хийж эхэлсэн ч үйл ажиллагаа нь удааширч зогссон. Заримыг дурдвал “Дархан-Газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК жилд 2 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дархан хотод, “Хэт” ХХК жилд 120 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорнод аймагт, “М-Ойл” ХХК жилд 300 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Улаанбаатар хот, Рашаант өртөөнд, “Сүмбэр Ойл” ХХК-ийн жилд 100 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр, “М Ойл энд Жи” ХХК нь жилд 330 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорноговь аймгийн Зүүнбаянд тус тус барих төсөл ирүүлснийг яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. ҮАБЗ-ийн 2014.03.17-ны өдрийн зөвлөмжөөр газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын | 100% УИХ-ын тогтоолын заалт нь бүрэн хэрэгжээгүй, цаг хугацааны ач холбогдолгүй болсон, ҮАБЗ, УИХ, ЗГ-аас гарсан шийдвэрүүдээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн зорилго үйл ажиллагаа өөрчлөгдсөн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | түүхий эдийг түшиглэн байгуулах зөвлөмж гарсан. Засгийн газрын 2017 оны "Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай" 59 дүгээр тогтоолоор Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хоорондын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Засгийн газрын 2017 оны "Төрийн өмчит компани байгуулах тухай" 92 дугаар тогтоолоор "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий 100 хувь төрийн өмчит Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХКомпани байгуулахаар шийдвэрлэсэн. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хооронд 2016.04.28-ны өдөр байгуулсан "Зээлийн ерөнхий хэлэлцээр"-ийг Монгол Улсын Их Хурал 2017.05.31-ний өдөр, мөн үйлдвэр барих төсөлд шаардлагатай нэмэлт санхүүжилт олгох асуудлаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хооронд 2019.10.09-ний өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Их Хурал 2019.12.20-ны өдөр тус тус соёрхон баталсан. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн менежментийн зөвлөх компани БНЭУ-ын Enjineers india limited (EIL) компанитай "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ"-г 2019 оны 5 дугаар сарын 13-нд байгуулсны дагуу үйлдвэр барих ерөнхий төлөвлөгөөг баталсан. Уг гэрээг МГТБҮ ТӨХХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор баталж "Газрын тос боловсруулах үйлдвэр барих 2019-2024 оны календарьчилсан төлөвлөгөө"-г 2019.05.28-ны өдөр нарийвчлан боловсруулан ажиллаж байна.<br>Төслийн менежментийн зөвлөх компанитай зөвшилцсөний үндсэн дээр үйлдвэрийн бүтээн байгуулалтыг дараах байдлаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Үүнд:<br>- EPC-I: технологийн бус, иргэний барилга байгууламж,<br>- EPC –II: лицензгүй технологийн байгууламж, дагалдах байгууламж,<br>- EPC – III: үйлдвэрийн цахилгаан станц,<br>- EPC – IV: лицензит технологийн байгууламж.<br>Үйлдвэрийн бүтээн байгуулалтын инженерчлэл, худалдан авалт, барилга-угсралтын ажлыг дөрвөн багцын эхний багц болох технологийн бус барилга байгууламжийн барилга-угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр БНЭУ-ын "JMC Projects India" компани шалгарч, 2020.10.13-ны өдөр гэрээг байгуулж, барилга угсралтын бэлтгэл ажлыг хангаад байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | 1 | 2 | 1.2.. Дотоодын түүхий эдийг боловсруулах үйлдвэр барих санаачилга гаргаж байгаа аж ахуйн нэгжийг дэмжих замаар бензин, түлш шатахууныхаа хэрэгцээг хангах зорилтыг хэрэгжүүлэх; | Уул уурхайн яам /хуучнаар/-наас газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг нийт 15 компанид олгосон хэдий ч тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын хөрөнгө санхүүжилт, техник технологи болон зарим тодорхойгүй шалтгааны улмаас дорвитой ажил хийгдээгүй. Нүүрс шингэрүүлж шатахуун үйлдвэрлэхээр тусгай зөвшөөрөл авсан "Багануур Энержи Корпорэйшн", "Гермон Газ", "МАК Си Ти Эл" компаниуд тодорхой ажлууд хийж эхэлсэн ч үйл ажиллагаа нь удааширч зогссон. Заримыг дурдвал "Дархан-Газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК жилд 2 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дархан хотод, "Хэт" ХХК жилд 120 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорнод аймагт, "М-Ойл" ХХК жилд 300 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Улаанбаатар хот, Рашаант өртөөнд, "Сүмбэр Ойл" ХХК-ийн жилд 100 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр, "М Ойл энд Жи" ХХК нь жилд 330 мянган тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Дорноговь аймгийн Зүүнбаянд тус тус барих төсөл ирүүлснийг яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. ҮАБЗ-ийн 2014.03.17-ны өдрийн 14/06 тоот зөвлөмжөөр газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах зөвлөмж гарсан. | 100% УИХ-ын тогтоолын заалт нь бүрэн хэрэгжээгүй, цаг хугацааны ач холбогдолгүй болсон, ҮАБЗ, УИХ, ЗГ-аас гарсан шийдвэрүүдээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн зорилго үйл ажиллагаа өөрчлөгдсөн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 8 | 2 | 3 | **Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай 2018-11-15 Дугаар 2018 №84** 2.9/. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх. | Үнэт металл боловсруулах хамгийн сүүлийн үеийн, инновацийн технологи болох "Вакуум дистиляцийн арга"-ын Патент эзэмшигч БНКазУ-ын нэр бүхий компаниар "Үнэт металл боловсруулах үйлдвэр"-ийн ТЭЗҮ хийлгэсэн бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ хэлэлцэх салбар зөвлөлийн 2019.09.09-ний өдрийн СТР/19-01-01 дугаар дүгнэлтээр ТЭЗҮ-ийг хүлээн авсан. Монгол Улсад Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг түлхүүр хүлээлцэх нөхцөлөөр барих гэрээг төсөл хэрэгжүүлэгч "Эрдэнэс алт ресурс" ХХК болон БНКазУ-ын "Сымбат Инженеринг" ХХК-ийн хооронд 2019.10.11-ний өдөр БНКазУ-д байгуулсан. | 100% Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 9 | 3 | 4 | **Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (УИХ 2016.07.21-ний 12 дугаар тогтоолд "21.Үндэсний геологийн алба" гэж нэмсүгэй) 2020-01-30 Дугаар 2020 №12** 3.. Үндэсний геологийн албыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан байгуулж | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Үндэсний геологийн албыг Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолоор байгуулсан. Тус тогтоолоор Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт зөвшөөрсөн. Үндэсний геологийн албаны орон тооны дээд хязгаарыг 68 байхаар тогтоосон боловч Засгийн | 100% Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажиллуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай. | газрын 38 дугаар тогтоолоор орон тооны дээд хязгаарыг 35 байхаар өөрчлөлт оруулсан. Өнөөдрийн байдлаар Үндэсний геологийн албаны үйл ажиллагаа жигд явагдаж байна. | |
| в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол – 3/5 | | | | | |
| 10 | 1 | 1 | **Валютын ханш, газрын тосны бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах талаар цаашид авах арга хэмжээний тухай**<br>**2012-02-08**<br>**Дугаар 2012 №10 ЭЗБХ**<br>1.8.. Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдийн тоог ОХУ-ын болон бусад нийлүүлэгч компанийн тооноос хамааруулан цөөлөх, газрын тосны бөөний худалдаа эрхлэгч томоохон аж ахуй нэгжүүдээс уул уурхайн салбарын томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй шатахуунд онцгой албан татварын болон аливаа татварын хөнгөлөлтийг үзүүлэхгүй байх, газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаанд үнийг хямд, тогтвортой байлгах зорилгоор өрсөлдөөнийг дэмжих бусад бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 2013.02.07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр ГТБ-ийг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдааны үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр тусгасан. Мөн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т импортлогч нь "газрын тосны бүтээгдэхүүнийг нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр импортлох" үүрэг хүлээхээр хуульчилсан. Түүнчлэн УУХҮС-ийн 2018.01.12-ны өдрийн А/08 дугаар тушаалаар батлагдсан "Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам"-д ГТБ импортлох тусгай зөвшөөрлийг бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдэд олгох нэмэлт зохицуулалт оруулсан. Түүнчлэн Онцгой албан татварын тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу тус хуулийн 6.2-т заасан хэмжээгээр автобензин, дизелийн түлшийг импортлох үед онцгой албан татварыг авч байгаа тул уул уурхайн салбарын томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй шатахуунд онцгой албан татварын болон бусад аливаа татварын хөнгөлөлтийг үзүүлээгүй болно. | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 11 | 2 | 2 | **Чиглэл өгөх тухай**<br>**2017-06-30**<br>**Дугаар 2017 №07 ЭЗБХ**<br>1.1/. Зээлийн ерөнхий хэлэлцээрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн явц, хэрэгжилтийн талаар хагас жил тутам Байнгын хороонд мэдээлэл хийж байх; | ТӨБЗГ-ын 2017.04.04-ний өдрийн 108 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" компанийг байгуулан ажиллаж байна. БНЭУ-ын Эксим банкны санал болгосон компаниудын дунд "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах компанийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017.05.26-ны өдрийн Б/208 тоот тушаалаар байгуулагдсан "Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, хэлэлцээр хийх" ажлын хэсэг 2017.06.06-ний өдөр "Газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах шугам хоолой"-н нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэл боловсруулахаар шалгарсан БНЭУ-ын Зөвлөх болох EIL компанийн төлөөлөгч нартай эхний уулзалтыг зохион байгуулсан бөгөөд Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний төсөл болон холбогдох асуудлуудаар хэлэлцээр хийж байна. Улмаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэхтэг Улсын Экспорт- | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн зориулалтад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг УИХ-ын байнгын хороодоор зөвшилцсөний дараа ажлын журмаар Засгийн газрын зүгээс шийдвэр гаргахаар ЗГ тэмдэглэл гарсан. ЗГ-ын тэмдэглэлийн дагуу уг асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн, Аюулгүй байдлын Байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжүүлсэн. Монгол Улсын Засгийн газарт БНЭУ-ын Экспорт-Импорт банкаар дамжуулан олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэхийг Байнгын хороод дэмжсэний дагуу хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2017.05.31-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн соёрхон батлуулаад байна. | |
| 12 | 2 | 3 | 1.2/. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт-Импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн нарийвчилсан техник эдийн засгийн үнэлгээ, зээлийн эдийн засгийн үр нөлөө, эргэн төлөгдөх нөхцөл болон төслийн хэрэгжилтийн явцын талаар хэрэгжилтийг хангаж ажиллаж буй холбогдох яамд, байгууллагууд Байнгын хорооны хуралдаанд танилцуулах. | ЗГ-ын тэмдэглэлийн дагуу уг асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн, Аюулгүй байдлын Байнгын хороодоор хэлэлцүүлж дэмжүүлсэн. Монгол Улсын Засгийн газарт БНЭУ-ын Экспорт-Импорт банкаар дамжуулан олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэхийг Байнгын хороод дэмжсэний дагуу хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2017.05.31-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн соёрхон батлуулаад байна. | 100% Зээлийн хэлэлцээрийг соёрхон баталсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 13 | 3 | 4 | **Чиглэл өгөх тухай**<br>**2018-10-30**<br>**Дугаар 2018 №32 ЭЗБХ**<br>2.2/. Газрын тосны зарим төрлийн бэлэн болон завсрын бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах, экологийн ангилал, импортолж байгаа боомтоос хамааруулан автобензин, дизелийн түлшний албан татварыг ялгавартай тогтоох, шатахууны үнийн огцом хэлбэлзлийг онцгой албан татварын хувь хэмжээгээр тухай бүр шуурхай зохицуулах зэрэг асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | Тус заалтын хэрэгжилтийг хангах, автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан, боомтоос хамааруулан ялгавартай тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд манай яамнаас Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2017 оны 12 дугаар сар, 2018 оны 12 дугаар сар, 2019 оны 03 дугаар сар, 2020 оны 11 дүгээр сарууудад Сангийн яаманд хүргүүлсэн. СЯ-аас 2021.01.05-ны өдрийн 4-2/04 тоотоор ирүүлсэн хариунд уг асуудал нь Засгийн газрын тухай хуулийн 20.4.6-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудалд хамаарахыг анхааруулж, уг саналыг цар тахалын эдийн засгийн үед авч үзэх боломжгүй хариуг ирүүлсэн. | 100% Тогтоолын дагуу УУХҮЯ-наас шалтгаалах холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 14 | 3 | 5 | 3.. Тогтоолын хэрэгжилтийг 2019 оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг | Автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан, боомтоос хамааруулан ялгавартай тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой | 100% Тогтоолын дагуу холбогдох арга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд даалгасугай. | албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2019.09.07-ны өдрийн 01/2545 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| г. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | |
| д. УАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл - 1/1 | | | | | |
| 15 | 1 | 1 | **Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40**<br>2.8. Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, буруутай этгээдэд хариуцлага тооцох, учруулсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авах | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй аж ахуйн нэгжүүдтэй хариуцлага тооцох хүрээнд 2018 онд нийт 209 тусгай зөвшөөрөл цуцалсан бол 2019 онд 199 тусгай зөвшөөрлийг цуцалсан байна. Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5 дахь заалтад “тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан;” тохиолдолд Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай зохицуулалтыг Улсын Их Хурлын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан. Дээр дурдсан хуулийн заалтын дагуу 2019 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Номгон, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дэвсгэрт нийт 20 аж ахуйн нэгжийн 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалж, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг албадан гүйцэтгүүлэх, цаашид хууль бусаар алт олборлох зөрчил гарахаас сэргийлэх, хууль бусаар алт олборлогч нар талбайг ухахаас хамгаалах зорилгоор 12 дугаар сарын 01-ийг хүртэл цагдаа болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад авах шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлж ажилласан. 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдрөөс 12 дугаар сарын 1-ийг хүртэл Цагдаагийн Ерөнхий газрын Эргүүл тусгай хамгаалалтын тасгийн 160, Архангай аймаг дахь Цагдаагийн газрын 160 нийт 320 алба хаагчид 22 тээврийн хэрэгсэлтэй хамгаалалтыг авч хэрэгжүүлсэн. | 100% ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| е. Засгийн газрын тогтоол – 16/21 | | | | | |
| 16 | 1 | 1 | **Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай** | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгохдоо сонгон шалгаруулалтаар олгох зарчмаар зохион байгуулж байна. Сонгон шалгаруулалтыг нийтэд ил тод нээлттэй байлгах зорилгоор Ашигт малтмал, газрын тосны газрын цахим хуудаст сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл | 100% Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | **2020-01-15**<br>**Дугаар 2020_17**<br>9.. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохдоо байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай баримтад үндэслэх, тусгай зөвшөөрөл олгох ажиллагааг Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.15-д заасны дагуу олон нийтийн хяналтын дор явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т үүрэг болгосугай. | олгох талбайн зарыг байршуулан мэдээлж байна. Мөн агентлагийн цахим хуудаст талбайн тухай болон сонгон шалгаруулалтын тухай мэдээллийг тогтмол байршуулж байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгох 53 талбайг 6 багц болгон нийтэд цахимаар зарласан. Үнээс шаардлага хангасан 27 талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгсоон. Үүний үр дүнд улсын төсөвт 4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. | ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 17 | 2 | 2 | **Жагсаалт батлах тухай**<br>**2020-01-22**<br>**Дугаар 2020_21**<br>3.. Худалдан авах ажиллагааг (tender.gov.mn) цахим системээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүн, гэрээг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт үүрэг болгосугай. | УУХҮ-ийн сайдын 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулж, нэмэлт өөрчлөлт орох бүрд Сангийн яамаар батлуулан ил тод байдлыг хангасан. 2020 онд зарласан 30 тендерийн урилгыг цахим системээр зарлаж, үр дүн болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнүүдийг 100 хувь байршуулж ажилласан. | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 18 | 3 | 3 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай**<br>**2020-09-23**<br>**Дугаар 2020_114**<br>2. Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа Азийн авто замын АН-4 чиглэлийн Баян-Өлгий аймгийн Өлгий хотыг тойрон гарах авто зам, гүүрийн барилгын ажлын Багц-1, Багц-2, Багц-3 дугаар хэсэг буюу нийт 18.82 км хатуу хучилттай авто зам, 201.08 у/м төмөр бетон гүүрийн барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. 2. Энэ тоггоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Баян-Өлгий аймгийн Засаг | Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан МОН-3129 дугаар зээлийн гэрээний дагуу "Баруун бүсийн авто замын коридор хөрөнгө оруулалтын хөтөлбөр" Төсөл 2-ын хүрээнд 2020 онд АН-4 чиглэлийн Өлгий хотыг тойрон гарах 18.82 км авто зам, 201.08 у/м гүүрийн барилгын ажлыг 3 багц гэрээгээр гүйцэтгэхээр Зам, Тээврийн Хөгжлийн Яам нь авто замын барилгын гүйцэтгэгч "Эйч Кэ Би Интернейшнл Холдинг" ХХК, "Хотгор Зам" ХХК-тай 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр гэрээ байгуулж талбайн ажлыг эхлүүлэхэд бэлэн болсон. Гэрээ ёсоор Багц-1: 6.76 км авто зам, Багц-2: 201.08 у/м төмөрбетон гүүр, 260м зам, Багц-3: 11.8 км авто замын барилгын ажилд шаардлагатай ТТАМ-ыг ашиглах, хайх эрхийг аж ахуйн нэгжүүдэд олгосон. Замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын дээрх талбайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | дарга А.Гылымханд, авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгасугай. | | |
| 19 | 3 | 4 | 4. Авто зам, гүүрийн барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд үүрэг болгосугай. 4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасугай. | Засгийн газрын тогтоолоор бүтээн байгуулалтын зорилгоор тусгай хэрэгцээнд авсан замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 20 | 4 | 5 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай**<br>**2020-10-07**<br>**Дугаар 2020_135**<br>2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Баян-Өлгий аймгийн Засаг дарга А.Гылымханд, авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгасугай. | Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр”- Төсөл 2-ыг хэрэгжүүлэх МОН-3129 зээлийн гэрээг 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан байна. Тус зээлийн хөрөнгөөр Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км 4 багц хэсэг бүхий хатуу хучилттай авто замыг барьж байгуулахаар төлөвлөсөн ба Ховд-Өлгий чиглэлийн 3 багц хэсэг бүхий нийт 163.9 км хатуу хучилттай авто замыг 2016- 2019 онд барьж байгуулан ашиглалтад оруулсан. Үлдэж байгаа багцын 1-4 дүгээр хэсэг буюу Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг 2020-2022 онд барьж хэрэгжүүлэхээр холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын тендерийг Азийн хөгжлийн банкны “Худалдан авах ажиллагааны журам”-ын дагуу зохион байгуулж, шалгарсан гүйцэтгэгч компани болох БНХАУ-ын “Лонгжиан Роуд энд Бридж” ХХК-тай зам барилгын ажлыг гүйцэтгэх гэрээг 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан байна. Уг тогтоолын дагуу ТТАМ хайх, ашиглах 7 талбайд эрх олгосон. Замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын дээрх талбайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 21 | 5 | 6 | **Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх тухай 2020-10-07 Дугаар 2020_136** 2. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 2021 онд бүрдүүлэх нөөц, бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг хавсралт ёсоор батлалсугай. 2. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг 2021 оны 1 дүгээр сарын 31-ний дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт даалгасугай. | Засгийн газрын 2020.10.07-ны өдрийн хуралдаанаар 2021 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх асуудлыг хэлэлцүүлсэн ба Засгийн газрын 2020.10.07-ны өдрийн 136 дугаар тогтоолоор 2021 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжийн нэр, төрөл, тоо хэмжээг тогтоон баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд хавсралтад орсон аж ахуйн нэгжүүдтэй компанийн нөөц бүрдүүлэх гэрээг 2021.01.31-ний өдрийн дотор байгуулах чиглэлийг АМГТГ-т хүргүүлсэн ба тус газраас гэрээ байгуулах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. | 100% Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 22 | 6 | 7 | **Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай 2020-04-22 Дугаар 2020_144** 1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаа явуулж буй байр, Уул уурхай, газрын тосны төв лаборатори нь 2019 онд цахилгаан хэмжих тоолуурыг тавиулсан бөгөөд тоолуур тавигдаагүй байр байхгүй болно. | 100% Холбогдох нөхцөлийг бүрдүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 23 | 6 | 8 | 8.. Энэ онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шуурхай зохион байгуулж, мэдээллийг ил тод нийтэлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл арга хэмжээг 11 багцаар хэрэгжүүлсэн. Тэдгээрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг төрийн цахим системээр 100% зохион байгуулж гэрээг байгуулан, тендерийн урилга, үр дүн, гэрээний хувийг байршуулж ил тод байдлыг хангасан. | 100% Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 24 | 7 | 9 | **Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг шилжүүлэх тухай 2020-10-14 Дугаар 2020_150** 2. Уламжлалт бус газрын тосны хайгуулын "Тавантолгой-XXXIII" талбайд нүүрсний | БХГ-ний эрх, үүргийг хамтарсан компани болох "Метан Газ Ресурс" ХХК-ийн нэр дээр шилжүүлэхээр АМГТГ, "Эрдэнэс Метан" ХХК болон "Метан Газ Ресурс" ХХК нар Гурван талт гэрээ байгуулах ба эрх, үүрэг шилжүүлэгч ба эрх, үүрэг хүлээн авагч талууд гарын үсэг зурж АМГТГ-т 2020.12.11-ний өдөр хүргүүлсэн. Гэрээлэгч нь Газрын тосны тухай хуулийн 34 дүгээр | 100% Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | давхаргын метан хийтэй холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар Ашигт малтмал, газрын тосны газар болон "Эрдэнэс метан" ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн хүлээсэн эрх, үүргийг "Метан газ ресурс" ХХК-д бүхлээр нь шилжүүлэхийг зөвшөөрсүгэй. 2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт даалгасугай. | зүйлийн 34.7-д заасан 20,000 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг улсын төсөвт төлнө. Үүнээс гадна БХГ-ний эрх, үүргийг шилжүүлснээр "Эрдэнэс метан" ХХК нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 10.2-т заасан "төрийн байгууллагаас олгосон эрх борлуулсан, шилжүүлсний орлого"-д ногдох татвар төлнө. Ногдох татварын хэмжээг хянуулан тогтоолгох зорилгоор холбогдох хууль, журмын дагуу татварын тооцооллыг хийж гүйцэтгэн Татварын ерөнхий газарт хүргүүлсэн. Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, БХГ-ний эрх, үүргийг хамтарсан компани болох "Метан Газ Ресурс" ХХК-ийн нэр дээр шилжүүлсэн. | ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 25 | 8 | 10 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах тухай**<br>**2020-04-29**<br>**Дугаар 2020_153**<br>2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрхийг олгохыг холбогдох аймгийн Засаг дарга нарт, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай. | Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг концессын гэрээгээр гүйцэтгэх "Макс рөүд" ХХК-д тус замын бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын 54 талбайг хайх, ашиглах эрхийг холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан талбайтай давхцуулахгүй олгосон. Тус компани замын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай 1,549,000 м.куб элс, дайрга, хайргыг ашиглахаар уг тогтоолд тусгасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалыг бүрэн ашиглаж замын ажлыг дуусгасан байна. | 100%<br>УУХҮЯ-наас тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, замын бүтээн байгуулалтын ажил дууссан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 26 | 9 | 11 | **Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай**<br>**2020-10-21**<br>**Дугаар 2020_154**<br>1. Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн чиглэлийн авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Архангай аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасанд, авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, | Орхон гол-Их тамир чиглэлийн авто зам нь Архангай аймгийн Өгийнуур сумын нутаг дэвсгэрт байрлах Орхон голын гүүрнээс Батцэнгэл сум, цаашлаад Их тамир сумын чиглэлд баригдах Мянганы замын нэг хэсэг бөгөөд Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XIV.1.1.23-д тусгагдсан арга хэмжээ юм. Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн 63 км хатуу хучилттай авто зам, 220 у/м төмөрбетон гүүрийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгчээр "Хурдны зам" ХХК, хяналтын зөвлөхөөр "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ ажиллаж байна. Уг тогтоолын дагуу ТТАМ хайх, ашиглах 19 талбайд эрх олгосон. Замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын дээрх | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус даалгасугай. | талбайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | |
| 27 | 9 | 12 | 3. Авто зам, гүүрийн барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд үүрэг болгосугай. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасугай. | Засгийн газрын тогтоолоор бүтээн байгуулалтын зорилгоор тусгай хэрэгцээнд авсан замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын албайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | 100% Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 28 | 10 | 13 | **Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай**<br>**2020-11-18**<br>**Дугаар 2020_183**<br>20. Аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах зорилгоор бэлэн байдал зарласан хугацаанд хүлээн авах бүх төрлийн сонгон шалгаруулалтын хугацааг 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдөр хүртэл сунгахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай. | Аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах зорилгоор бэлэн байдал зарласан хугацаанд хүлээн авах Мэдээлэл технологийн үйлчилгээ болон Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг 12 сард дүгнэж, гэрээг байгуулан, богино хугацаанд гүйцэтгэлийг хангуулсан. 2020 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын урсгал зардлаар санхүүжүүлэх нийт 9 нэр төрлийн 320.6 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөж жилийн эцсийн байдлаар гэрээ байгуулагдсан 5, дараа жил хийхээр хойшлуулсан 1 (Төсвийн тодотголоор хасагдсан), шууд худалдан авалтаар 3 арга хэмжээг тус тус зохион байгуулан ажилласан. Тогтоолын сунгасан хугацаанд зарлагдсан тендер байхгүй байсан. | 100% Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 29 | 11 | 14 | **Ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох тухай**<br>**2020-06-01**<br>**Дугаар 2020_212**<br>2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан талбайд ашигт малтмал хайх эрхийг “Эрдэнэс Монгол” ХХК, түүний охин компани “Эрдэнэс алт ресурс” ХХК-д, 2 дугаар хавсралтад заасан талбайд ашигт малтмал хайх эрхийг “Эрдэнэс Монгол” ХХК, түүний охин компани “Эрдэнэс силвер ресурс” ХХК-д тус тус олгох арга хэмжээ авч, ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэхийг Ашигт | Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумдын нутагт Эрдэнэс алт ресурс ХХК-д XV-021669, 021668, 021667, 021666, Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай сумдын нутагт Эрдэнэс силвер ХХК-д XV-021671, 021670 дугаарын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон. Талбайнууд нь улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй сэдэвчилсэн болон зураглалын ажлын үр дүнд тогтоогдсон хэтийн төлөв бүхий талбайнууд бөгөөд үнэт, өнгөт, ховор, холимог металлын хүдэржилттэй. Эрдэнэс алт ресурс ХХК, Эрдэнэс силвер ХХК нь эрх олгогдсон талбайд ашигт малтмал хайгуулын ажил гүйцэтгэх бэлтгэл ажил болон хайгуулын ажлуудыг хийж гүйцэтгэж байна. | 100% Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэнд үүрэг болгосугай. | | |
| 30 | 11 | 15 | 3. Ашигт малтмал хайх ажлыг гүйцэтгэх төрийн өмчит хуулийн этгээдүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүү нарт даалгасугай. | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн зураглал, сэдэвчилсэн судалгааны ажлуудын үр дүнд хэтийн төлөвтэй болох нь тогтоогдсон 6 талбайд ашигт малтмалын хайгуулын XY-021666, XY-021667, XY-021668, XY-021669, XY-021670, XY-021671 дугаар бүхий 6 тусгай зөвшөөрлийг төрийн өмчийн Эрдэнэс силвер ресурс ХХК болон Эрдэнэс алт ХХК-дад олгосон. Эрдэнэс силвер ресурс ХХК нь Үндэсний геологийн алба ба Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын хамтран хайгуулын ажлыг гүйцэтгэж байна. Үүний үр дүнд Овоот хяр нэртэй XV-021670 хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд алтны хүдрийн ордын хайгуулыг хийж дуусган нөөцийг тооцолсон байна. Овоот хяр ордын хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ордын нөөцийг ЭБМЗөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн B+C зэргээр 53,1 тонн алтны нөөцийг Улсын ашигт малтмалын нэгдсэн бүртгэлд бүргэсэн байна. | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 31 | 12 | 16 | **Агентлаг байгуулах тухай**<br>**2020-06-23**<br>**Дугаар 2020_230**<br>3. Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталж мөрдүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгосугай. | Үндэсний геологийн албаны бүтцийн ерөнхий бүдүүвч, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай УУХҮСайдын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А-254 дүгээр тушаалаар батлуулсан. | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ.. |
| 32 | 12 | 17 | 9. Чиг үүрэг нь шилжиж байгаатай холбогдуулан Ашигт малтмал, газрын тосны газраас Үндэсний геологийн албанд чиг үүргийн хувьд шилжих орон тоог холбогдох төсөв, хөдлөх хөрөнгийн хамт шилжүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн), Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т тус тус даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн алба байгуулагдаж буйтай холбогдуулан батлагдсан орон тооны дээд хязгаарт багтаан шилжих орон тоо, холбогдох төсөв, хөрөнгийг хүлээлцүүлж, үйл ажиллагааг яаравчлан эхлүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг УУХҮСайдын 2020 оны 8 дугаар сарын 24-ны өдрийн А/217 дугаар батлуулсан. Үндэсний геологийн албанд Ашигт малтмал, газрын тосны газраас 35 мэргэжилтэний орон тоо, тэдгээрийн ажилд шаардлагатай дагалдах хэрэгсэл бүхий хөдлөх хөрөнгө, төсвийг шилжүүлсэн. Үндэсний геологийн алба нь Ашигт малтмал, газрын тосны II байранд үйл ажиллагаагаа явуулж байна. | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 33 | 13 | 18 | **Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай**<br>**2020-06-23**<br>**Дугаар 2020_231** | Тогтоолын нэмэлтээр түгээмэл тархацтай ашигт малтмалын тайлбайнуудыг ялган тогтоосон. Эдгээр талбайд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд тусгай | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2. Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 361 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол"-ын 42 дахь заалтын дараа хавсралтад дурдсан агуулгатай 43-61 дэх заалтыг нэмсүгэй. 2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан нарт даалгасугай. | зөвшөөрөлтнй холбоотой асуудлыг харъяалах аймгийн Засаг даргын тамгын газар зохицуулах арга хэмжээг авсан.<br>Засгийн газрын тогтоолоор бүтээн байгуулалтын зорилгоор тусгай хэрэгцээнд авсан замын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайнууд нь холбогдох хууль, тогтоомжоор хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд одоогоор замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой, ТТАМ ашиглах талаар хүндрэлтэй зүйл гараагүй байна. | хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 34 | 14 | 19 | **Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2018-10-24**<br>**Дугаар 2018_323**<br>3.. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор найдвартай хангах асуудлаар холбогдох байгууллага, компанитай уулзалт, хэлэлцээр хийж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт үүрэг болгосугай. | Газрын тосны тухай хуулийн 7.1.6 дахь заалтын дагуу Засгийн газар нь Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр барьсан тохиолдолд гэрээлэгчид ногдох газрын тос болон өртөгт газрын тосыг тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр худалдаж авах давуу эрхийг эдлэх эрхтэй бөгөөд мөн хуулийн 11.2.4. дэх заалтын дагуу гэрээлэгч нь газрын тосыг нийлүүлэх үүрэгтэй. Мөн Тосон-Уул XIX, Тамсаг XXI, БХГ-97 талбайд хэрэгжиж буй БХГ-нд хуулийн дээрх заалтыг гэрээний салшгүй хэсэг болгож протоколоор тохирсон. Үүний хүрээнд газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор найдвартай, тасралтгүй хангах асуудлыг шийдвэрлэх талаар санал солилцох уулзалтыг 2020.06.04, 2020.10.13-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар болон "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн холбогдох албан тушаалтнуудтай хамтран Петро Чайна Дачин Тамсаг компаний удирдлагатай уулзалт зохион байгуулсан. Петро Чайна Дачин Тамсаг компаний зүгээс Газрын тосны тухай хууль, БХГ-ний үүргээ биелүүлэн, боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах тал дээр өөрийн компаний хувь нэмрийг оруулж ажиллахаа илэрхийлсэн байна. | 100%<br>Хууль болон БХГ-нд тусгагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 35 | 15 | 20 | **Төслийн нэгжийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>**2019-12-18**<br>**Дугаар 2019_451**<br>2. Төслийн нэгжийг татан буулгахтай холбогдуулан чиг үүрэг, холбогдох баримт бичгийг "Эрдэнэс Монгол" ХХК-д шилжүүлэх, тус төслийн нэгжийн албан хаагчдыг чөлөөлөх арга хэмжээг 2019 оны IY улиралд багтаан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020.01.15-ны өдрийн А/02 дугаар тушаалаар "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл хэрэгжүүлэх нэгж"-ийг татан буулгаж, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020.01.15-ны өдрийн А/06 дугаар тушаалаар байгуулагдсан УУХҮЯ болон "Эрдэнэс Монгол" ХХК-ийн төлөөлөл бүхий Ажлын хэсгийн 2020.02.04-ний өдрийн актаар татан буугдсан төслийн нэгжийн чиг үүрэг, | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.<br>3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2016 оны 107 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцож, 2 дахь заалтын "...энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслийн нэгж болон" гэснийг хассугай. | холбогдох баримт бичгийг ЗГХЭГ-ын харьяа "Эрдэнэс Монгол" ХХК-д шилжүүлсэн. | |
| 36 | 16 | 21 | **Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх үүргийг шилжүүлэх тухай**<br>**2019-12-18**<br>**Дугаар 2019_452**<br>2.. Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргийг шилжүүлэх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга (Х.Хэрлэн) нарт даалгасугай. | Газрын тосны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, ЗГ-ын 2019 оны 452 дугаар тогтоол, газрын тосны хайгуулын Баянтүмэн-XVII талбайд байгуулсан БХГ-ний 5 дугаар зүйлийн 5.1-д заасныг тус тус үндэслэн БХГ-ний эрх үүрэг шилжүүлэх тухай гурван талт гэрээг АМГТГ, Магнай трейд ХХК, Түмэн Ойл ХХК хооронд 2020.02.21-ний өдөр байгуулснаар БХГ-ний эрх үүрэг Түмэн ойл ХХК-д шилжсэн болно. | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| | | | ё. Ерөнхий сайдын захирамж – 3/3 | | |
| 37 | 1 | 1 | **Ажлын хэсэг байгуулах тухай" Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах**<br>**2016-11-22**<br>**Дугаар 2016_114**<br>2. Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. | Ерөнхий сайдын 2016 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" 114 дүгээр захирамжаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж дүгнэлт гаргасан. Үүнд:<br>1. Хатчийн судалгааны тайлан, салбарын яамнаас ирсэн дүгнэлтийг үндэслэн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт барих асуудлыг ЗГ-ын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх;<br>2. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр эзэмших тухай Уул уурхай хүнд, үйлдвэрийн яамны саналыг ЗГ-ын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх;<br>3. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчтай гэрээ хэлцэл хийх ажлыг эрчимжүүлж үр дүнг 2017 оны II улиралд багтаан Засгийн газарт танилцуулах асуудлыг Засгийн газраас гаргах тогтоолд тусгаж шийдвэрлэх.<br>Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан зохих журмын дагуу Засгийн газрын 2017.03.15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх | 100%<br>Захирамжийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | тухай" 88 дугаар тогтоол батлагдан бөгөөд тус тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| 38 | 2 | 2 | **Ажлын хэсэг байгуулах тухай" Гацууртын алтны үндсэн ордыг ашиглах төсөл"-ийн хөрөнгө оруулагчтай Хөрөнгө оруулалтын гэрээбайгуулах талаар хэлэлцээ хийх үүрэг бүхий**<br>**2017-01-25**<br>**Дугаар 2017_20**<br>2. Хэлэлцээний үр дүнг эцэслэн тохирсон гэрээний төслийн хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай. | Засгийн газар 2016 онд шинээр байгуулагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 20 болон 21 дүгээр захирамжуудаар шинэ ажлын хэсэг байгуулагдаж, орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг бэлтгэн хөрөнгө оруулагч талд хүргүүлсэн. Гацууртын үндсэн ордыг ашиглах төслийн хувьд Засгийн газрын зүгээс төрийн эзэмшлийн 34 хувийг Ашигт малтмалын тухай хуульд тусгайлан заасан "ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр"-өөр орлуулах зарчмыг баримтлан ажиллаж байна. Шинэ ажлын хэсгийн хүрээнд бэлтгэсэн гэрээнүүдэд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах нөхцөлүүдийг бүрдүүлж, оруулж өгөхийн зэрэгцээ төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох өөрчлөлтүүд орсон болно. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс Гацууртын ордын нөөцийг дахин тодотгох шаардлагыг "Сентерра Гоулд Монголиа" ХХК-д тавьсаны дагуу нөөцийг шинэчлэн тодотгох ажлыг хийж байна. Үүний дараа энэхүү төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах бөгөөд уг ТЭЗҮ-д төслийн хөрөнгө оруулалт болон эдийн засгийн тооцоо өөрчлөгдөж болзошгүй тул Хөрөнгө оруулалтын болон Орд ашиглах гэрээний зарим заалтыг эргэн харахаар ойлголцолд хүрсэн. Өмнөх хэлэлцээний үеэр энэхүү төсөлд төрийн эзэмших ашигт малтмал ашигласны тусгай төлбөрийн хувь хэмжээ 3 хувиар яригдаж байсныг нэмэгдүүлэхээс гадна орон нутагт зайлшгүй шаардлагатай зарим асуудлыг шийдвэрлүүлэх саналыг тусгай зөвшөөрөл эзэмшигч буюу хөрөнгө оруулагч талд тавиад байна. Гацууртын алтны ордын тусгай зөвшөөрлийн асуудал нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.03.15-ний өдрийн №128/ШШ2019/0180 дугаартай шийдвэрээр ордын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг АМГТГ-т даалгасан байна. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 39 | 3 | 3 | **Ажлын хэсэг байгуулах тухай**<br>**2020-08-20**<br>**Дугаар 2020_32**<br>2. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд | Шадар сайдын 2020.09.01-ний өдрийн 94 дүгээр тушаалаар уг Ажлын хэсгийн хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталсантай холбогдуулан УУХҮС-ын А-246 дугаар тушаалаар дээрх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар гаргаж 2020 оны 12 сард Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн | 100%<br>Тогтоолын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | нь ашиглалтад оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай. 2. Бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулж, явцыг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Я.Содбаатар)-т даалгасугай. | | |
| ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл – 17/21 | | | | | |
| 40 | 1 | 1 | **2014 оны 10 дугаар сарын 4-ний өдөр 51 дүгээр тэмдэглэл 2014-10-04 Дугаар 2014_51** XYI. . Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг зөвшөөрч, холбогдох хуулийн дагуу үзэл баримтлалыг батлуулан хуулийн төслийг боловсруулж танилцуулах өргөтгөсөн ажлын хэсэг гарган ажиллуулахыг Уул уурхайн сайд Д.Ганхуягт даалгав. | Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн дагуу Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төслийн хувилбарыг боловсруулан ажилласан. Засгийн газрын бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх шаардлага гарч байсан. Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/209 дугаар тушаалаар байгуулан ажиллуулсан: Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулга, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр оруулсан нэмэлт, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд 020 оны 07 дугаар сарын 07-ны өдөр оруулсан өөрчлөлт, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасаны дагуу хуулийн шинэчилсэн найруулгыг дахин шинэчилэн боловсруулах шаардлага зүй ёсоор гарсан. Үүнтэй уялдуулан Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаас "Салбарын хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах асуудлын хүрээнд Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж,... Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэ ... "-хийг үүрэг болгосон. Засгийн газраас өгсөн үүргийн дагуу Газрын хэвлийн | 100% Энэхүү ажлыг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгийг шинэчилэн байгуулах зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Зохион байгуулалтын хүрээнд холбогдох салбаруудын төлөөллийг хамруулахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 03/3013 албан тоотоор холбогдох төрийн болон төрийн бус, эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагад хандсан. | |
| 41 | 2 | 2 | **2015 оны 03 дугаар сарын 30-ны өдөр 18 дугаар тэмдэглэл**<br>**2015-03-30**<br>**Дугаар 2015_18**<br>XXII.2. . Гацууртын ордын хөрөнгө оруулагчтай хийж байгаа хэлэлцээний явцын талаар Үүнтэй холбогдуулан хэлэлцээг эцэслэх чиглэлээр шуурхай ажиллаж, явц, үр дүнг тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав. | Гацууртын алтны ордын тусгай зөвшөөрлийн асуудал нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.03.15-ний өдрийн №128/ШШ2019/0180 дугаартай шийдвэрээр ордын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг АМГТГ-т даалгасан байна. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 42 | 3 | 3 | **2015 оны 05 дугаар сарын 4-ний өдөр 24 дүгээр тэмдэглэл**<br>**2015-05-04**<br>**Дугаар 2015_24**<br>XXI. 2. . Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Сентерра гоулд Монголиа” ХХК-тай тус ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээний талаар хийж байгаа хэлэлцээний явцын тухай Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан уг хэлэлцээг 2015 оны 5 дугаар сарын 25-ны дотор дуусгахыг Ажлын хэсэг (Г.Тэмүүлэн)-т даалгав. | Гацууртын алтны ордын тусгай зөвшөөрлийн асуудал нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.03.15-ний өдрийн №128/ШШ2019/0180 дугаартай шийдвэрээр ордын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг АМГТГ-т даалгасан байна. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 43 | 4 | 4 | **2016 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр 22 дугаар тэмдэглэл**<br>**2016-04-18**<br>**Дугаар 2016_22**<br>XXYIII.4. . Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах талаар хийж байгаа хэлэлцээний явцын талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хэлэлцээг цаашид үргэлжлүүлж, 2016 оны 4 дүгээр сард багтаан орд ашиглах болон хөрөнгө | Гацууртын алтны ордын тусгай зөвшөөрлийн асуудал нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.03.15-ний өдрийн №128/ШШ2019/0180 дугаартай шийдвэрээр ордын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг АМГТГ-т даалгасан байна. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | оруулалтын гэрээ байгуулахыг Ажлын хэсэг (Р.Жигжид)-т даалгав. | | |
| 44 | 5 | 5 | **2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл**<br>**2018-07-04**<br>**Дугаар 2018_29**<br>XIY.. Газрын тосны хайгуулын Баянтүмэн-XVII талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар Газрын тосны газар (хуучин нэрээр) болон "Магнай трейд" ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг "Магнай трейд" ХХК-аас "Эм Ти ПЛО" ХХК-д бүхэлд нь шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс чиглэл авсны үндсэн дээр дахин хэлэлцүүлэхээр хойшлуулав. Үүнтэй холбогдуулан газрын тосны салбарт байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, ашигт малтмалын салбарт олгосон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан боловч үйл ажиллагаа явуулалгүй тусгай зөвшөөрөл (гэрчилгээ)-ийг бусдад шилжүүлж (худалдаж) байгаа асуудлыг шийдвэрлэх болон цаашид авах арга хэмжээний талаар тодорхой санал боловсруулан зохих журмын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Газрын тосны газар (хуучин нэрээр) болон "Магнай трейд" ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг "Магнай трейд" ХХК-аас "Эм Ти ПЛО" ХХК-д бүхэлд нь шилжүүлэх талаар хөрөнгө оруулагч компани болон гэрээлэгч компанийн хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний хугацаа дууссан гэж үзээд уг асуудлыг цаашид хэлэлцүүлэх шаардлаггүй гэж үзэж дуусгавар болгосон.<br>Газрын тосны салбарт байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийн талаарх танилцуулгыг гэрээ байгуулсан талбай бүрээр бэлтгэн ЗГ-ын 2018.10.03-ны өдрийн хуралдаанд танилцуулж 41 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. | 100%<br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 45 | 6 | 6 | **2018 оны 10 дугаар сарын 24-ний өдөр 44 дүгээр тэмдэглэл**<br>**2018-10-24**<br>**Дугаар 2018_44**<br>XXYI.7. . 1. ОХУ-ын Роснефть компанитай хийж байгаа хамтын ажиллагааны хэлэлцээг үргэлжлүүлж, газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөлд хамтран оролцох нөхцөл боломжийг судлан танилцуулах; 2. Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрээс Тосон-Уул орд хүртэл газрын тос дамжуулах | Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай түүхий тосыг тээвэрлэх дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг МУ-ын Ерөнхий сайдын 2019.09.16-ны өдрийн 118 дугаар Захирамжаар байгуулсан. Ажлын хэсэг холбогдох судалгааг "Монголын логистикийн холбоо" ТББ-аар гүйцэтгүүлж тайланг хүлээн авсан ба тайлангийн үр дүнг Засгийн газрын 2019.12.18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 55 дугаар тэмдэглэл гаргуулсан. | 100%<br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хоолойн техник, технологи болон санхүүжүүлтийн асуудлыг судлан танилцуулах; 3. Дотоодын зах зээлд нийлүүлэх автобензин, дизелийн түлшний нөөц, хангамжийг нэмэгдүүлэх, тогтворжуулах зорилгоор автобензин, дизелийн түлшний нөөцийн агуулахуудын багтаамжийг нэмэгдүүлэх, гаалийн баталгаат агуулах байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх; 4. Хөшигийн хөндийд баригдаж байгаа нисэх онгоцны шинэ буудлыг түлш, шатахуунаар хангах асуудлыг шийдвэрлэхэд гадаадын хөрөнгө оруулалт, оролцоог судлан танилцуулах. | | |
| 46 | 7 | 7 | **2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр 2 дугаар тэмдэглэл**<br>**2019-01-09**<br>**Дугаар 2019_2**<br>XXIII.5. . "Газрын ховор элемент" хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Газрын ховор элемент хөтөлбөрийн төслийг боловсруулсан. Боловсруулсан Хөтөлбөрийн төслийг танилцуулах, санал авах олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжийн төлөөлөл 32 хүн оролцсон. Мөн хөтөлбөрийн төслийг яамны цахим хуудаст байршуулан санал авах ажиллагааг зохион байгууллаа. ирүүлсэн санал, зөвлөмжүүдэд үндэслэн нэмэлт өөрчлөлт оруулж боловсруулсан хөтөлбөрийн төсөлд яамдаас санал авахаар 2020.06.03-ны өдрийн 01/1512 тоот албан бичгээр хүргүүлж,ирүүлсэн саналыг нэгтгэсэн байна. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2020.06.17-ны өдрийн 01/1643 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Гэвч Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчингүй болсонтой холбоотойгоор дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг буюу үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл байхгүй болсон байна. | 100%<br>Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль 2020 онд батлагдсанаар дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг буюу үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл байхгүй болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 47 | 8 | 8 | **2019 оны 7 дугаар сарын 9-ний өдөр 30 дугаар тэмдэглэл**<br>**2019-07-09**<br>**Дугаар 2019_30**<br>XXI.3. 2. .Улсын тусгай хамгаалалтад авах газар нутагт нь ашигт малтмал хайх, ашиглах талбайтай давхцаж байгаа эсэхийг нягталж, шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжид заасан зохих арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав. | Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын 2020 оны 46 дугаар тогтоол, Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай УИХ-ын 2020 оны 47 дугаар тогтоолд хамрагдсан талбайнуудад Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай хуулийн дагуу олгогдсон тусгай зөвшөөрлийн талбайн давхцалыг шалгаж, тодруулан давхцалтай хэсгийг тогтоон холбогдох саналыг бэлтгэн Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн: | 100%<br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 48 | 9 | 9 | **2019 оны 7 дугаар сарын 24-ний өдөр 33 дугаар тэмдэглэл 2019-07-24 Дугаар 2019_33** II.. Улаанбаатар хотноо 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулсан Монгол, Канадын Дугуй ширээний уулзалтын 8 дугаар хуралдааны дүнг сайшааж, уг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд бөгөөд Дугуй ширээний уулзалтын монголын хэсгийн дарга Д.Сумъяабазарт даалгав. | Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн дагуу Монгол, Канадын дугуй ширээний уулзалтын VIII хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2019.08.07-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд баталж 2019.08.14-ний өдөр 01/2316 дугаар албан тоотоор Гадаад харилцааны яаманд хүргүүлэв. Баталсан төлөвлөгөөний хэрэгжилтэд тухай бүр хяналт тавьж тус яамтай холбогдолтой ажлын биелэлтийг 2020.11.10-ны өдрийн 04/2797 дугаар албан тоотоор Гадаад харилцааны яаманд хүргүүлэв. Засгийн газрын 2020.09.02-ны өдрийн 97 дугаар тогтоолоор тус уулзалтын Монголын хэсгийн даргаар Сангийн сайд томилогдсон болно. | 100% Тус уулзалтын Монголын хэсгийн даргаар Сангийн сайд томилогдсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 49 | 9 | 10 | III.3.. 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгов: 2.1. үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж байх; 2.2. үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлэх. | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан төсөл, арга хэмжээнд зарцуулагдах төсөв, хөрөнгийн хэмжээг зарцуулсан дүнтэй нь харьцуулан нэгтгэж жилийн эцсийн тайлангийн хамт хүргүүлж ажилласан бөгөөд зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлсэн. | 100% Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 50 | 10 | 11 | **2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2019-12-18 Дугаар 2019_55** XXIX.6. . Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”-ийг дотоодын түүхий тосоор хангах, газрын тосны нийлүүлэлтийн дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох, шаардлагатай тооцоо судалгаа хийх, техник, технологийн шийдэл, хөрөнгө оруулалтын талаар санал, дүгнэлт гаргасан Ажлын хэсгийн тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”-ийг түүхий тосоор | МУ-ын Ерөнхий сайдын 2019.09.16-ны өдрийн 118 дугаар Захирамжаар байгуулсан Ажлын хэсгийн санал дүгнэлтийг Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар дахин хэлэлцүүлж ЗГ-ын 2020 оны 01 дүгээр тэмдэглэлээр түүхий тосыг дамжуулах хоолойгоор тээвэрлэхээр шийдвэрлэсэн. | 100% Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хангах, газрын тосны нийлүүлэлтийн дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох талаар санал, дүгнэлт гаргасан Ажлын хэсгийн тайланг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн төлөөллийг байлцуулж, Засгийн газрын хуралдаанд дахин танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар даалгав. | | |
| 51 | 11 | 12 | **2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр**<br>**2 дугаар тэмдэглэл**<br>**2020-01-08**<br>**Дугаар 2020_2**<br>Х.4. . Шатахууны үнийг тогтворжуулах зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газар болон "Би Ди Өү Интернэйшнл" ХХК хооронд хамтран ажиллах саналын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан АИ-92 төрлийн шатахууны үнийг тогтворжуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэн, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт үүрэг болгов. | Энэ ажлын хүрээнд Засгийн газрын 2020 оны 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан "Эрчис Ойл" төрийн өмчит компаниар дамжуулан "АИ-92 төрлийн автобензиний үнийг тогтворжуулах" хамтын ажиллагааны гэрээ байгуулах ажлыг УУХҮЯ болон АМГТГ хамтран зохион байгуулав. Энэхүү тогтоолоор хэрэгжүүлж буй гэрээ нь эрсдэлийн сан буюу /Hedge Fund/ үүсгэн газрын тосны бүтээгдэхүүний бирж дээр санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан арилжаалах буюу урт болон богино хугацааны гэрээ хийж, үнэ болон нийлүүлэлтээ тогтмол хэмжээнд барьдаг туршлагаас үндэслэн Монгол Улсад анх удаа хийгдэж буй шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулж буй арга юм. Манай улсын хувьд иргэдийн өргөн хэрэглээний суурь бүтээгдэхүүн болох АИ-92 шатахууны үнийг тогтворжуулах нь нийт эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх бөгөөд эдийн засгийн өсөлтийг дэмжих, бусад бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хязгаарлах гол ач холбогдолтой бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн "Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна" гэсэн заалтыг хэрэгжүүлэх боломжтой болж байна. Энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс аливаа санхүүжилт шаардагдахгүй бөгөөд түгш, шатахууны импорт эрхлэгч компаниудын гадаад улстай хийсэн аливаа гэрээ хэлцэлд өөрчлөлт орохгүй эерэг талтай гэдгийг гэрээ байгуулах мэдэгдэл илгээсэн 18 аж ахуйн нэгжийн удирдлагуудад танилцуулан "Эрчис Ойл" ТӨК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Гэрээ байгуулснаар улсын хэмжээнд АИ-92 шатахууны бөөний болон жижиглэнгийн үнийг бүсчлэлээр жигд тогтоож 8 сарын хугацаанд хэрэгжүүлэн ажиллах бүрэн боломжтой юм. Засгийн газрын 2020.05.13-ны өдрийн хуралдаан УУХҮСайд Д.Сумъяабазар Бүх төрлийн шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга* хийв. | 100%<br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 52 | 12 | 13 | **2020 оны 2 дугаар сарын 12-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл** | Төслийн санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, төслийг гадаад, дотоодын эх үүсвэрээр | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | **2020-02-12**<br>**Дугаар 2020_9**<br>XYI.6. . “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Алт цэвэршүүлэх үйлдвэр барих” төслийн хэрэгжилтийн явц, шаардлагатай санхүүжилтийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Алт цэвэршүүлэх үйлдвэр барих” төслийг дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийн талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс Монгол” ХХК (П.Ганхүү) нарт даалгав. | санхүүжүүлэх боломжийн талаар санал боловсруулж Засгийн газарт танилцуулах тухай Монгол улсын Засгийн газрын 2020.02.12-ны өдрийн 9 дүгээр хуралдаанаас чиглэл авсан бөгөөд гадаад, дотоодын банкны зээлийн нөхцөл, тавигдах шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалтын нарийвчилсан шинжилгээ хийлгэж, Япон, Швейцар, Сингапурын хөрөнгө оруулалтын банкнуудтай хамтран ажиллаж байна. Япон улсын SBI групп төсөлд хөрөнгө оруулах боломтой гэдгээ илэрхийлсэн бөгөөд хөрөнгө оруулсан тохиолдолд хувь эзэмшлийн хэмжээг тодорхой болгохыг хүссэн энэ асуудлыг “Эрдэнэс Монгол” ХХК-иар дамжуулан Засгийн газрын хэрэг эрхлэх газарт уламжилсан. Монгол Улсын Засгийн 2020.06.01-ний өдрийн 212 тоот тогтоолоор ашигт малтмал хайх эрх олгогдсон ба тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2020.08.26-ны өдрийн 308 тоот шийдвэрээр Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумдын нутагт орших Хүрэнцав нэртэй 1704.51 гектар талбай /XV-021666/, Мухар хар толгой нэртэй 4313.57 гектар талбай /XV-021667/, Довжоот нэртэй 1393.37 гектар талбай /XV-021668/, Халзан нэртэй 453.89 гектар талбай /XV-021669/ нийт 7865.34 гектар талбай бүхий 4 талбайн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг “Эрдэнэс алт ресурс” ХХК-д компанид олгосон бөгөөд дээрх хайгуулын тусгай зөвшөөрлийг эргэлтэд оруулах замаар төслийн хөрөнгө оруулалтын зарим хэсгийг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэхээр ажиллаж байна. | Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 53 | 13 | 14 | **2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 22 дугаар тэмдэглэл**<br>**2020-04-01**<br>**Дугаар 2020_22**<br>XYIII.2.2. Дараах арга хэмжээ авахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав:<br>2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах;<br>2.2. Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнах;<br>2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, тендерийн явцын мэдээг сар бүр Шилэн дансанд байршуулж худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллаж байна. Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тухай бүрд нь байршуулж байна. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээг байгуулж, хүчинтэй хугацааг нэг ч удаа сунгуулаагүй ба гэрээний хэрэгжилтэд хяналтыг тавьж, акт үйлдэн санхүүжилтийг олгож байна. 2020 онд гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгж байхгүй байна. | 100%<br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг тус хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр Сангийн яаманд хүргүүлэх; 2.4. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа захиалагч бусдад давуу байдал олгох, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн, гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавихгүй байх, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар, эцсийн үр дүнд үндэслэн боловсруулах. | | |
| 54 | 14 | 15 | **2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр 26 дугаар тэмдэглэл**<br>**2020-04-22**<br>**Дугаар 2020_26**<br>ҮII.. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгох;<br>2. Дулааны тоолуур худалдан авах, суурилуулахад шаардагдах хөрөнгийг төсөвт байгууллагын зарлагын хэмнэлт, давсан орлогоос холбогдох хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлэхийг Төсвийн захирагч нарт зөвшөөрөх; | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаа явуулж буй байр, Уул уурхай, газрын тосны төв лаборатори нь 2019 онд цахилгаан хэмжих тоолуурыг тавиулсан бөгөөд тоолуур тавигдаагүй байр байхгүй болно.. | 100%<br>Холбогдох нөхцөлийг бүрдүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 55 | 15 | 16 | **2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 27 дугаар тэмдэглэл**<br>**2020-04-27**<br>**Дугаар 2020_27**<br>4. . "Эрдэнэс Тавантолгой Майнинг" ХХК-д шилжүүлсэн Цанхийн зүүн хэсгийн МҮ-011943 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийг | МV-011943 тоот тусгай зөвшөөрлийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д буцаан шилжүүлснийг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2020 оны 6 дугаар сарын 11-ний 202 дугаар шийдвэрээр Кадастрын хэлтсийн мэдээллийн санд бүртгэсэн. | 100%<br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д буцаан шилжүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт; | | ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 56 | 16 | 17 | **2020 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр 28 дугээр тэмдэглэл**<br>**2020-04-29**<br>**Дугаар 2020_28**<br>IX.3. . Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгах. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны албан хаагчдад улирал бүр холбогдох журмын дагуу урамшуулал олгосон. 2020 онд нийт 2 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарч нуг удаагийн буцалтгүй тусламжийн хуулийн дагуу олгосон. | 100%<br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 57 | 17 | 18 | **2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 37 дүгээр тэмдэглэл**<br>**2020-06-23**<br>**Дугаар 2020_37**<br>IY.. Бүтээгдэхүүн хуваах гэрээ цуцлах эрх олгох тухай асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов. 2. "Ди Дабль Юү Эм Петролеум АГ" ХХК-тай "Цагаан-Элс XIII", "Зүүнбаян XIY" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ", "Сансарын геологи хайгуул" ХХК-тай "Төхөм Х хойд", "Цайдам XXYI" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-г цуцлах ажлыг зохион байгуулж, тэдгээр компанийн Газрын тосны тухай хуулийн 13.1.3-д заасан татвар, төлбөр, хураамжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-г цуцлахтай холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавьж, уг талбайд зарцуулсан хөрөнгийн тооцооллыг нягтлан шалгаж, зохих арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Газрын тосны газар болон "Ди Дабль Юү Эм Петролеум АГ" ХХК-тай "Цагаан-Элс XIII", "Зүүнбаян XIY" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ", "Сансарын геологи хайгуул" ХХК-тай "Төхөм Х хойд", "Цайдам XXYI" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ", "Импайр газ Монголиа ХХК-тай "Борзон YII" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-г цуцлах тухай асуудлыг ЗГ-ын 2020.06.23-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэн 232 тоот тогтоолыг гаргуулсан. Уг тогтоолтой холбогдуулан холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар АМГТГ-ын даргын 2020.08.25-ны өдрийн А/85 тоот тушаалыг гарган ажиллаж байна. | 100%<br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 58 | 17 | 19 | IY.3. . "Импайр газ Монголиа ХХК-тай "Борзон YII" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-г цуцлах ажлыг зохион байгуулахыг | Газрын тосны газар болон "Ди Дабль Юү Эм Петролеум АГ" ХХК-тай "Цагаан-Элс XIII", "Зүүнбаян XIY" талбайд байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ", "Сансарын геологи хайгуул" ХХК- | 100%<br>Тэмдэглэлийн дагуу холбогдох арга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, тус “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г цуцлахтай холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, уг талбайд зарцуулсан хөрөнгийн тооцооллыг нягтлан шалгахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, татан буулгалтын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат нарт тус тус даалгав. | тай “Төхөм X хойд”, “Цайдам XXYI” талбайд байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”, “Импайр газ Монголиа ХХК-тай “Борзон YII” талбайд байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-г цуцлах тухай асуудлыг ЗГ-ын 2020.06.23-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэн 232 тоот тогтоолыг гаргуулсан. Уг тогтоолтой холбогдуулан холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар АМГТГ-ын даргын 2020.08.25-ны өдрийн А/85 тоот тушаалыг гарган ажиллаж байна. | хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 59 | 17 | 20 | YI.2. . Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжүүлж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1) гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалттай холбоотой асуудлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажлын сонгон шалгаруулалтад оролцогчийн санхүүгийн саналыг тус үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан дүнд багтаах хэлцэл хийж танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ын ерөнхий гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулж, хэлэлцээ хийж дууссан тухай танилцуулгыг 2020-08-05 өдрийн хуралдаанд танилцуулж 43 дугаар тэмдэглэл гаргуулсан. | 100% Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 60 | 17 | 21 | YI.5. . Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж, түүнтэй хэлэлцээ хийж дууссан талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй | Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил (EPC-1)-ын ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан БНЭУ-ын “JMC Projects (India) Ltd” компанитай 2020.10.13-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. | 100% Тэмдэглэлийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажлыг сонгон шалгаруулалтын нөхцөл, хэлэлцээний үр дүн, зайлшгүй шаардлагатай бусад шаардлагыг харгалзан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гэрээ байгуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нарт даалгав. | | |
| з. Засгийн газрын албан даалгавар – 1/2 | | | | | |
| 61 | 1 | 1 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>**2020-11-19**<br>**Дугаар 2020_2**<br>1. Дор дурьдсан арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 1.1. Салбар болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний төслийг хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх; | Эрдэс баялгийн салбарын хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний төслийг хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж Төрийн нарийн бичгийн даргын 2020.12.25-ны өдрийн 03/3218 албан тоотоор ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100%<br>Албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| 62 | 1 | 2 | 1.2. Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд нэгтгэх болон цаашид иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг үйлчилгээний жагсаалтын хамт боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлэх; | Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж “e-Mongolia” цонхонд нэгтгэх ажлуудын санал боловсруулж Харилцаа холбоо мэдээллийн технологийн газарт Төрийн нарийн бичгийн даргын 2020.12.24-ний өдрийн 03/3205 албан тоотоор хүргүүлсэн. | 100%<br>Албан даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. |
| Нийт ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ 47 шийдвэрийн 62 зүйл, заалт | | | | | |